



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 10 дүгээр сарын 24-ний өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-9</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>10-96</i>

1. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/	12-34
2. Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/	34-39
3. Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал	39-40
4. Засгийн газрын гишүүнийг томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсох	41-86
5. Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолын ажиллагаа	86-87
6. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн санал хураалт	87-88
7. “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн санал хураалт	88
8. Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай	88-95
9. Баталсан тогтоолын эцсийн найруулгыг сонсох	95-96

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
10 дугаар сарын 24-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 91 гишүүн хүрэлцэн ирж, 72.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 32 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Ж.Галбадрах, Т.Доржханд, Д.Жаргалсайхан, Ж.Золжаргал, Ч.Лодойсамбуу, Б.Мөнхсоёл, С.Цэнгүүн, М.Энхцэцэг;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, М.Нарантуяа-Нара;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Ч.Анар, Х.Булгантуяа, Ж.Ганбаатар, Б.Дэлгэрсайхан, Б.Жавхлан, Б.Тулга, А.Ундраа;

Тасалсан: С.Амарсайхан, Х.Баттулга, Ж.Баярмаа, Ц.Мөнхбат, Л.Оюун-Эрдэнэ;

Хоцорсон: Х.Баасанжаргал-05 минут, Б.Батцэцэг-05 минут, Г.Ганбаатар-34 минут, Л.Гантөмөр-15 минут, М.Ганхүлэг-25 минут, Ц.Даваасүрэн-57 минут, Г.Лувсанжамц-05 минут, О.Номинчимэг-1 цаг 26 минут, Э.Одбаяр-02 минут, Д.Цогтбаатар-13 минут, Р.Эрдэнэбүрэн-31 минут.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдоржийн тавьсан асуултад Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж хариулав.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж хэлэлцэх асуудлын дараалалд Засгийн газрын гишүүнийг танилцуулах тухай асуудлыг нэмэх горимын санал гаргав.

Горимын саналтай холбогдуулан Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдоржийн тавьсан асуултад Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж хариулав.

Б.Пүрэвдорж: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 44

Бүгд: 95

53.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж горимын санал дэмжигдсэн тул дээрх асуудлыг хэлэлцэх асуудлын 4 дүгээрт хэлэлцэх горимын санал гаргав.

Б.Пүрэвдорж: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 41

Бүгд: 95

56.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул хэлэлцэх асуудлын дараалалд Засгийн газрын гишүүнийг танилцуулах асуудлыг нэмж, хэлэлцэх асуудлын 4 дүгээрт хэлэлцэхээр тогтов.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга М.Энх-Амгалан, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Т.Баясгалан, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, мөн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ-ын захирал М.Амгаланбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Р.Тэгшжаргал нар байлцав.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудал Улсын Их Хурлын гишүүдийн асуулт, хариултаар үргэлжлэв.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Бямбацогт, Х.Баасанжаргал, Ж.Энхбаяр, П.Сайнзориг, Ч.Номин, О.Саранчулуун, Б.Түвшин, Р.Сэддорж, Б.Жаргалан, Х.Баасанжаргал, Б.Пунсалмаа нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./12:08/

Хоёр.Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав

Төслийн гурав дахь хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодоос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагад нийцсэн эсэх талаарх дүгнэлтийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдоржийн тавьсан асуултад Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж хариулав.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага хангахгүй байгаа тул Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодод хоёр дахь хэлэлцүүлгийг дахин явуулахаар буцаав.

Уг асуудлыг 12 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Тогтоолын төслийг Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./12:26/

Үдээс өмнөх хуралдаан 1 цаг 54 минут үргэлжилж, 12 цаг 26 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 03 минутад эхлэв.

Дөрөв.Засгийн газрын гишүүнийг томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүнд нэр дэвшигч Б.Энхбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүй, дотоод хэргийн сайдад нэр дэвшигч Баттөмөрийн Энхбаярыг томилох тухай саналыг Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар танилцуулав.

Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулга болон нэр дэвшигчээс Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Д.Бум-Очир, Ж.Батсуурь, Д.Энхтүвшин, А.Ариунзаяа, Да.Цогтбаатар, Ц.Баатархүү, Л.Энхнасан, Ц.Сандаг-Очир, С.Эрдэнэболд, Г.Уянгахишиг, С.Одонтуяа, Д.Ганбат, А.Ганбаатар, Р.Эрдэнэбүрэн, Б.Бейсен, Д.Батлут нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, нэр дэвшигч Б.Энхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Б.Хэрлэн нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Засгийн газрын гишүүнийг томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонслоо.

Уг асуудлыг 16 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаан Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолын ажиллагааны бэлтгэлийн дараа үргэлжлүүлэн хуралдахаар 16 цаг 59 минутаас 17 цаг 21 минутад завсарлав.

Тав.Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолын ажиллагаа

Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагаатай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүнд нэр дэвшигч Б.Энхбаяр нар байлцав.

“Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжийг Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар танилцуулав.

Ёслолын ажиллагааг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Төрийн ёслолын газрын дарга Э.Одмөнх, мөн газрын шинжээч Б.Мөнхтүшиг, мэргэжилтэн Б.Билгүүндалай, Ч.Цолмон, ажилтан Г.Анар, Б.Анхцэцэг, Э.Рагчаадорж нар зохион байгуулав.

Танхимын баруун хойд, зүүн хойд болон урд дэлгэцэн дээр “МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН БИ УЛСЫН АШИГ СНИРХЛЫГ ЭРХЭМЛЭН, ТӨРТ

ЁС, ТҮҮХ, СОЁЛЫНХОО УЛАМЖЛАЛЫГ ХҮНДЭТГЭЖ, МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙГ ДЭЭДЛЭН САХИЖ, АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС АНГИД БАЙЖ, ТӨРИЙН ХУУЛЬ БИЕЛҮҮЛЭХ АЖЛЫГ ТӨР, АРД ТҮМЭН, МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ӨМНӨ БИЕЧЛЭН ХАРИУЦАЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮНИЙ ҮҮРГЭЭ ЧИН ШУДАРГААР БИЕЛҮҮЛЭХЭЭ ТАНГАРАГЛАЯ. МИНИЙ БИЕ ЭНЭ ТАНГАРГААСАА НЯЦВАЛ ХУУЛИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭНЭ.” гэсэн Засгийн газрын гишүүний тангаргийн үг гарч байв.

“Их хуралдай” танхимын индрийн баруун талд Төрийн далбаа, танхимын голд Үндсэн хууль, тангаргийн бичиг, үзэг тавьж тусгайлан бэлтгэсэн ширээг сандлын хамт Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолд зориулан бэлтгэн байрлуулж, Төрийн сүлдний баруун талд хүндэт харуул зогссон байлаа.

Монгол Улсын Засгийн газрын гишүүний тангараг өргөх журмын дагуу тангараг өргөх ёслолын ажиллагаа эхлэв.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүй, дотоод хэргийн сайдад нэр дэвшигч Баттөмөрийн Энхбаяр тангаргийг уншив.

Тангараг өргөсний дараа Засгийн газрын гишүүн Төрийн сүлдэнд мэхийн ёсолж, Төрийн далбааны өмнө баруун өвдөг мэхийн сууж адис аван, “Их хуралдай” танхимын голд байрлуулсан ширээнд сууж, тангаргийн бичигт гарын үсэг зурж, Улсын Их Хурлын дэд даргад тангаргийн бичгээ гардуулсны дараа Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулав.

Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар Засгийн газрын гишүүнд үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулж дууссаны дараа Монгол Улсын Төрийн дууллыг “Их хуралдай” танхимд эгшиглүүлэхэд хуралдаанд оролцогсод суудлаасаа босож хүндэтгэл үзүүлэв.

Тангараг өргөх ёслолын ажиллагаа 17 цаг 28 минутад өндөрлөв.

Хуралдаан Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн санал хураалтаар үргэлжлэв.

Б.Пүрэвдорж: Байнгын хорооны саналаар Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	54
Татгалзсан:	45
Бүгд:	99
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.	

Улсын Их Хурлын гишүүн С.Замира, Б.Хэрлэн нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 56.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	59
Татгалзсан:	40
Бүгд:	99

59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	56
Татгалзсан:	43
Бүгд:	99

56.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.“Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	58
Татгалзсан:	41
Бүгд:	99

58.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн болон Төсвийн байнгын хороодод шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн санал хураалтыг явуулав.

Б.Пүрэвдорж: “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	44
Татгалзсан:	55
Бүгд:	99

44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 44
Бүгд: 99
55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Пүрэвдорж: Горимын санал дэмжигдсэн тул дээрх батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 40
Бүгд: 99
59.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /17:41/

Уг асуудлыг 17 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай саналыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг танилцуулав.

Санал болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Д.Ганбат нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар нар хариулж, тайлбар хийв.

Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл ажлын 3 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж ажлын 3 өдрийн завсарлага өгөв./18:07/

Уг асуудлыг 18 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Баталсан тогтоолын эцсийн найруулгыг сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж баталсан тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /18:08/

2.“Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /18:09/

Уг асуудлыг 18 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 39 минут үргэлжилж, 126 гишүүнээс 102 гишүүн хүрэлцэн ирж, 81.0 хувийн ирцтэйгээр 18 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 32 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Пүрэвдорж: Өнөөдрийн мэндийг та бүхэндээ хүргэе. Их Хурлын гишүүдийн ирц 126-аас 91 болж, 72,2 хувьтайгаар өнөөдрийн чуулганы ирц бүрдсэн байна. Чуулган эхэлснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 5 асуудлыг хэлэлцэнэ.

Тэгэхээр энэ хуралдааныг өнөөдөр даргалах асуудлыг Булгантуяа дарга өчигдөр орой болон өнөөдөр өглөө над руу ярьж мэдэгдсэн байгаа. Тэгээд энэ талаар тодорхой тайлбарыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Баасандорж танилцуулна. Индрийн 1 номер.

Б.Баасандорж: Улсын Их Хурлын дэд дарга, гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Улсын Их Хурлын дараагийн даргыг сонгох хүртэл Улсын Их Хурлын дэд дарга Булгантуяа дарга Улсын Их Хурлын тогтоолоор заасны дагуу Улсын Их Хурлын даргын бүрэн эрхийг хэрэгжүүлж байгаа. Тэгээд өчигдөр Улсын Их Хурлын даргын үүргийг гүйцэтгэж байгаа Булгантуяа дарга болон Пүрэвдорж дарга нар холбогдсон байсан. Тэгээд манай Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйл дээр Улсын Их Хурлын дэд даргыг сонгох, чөлөөлөх гэсэн Улсын Их Хурлын дэд даргын бүрэн эрх, эрх, үүргийг зааж өгсөн байдаг. Энэ хуулийн 14.4-т Улсын Их Хурлын дэд дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

14.4.3.Улсын Их Хурлын даргаас хуваарилсан болон даалгасан чиг үүрэг гэж байгаа. Тэгэхээр Улсын Их Хурлын дэд дарга Пүрэвдорж дэд дарга бол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааныг даргалах энэ хуулийнхаа дагуу бүрэн боломжтой гэсэн тодруулгыг та бүхэндээ хэлье.

Б.Пүрэвдорж: Дэг байхгүй. Өнөөдрийн хуралдаанаар дараах 5 асуудлыг хэлэлцэнэ.

1 дүгээрт Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх, эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

2 дугаарт нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дахь хэлэлцүүлгийг явуулна.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэнэ.

4 дүгээрт нь Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг хэлэлцэнэ.

5 дугаарт Баталсан тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Энэ хэлэлцэх асуудал дээрээ холбоотойгоор бас тодруулах, 1 асуудлыг нэмэх саналтай байна.

Засгийн газрын гишүүнийг танилцуулах тухай асуудлыг оруулах саналтай байна. Энэ дээр Баасандорж дарга 2, 3 асуултад хариулмаар байна.

1 дүгээрт нь яс Засгийн газрын гишүүнийг танилцуулах тухай асуудал урьд нь хэдэн удаа хэлэлцэх асуудлын дараалалд орсон бэ. Индрийн 1 номер.

Б.Баасандорж: Пүрэвдорж дэд даргын асуултад хариулъя. Монгол Улсын Ерөнхий сайдаас ирүүлсэн Засгийн газрын гишүүнийг огцруулах, томилох тухай асуудал өмнөх чуулганы тов дарааллын 2 удаагийн тов дараалалд орсон байгаа. Тухайлбал, өнгөрсөн 7 хоногийн тов дарааллын 5 дахь өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны тов дараалалд байсан.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр энэ асуудал бол урьд нь даргын зөвлөлийн хурлаар дэмжигдэж, хэлэлцэгдэж байсан гэсэн үг. Тийм ээ. 1 номер.

Б.Баасандорж: Өнгөрсөн 2 удаагийн тов дараалал дээр даргын зөвлөлийн хурал дээр танилцуулагдаад, тов дараалалд бол даргын дэргэдэх зөвлөлийн олонхын саналаараа асуудлаа шийдээд, тов дарааллаа баталдаг. Тэрний дагуу дэмжигдсэн байгаа.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр энэ даргын зөвлөлийн хурлаар хэд хэдэн удаа дэмжигдэж, хэлэлцэх асуудал нь тодорхойгүй шалтгаанаар хойшлогдсон ийм асуудал байгаа. Тэгэхээр энэ хэлэлцэх асуудлын 6 дээр Засгийн газрын гишүүнийг танилцуулах тухай асуудлыг оруулж байна.

Энэ дээр Их Хурлын гишүүд саналаа өгч, энэ асуудлыг шийдвэрлэхийг хүсэж байна. Санал хураалт. Санал хураалтад бэлтгээрэй. Одоогийн байдлаар 61 гишүүн ирцэд орсон байна. Санал хураалт. Ирцийн санал хураалт явуулъя.

Баасанжаргал гишүүнээ, урд өдрийн 17 цагаас өмнө та горимын саналаа бүлгийн даргаараа дамжуулж өгөх ёстой. Тэгэхээр өнгөрсөн. Тийм учраас өчигдөр, уржигдар гарсан Цэцийн дүгнэлт. Тэгэхээр өнөөдрийн асуудал байхгүй. Тийм учраас үүнтэй холбоотой үг хэлэх боломжгүй гэдгийг хэлье.

Санал хураалт. Хэлэлцэх асуудлын 6 дугаарт Засгийн газрын гишүүнийг танилцуулах асуудал 95 гишүүнээс 51 гишүүн дэмжиж, 53,7 хувиар дэмжигдлээ.

Би түрүүн үргэлжлүүлээд явж байсан. Томьёоллоо хэлчихсэн байгаа. Дахиад тэгвэл хураалгачихъя.

Засгийн газрын гишүүнийг танилцуулах асуудлыг хэлэлцэх асуудлын 4 дээр оруулахаар санал гаргаж байна. Энэ саналыг санал хураалтаар шийдье. Санал хураалт. Нийт 95 гишүүн хурлын ирцэд бүртгэгдсэнээс 54 буюу 56,8 хувиар энэ санал дэмжигдлээ.

Хэлэлцэх асуудалдаа орёе.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор 2025 оны 10 сарын 17-ны өдөр Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг ажлын 3 өдрийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна.

Бүлгийн дарга үүнтэй холбоотой үг хэлэх үү. Үг хэлэхгүй юм байна. Одоо Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал дүгнэлт, хууль санаачлагчдын илтгэл, хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлага, хуулийн төслийн үр нөлөө, зардлын тооцоо болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаг гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу үргэлжлүүлэн асуулт асууж, хариулт авна. Мандхай гишүүн асуултаас татгалзаж байгаа юм байна. Дараагийнх нь Энхтүвшин. Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин алга байна. Энэ дээр нэр нь гараад байгаа. Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа асуулт асууна.

А.Ариунзаяа: Дагасан хууль. Пүрэвдорж гишүүн ээ, уг нь би Цэцийн дүгнэлтийг авч үзээд, бидний өмнө нь хэлэлцэж эхэлсэн 17-ны чуулганыг бүхэлд нь хүчингүй болгочихсон юм шиг дүгнэлт гаргачихсан байгаа байхгүй юу. Энийг уг нь тодруулж асуух гэсэн та ердөөсөө боломж өгөхгүй юм. Тэгээд энэ хардаа 16, 17-ны ирцийг нэгтгэсэн нь хууль зөрчсөн байна. Ирцэд орчхоод саналаа өгөөгүй хүмүүсийн санал нь Үндсэн хууль зөрчсөн байна гэдэг асуудлыг Үндсэн хуулийн цэц дүгнэчихсэн учраас бид нар яаж чуулгандаа оролцохоо ч мэдэхгүй ийм сонин нөхцөл байдалд орчхоод байгаа байхгүй юу. Бусад ардчилсан улсад ирцэд орсон ч санал өгөөгүй гишүүний эсрэг санал өгсөнд тооцдог практик тогтоогдоогүй байна гээд ардчилсан улс мөн ч юм уу, биш ч юм уу ийм дүгнэлтийг Үндсэн хуулийн цэц өгчхөөд байгаа учраас одоо энэ санал хураалт дээр ирцдээ орчхоод гараад явчихсан гишүүд Үндсэн хуулиа зөрчсөн ийм асуудал дэгдээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг яаж зохицуулах ёстой юм бэ. Энийг ердөөсөө ойлгохгүй байгаад байна. Уг нь даргын дэргэдэх зөвлөл энийгээ яримаар байгаа байхгүй юу. Бид нар аливаа асуудлыг хэлэлцэхээсээ өмнө бид нар дэгийн энэ асуудлуудаа тодорхой болгомоор байна. Ирцдээ орчхоод гарсан хүмүүсийг яах юм. Тэгээд даргын дэргэдэх зөвлөлийн гишүүд энийгээ тодорхой болгохгүй бол бид өнөөдөр гараад явж байгаа хүмүүс Үндсэн хууль зөрчсөнд тооцогдоод байна шүү дээ.

Тэгээд та нарын энэ Энхбаярыг сайдаар томилох асуудал чинь 1 байдаг юм байгаа биз. Энэ Үндсэн хуулийн зарчим тэнд Үндсэн хуулиараа олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэх юм уу, үгүй юм уу энэ гишүүд чинь. Чуулган хүчинтэй байх юм уу, үгүй юм уу гэдгийгээ ярьдаггүй юм уу. Ганцхан хоног тэсчихнэ л биз дээ. Юу нь тийм хэцүү үнэхээр шууд яаралтай байгаа юм. Сайдаар томилогдохгүй л болохгүй үхчих гээд байгаа юм бэ. Үндсэн хуулийн цэцээр дүгнэгдчихсэн байгаа энэ асуудлыг саналаа бид нар яаж өгөх юм бэ. 17-ны чуулган ер нь бүхэлдээ хүчинтэй юм уу, хүчингүй юм уу гэдгийгээ ярьж байж энэ асуудлуудаа хэлэлцэхгүй юм уу.

Дагасан хууль дээр урт хугацааны гэрээ байгуулж, биржийн үнээр нүүрсээ борлуулахгүй байх энэ тогтоол орж ирж байгаа нь дахиад эргээд хүний гараар могой барьсан асуудал мөн шүү дээ. Хэзээ нэгэн цагт оффтейк гэрээ байгуулчихсан байна. Ийм үнээр гэрээ хийсэн байна гэдэг асуудал дахиад л гарч ирнэ шүү дээ. Тэр

үед нь Засгийн газар юу гэж хариулах вэ гэхээр Улсын Их Хурлаас баталж өгсөн тогтоол шүү дээ гэж ярина. Дахиад л ийм асуудал орж ирж байгаагаа гишүүд маань мэдэж байна уу, үгүй юу.

Пүрэвдорж дарга аа, даргын дэргэдэх зөвлөл энэ асуудлаа шийдэж өгөөч ээ. Чуулган хүчинтэй юм уу, хүчингүй юм уу. Ирцэд ороод гарсан гишүүд татгалзах эрх нь байгаа шүү дээ. Татгалзах эрх нь байгаа учраас чуулганы санал хураалтад нь орохгүй гарч байгаа байхгүй юу. Яагаад гэвэл Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиараа би танхимд өөрийн биеэрээ байж санал өгөөгүй ч гэсэн ирцэд ороод гарсан байгаа бол миний санал татгалзсанаар авна. Тэгээд яагаад бичигдсэн хуулиа мөрдсөнийхөө төлөө Үндсэн хууль зөрчсөн болчхов. Тэгээд урьд өмнөх бүх шийдвэрүүд нь яах юм болж байна. Тэгээд энийг даргын дэргэдэх зөвлөлд хэлэлцэж ярьж өгөөч.

Хамтын шийдвэр гаргачхаад зөвхөн Булгантуяа дээр л энэ үүргийг нь хариуцуулж болохгүй шүү дээ. Улсын Их Хурал бол хамтын шийдвэр гаргадаг. Энэ 16, 17-ны ер нь энэ чуулган хүчинтэй юм уу, хүчингүй юм уу. Ирцэд орчхоод гарсан гишүүд, ирцэд орчхоод саналаа өгөөгүй гишүүд Үндсэн хууль зөрчсөн болж байна уу. Энийгээ шийдвэрлэж өгч байж энэ чуулганы үйл ажиллагаа .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Ариунзаяа гишүүний саналыг хүндэтгэж байна. Үндсэн хуулийн цэц тэр өдрийн хуралдааныг хүчингүй гэж тооцсон. Тийм учраас энэ тухайн өдөр хэлэлцэж байсан эхний 3 асуудал буюу хэлэлцэх асуудлын нэгдүгээрх нь Мөнгөний бодлого энэ тэр бол аль хэдийн батлагдаад явчихсан. Тэгэхдээ тэрийг бид нар дахиж тэр өдөр болсон. Харин тийм учраас тэрийг дахиж даргын зөвлөл дээр бас хэлэлцэж, буцааж оруулж ярилцах асуудал гарч ирнэ гэсэн үг. Тэгэхээр ер нь бол энэ эхний 3 асуудал буюу Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, 2 дахь асуудал буюу 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл зэрэг энэ асуудлууд бол тухайн өдөр хэлэлцэгдэж явж байсан. Тийм учраас энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гарсантай холбоотойгоор энэ өдөр хэлэлцэгдсэн өөрөөр хэлбэл завсарлага аваад явж байна гэдэг чинь бас хэлэлцэгдсэн гэсэн үг. Тэгэхээр энэ асуудлууд чинь бүгдээрээ цэцийн дүгнэлтээр тухайн өдрийн хуралдаан хүчингүй гэж тооцогдсон учраас энэ асуудлыг Ариунзаяа гишүүний саналын дагуу даргын зөвлөлөөр дахин хэлэлцэж оруулж ирэх ийм асуудлыг ярина. Тийм учраас эхний 3 асуудлуудыг хойшлуулъя гэсэн ийм горимын санал гаргаж байна. Даргын зөвлөлөөр хэлэлцэхээр. Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. Тэгэхээр энэ хэлэлцэж байсан асуудал. Үндсэн хуулийн цэцэд Монгол Улсын Ерөнхий сайд Улсын Их Хурлын дэд дарга Булгантуяа хуралдааны үйл ажиллагааг удирдахдаа Үндсэн хууль зөрчлөө. Дээрээс нь Улсын Их Хурлын Ерөнхий сайдыг огцруулсан 95 дугаар тогтоол Үндсэн хууль зөрчсөн байна. Энийг шалгаж өгөөч, нягталж өгөөч ээ гэж хүсэлт гаргасан. Үндсэн хуулийн цэц ч гэсэн яг энэ асуудлыг энэ 2 асуудлаар хоёулаа Үндсэн хууль зөрчсөн байна гэсэн дүгнэлт гаргасан. Бусад асуудлууд дээр ямар нэгэн Үндсэн хууль зөрчсөн гэсэн маргаан үүсээгүй, ямар нэгэн шийдвэр гараагүй. Тийм байхад бол энэ асуудлуудаа бид хэлэлцээд цаашаа явах ёстой. Тийм болохоор юу гэдэг юм Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гараагүй байхад явж байсан процесс явж байгаагаараа явж байх ёстой. Харин тэрэнтэй холбоогүй асуудлыг бүхэлдээ тэр өдрийн хуралдаан хүчингүй юм шиг хойшлуулж болохгүй. Тийм болохоор энэ төсвийн хэлэлцүүлгээ хийгээд явъя. Төсвөө баталмаар байна.

11 сарын 15 дөхөж байна. 9 сарын 1-нд өргөн барьсан. Одоо үндсэндээ 50 хонож байна Улсын Их Хурал дээр. Одоо 11 сарын 15 хүртэл богинохон хугацаа үлдэж байна. Тийм болохоор энэ асуудлыг битгий хойшлуулаач ээ. Хэлэлцүүлээд цааш нь явъя. Энэ бол Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй огт хамаагүй асуудал учраас энийг цааш нь хэлэлцээд явахад ямар нэгэн хууль зөрчихгүй. Хууль зөрчихгүй. Төсвөө хурдан хэлэлцэж баталъя.

Б.Пүрэвдорж: Баасанжаргал гишүүн бас хариулчих.

Х.Баасанжаргал: Тэгээд би горимын саналтай холбоотой санал хэлж байгаа гэдгээ тэмдэглүүлье.

2 дугаарт Бямбацогт сайд өөрөө хэдийгээр сая ингэж тайлбарлаж байгаа боловч Үндсэн хуулийн цэцэд гаргасан Засгийн газрын хүсэлтэд өнөөдрийн энэ маргаан бүхий ирцийн асуудлыг 1 үндэслэлээ болгож өгсөн.

2 дугаарт Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн 35 дугаар хуудсанд 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн ирцийн бүртгэлд орсон гишүүд, мөн 10 сарын 17-ны ирцийн бүртгэлд болон санал хураалтад оролцоогүй байхад Ерөнхий сайдыг огцруулахыг дэмжих санал өгсөнд тооцогдсон байна.

Мөн 3 дахь параграф бусад ардчилсан улсад ирцэд орсон санал өгөөгүй гишүүнийг эсрэг санал өгсөнд тооцдог практик тогтоогдохгүй байна.

4 дэх параграф иймд Улсын Их Хурлын 2025 оны 10 дугаар сарын 16, 17-ны өдөр буюу 2 өдрийн ирцийг нэгтгэн тооцсон нь Үндсэн хуулийн 27 дугаар зүйлийн 6, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн хуралдааны тухай хуулийн 6.2 дахь хэсгийг зөрчсөнөөр Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх зарчмыг алдагдуулсан байна гээд ирцтэй холбоотой дүгнэлтийг Үндсэн хуулийн цэц бүхэлд нь хийсэн байна. Тийм учраас энд бид нар даргын дэргэдэх зөвлөл дээр 2 асуудлыг маш тодорхой шийдэх хэрэгтэй байна. 16, 17-ны өдрийн хуралдаан үндсэндээ хүчингүй болсон учраас буцаад тэр өдрүүдэд шийдсэн асуудлуудыг дахин шийдвэрлэх.

2 дугаарт цаашид энд бас маш том ноцтой үр дагаврыг Үндсэн хуулийн цэц шийдчихээд байгаа. Ирцдээ орсон хэр нь санал өгөөгүй гарч явсан бол энийг саналд тооцохгүй гээд. Тэгэхээр энэ асуудлыг бас шийдэх хэрэгтэй. Тэгээд цаашид ер нь Дэгийн тухай хуультай холбоотой асуудлууд энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбоотой гарч ирж байна гэсэн үг. Тэгэхээр энэ дээр бол даргын дэргэдэх зөвлөл энэ 2 асуудал дээр маш нухацтай хандах хэрэгтэй. Тэгээд нэгэнт Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт эцсийнх байна. Энийг хэлэлцэхгүй гээд дүгнэлтийнхээ хэсэг дээр яг эдгээр дүгнэлтүүдийг хийчихсэн байна.

Б.Пүрэвдорж: 3 минут. Ж.Энхбаяр гишүүн.

Ж.Энхбаяр: Эрхэм гишүүд ээ, улсын төсөв батлах нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх бөгөөд бүрэн бас хариуцлагатай ийм ажил, үүрэг. Энийг ямарваа нэгэн асуудалтай хольж тайлбарлаж, хойшлуулах ийм санал байж болохгүй буюу зохисгүй.

2 дугаарт Их Хурал хэлэлцэх асуудлаа баталчихсан. Энэ хүрээнд Их Хурлыг удирдаж байгаа дэд дарга та дэг сахиулах ёстой. Цэцийн асуудал дээд хуралдаанаараа эцсийн шийдээ гаргасан. Цэцийн шийдвэрийг энд хэн нэгэн тайлбарлах эрхгүй. Ингээд хуралдаанаа явуулаад, нийгэм, эдийн засгийн тулгамдсан олон асуудал байна. Төсвийнхөө батлах асуудлуудаа үндсэн үүргээ бид Их Хурал биелүүлэх ёстой. Энэ бидний 1 талдаа хариуцлагын асуудал, нөгөө талаар онцгой бүрэн эрхийн асуудал. Үндсэн хуульд заасан төсвийн асуудал. Төсөв ямар нэгэн саадгүйгээр урагшлах учиртай.

Б.Пүрэвдорж: Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Баярлалаа. Тэгээд би бас Пүрэвдорж даргатай адилхан саналтай байгаа юм. Энэ асуудлыг даргын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцээд, дахин тэр санал хураалтуудыг хийхийг нь хийгээд, шаардлагатай бол энэ асуудлыг шийдэх 1 удаагийн дэг гаргаж ирэх ёстой. Ерөнхийдөө Ерөнхий сайдыг огцруулах эсэх асуудал дээр гарсан тогтоолыг хэлэлцэхдээ цэц маш том зарчмын шинжтэй санал өгөх болон ирцтэй холбоотойгоор маш том зарчим тогтоочихлоо. Энэ асуудлыг бид нар эцэслэн шийдэхгүйгээр дараа дараагийн Улсын Их Хурлын бүх үйл ажиллагаа явахгүй болчихлоо. Өөрөөр хэлэх юм бол хэдийгээр тэр тогтоол Үндсэн хуульд нийцээгүй гэж дүгнэж байгаа боловч зарчмын хувьд ер нь танхимд сууж саналаа өгөөгүй нь ирцэд ч юм уу, санал өгсөнд тооцохгүй шүү гээд нийтлэг байдлаар тогтоочхож байгаа байхгүй юу. Тэгэхээр бид хэд энэ асуудлыг цаашдаа шийдэх ёстой юм.

2 дугаарт Ерөнхийлөгчийн хориг бас энэ асуудлыг тавьсан. Бүхэл бүтэн 2 институт нь ирцгүй чуулган болсон шүү гэдэг зүйлийг хэлээд байхад бид хэд ингэж урагшилж болохгүй. Тэгэхээр Дэгийн хууль энэ тэрээ янзлаад, энэ асуудлаа шийдэх ёстой.

2 дугаарт би Ж.Энхбаяр гишүүнтэй яг санал нэг байна. Төсөв чухал. Харин Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээр тогтоогдсон асуудлыг зөрчиж, бид нар төсвөө хэлэлцвэл энэ төсөв чинь бүр цаашдаа маш ноцтой үр дагаварт хүрнэ. Тийм учраас Пүүжээ даргын гаргаж байгаа энэ саналыг гишүүд дэмжээд, Байнгын хорооны дарга нар гялс ороод энэ асуудлуудаа шийдээд, өнөөдөртөө хамаагүй сунаж хуралдаад ч хамаагүй энэ асуудлуудаа жоохон мухарлаад явъя.

Тэгээд Дэгийн тухай хууль байгаа. Нам эвслийн бүлэг энэ хуулийн 6.6-д заасан нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэлээ тодорхой бичиж өгнө гэсэн. Сая ийм үндэслэл гараагүй байж байхад Б.Энхбаяр сайдыг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар танилцах асуудлыг шууд хаанаас ч юм бэ гээд гаргаад явчихлаа. Бид хэд ерөөсөө алхам тутамдаа ийм байна. Тэгээд би бол Пүүжээ даргыгаа хайрлаж байгаа учраас та битгий 1 өдөр суунгуутаа дэг зөрчөөд цаашаа явчихаасай. Би бас яг таныг дэг сахиулах гэж байгаа энэ туйлын хүсэл зоригийг чинь дэмжиж байгаа шүү дарга аа. Тэгээд та яаралтай энэ хуралдааныг хойшлуулаад, даргын дэргэдэх зөвлөлийг хуралдуулж, энэ асуудлыг шийдээд, 1 удаагийн дэгээ батлах уу. Тэгээд энийгээ дагаад Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дэгийн хуулийн аль аль заалтыг яаралтай засаж өөрчлөх юм. Энийгээ шийдээд урагшильъя гэдэг таны гаргаж байгаа саналыг дэмжиж байна гэдгийг хэлье.

Б.Пүрэвдорж: Ер нь бол энэ асуудлыг хасах горимын санал гаргахаар бол 17 цагаас өмнө гаргах юм байна. 1 дүгээрт.

2 дугаарт Цэцийн шийдвэр бол энэ Цэцэд оролцсон хүмүүс дээр л гарт нь байх шиг байна. Улсын Их Хурлын гишүүдэд ирээгүй байна. Тийм учраас Цэцийн шийдвэр дээр бид нар тэр өдрийн чуулганы хуралдааныг хүчинтэйд тооцсон, хүчингүйд тооцсон гэдэг энэ шийдвэр бид нар мэдэхгүй байна. Тийм учраас Цэцийн шийдвэр албан ёсоор ирсний дараагаар гишүүд танилцуулсны дараагаар бид нар тэр өдрийн хуралдаан 16, 17-ны хуралдаан хүчинтэй эсэхийг ярилцана.

Тийм учраас даргын зөвлөлийн гаргасан товын дагуу хэлэлцэх асуудлаа үргэлжлүүлээд явъя. Дараагийн асуулт. Тэмүүлэн гишүүн асуулт асууя. Байхгүй байна. Дараагийнх нь Номин гишүүн асуултаа асууя.

Ч.Номин: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Би өнөөдөр энэ дагасан хуулиуд дээр хэд хэдэн асуулттай байсан. Хэдий тийм боловч яг асуултаа асууж цаашаа үргэлжлүүлснээр би Үндсэн хуулийн цэцээс гарсан дүгнэлтийг зөрчиж байгаа, цаашлаад Үндсэн хууль зөрчиж байгаа юм болов уу гэдэг айдастай байна. Яагаад вэ гэхээр 16, 17-ны өдрийн ирцийг бүрдээгүй гэдэг үндэслэл дээр Цэцээс тухайн өдрүүдийн хурлуудыг хүчингүй гэдэг ийм дүгнэлт гарч ирж байна. Тэгэхээр бид нар 17, 16-ны өдрүүдийг хэлэлцсэн асуудлыг цаашаа үргэлжлүүлээд хэлэлцээд явахаар Улсын Их Хурал бүхлээрээ хууль зөрчих гэж байна уу гэдэг ийм айдастай байна. Тийм учраас Пүрэвдорж даргалагч аа та энэ асуудлыг яаралтай шийдвэрлэж өгөөч ээ. Үнэхээр бидний хувьд бол улсын төсвөө хэлэлцэх, төсвийн хүрээний асуудлуудаа гаргах энэ ажлууд бол маш чухал байна. Тэгэхээр энийгээ хэлэлцэхийн тулд хамгийн түрүүнд эхлээд бид нар 17-ны өдрийн хурал хүчинтэй юм уу. Хүчинтэй бол үргэлжлүүлж энэ асуудлаа хэлэлцүүлье. Хүчингүй бол одоо бид нар өнөөдөр хэлсэн үг болгондоо хуулийн өмнө хариуцлага хүлээх болж байна. Тэгэхээр та энэ асуудлыг эхлээд шийдвэрлэж өгөөч ээ гэдэг санал байн.

Б.Пүрэвдорж: Хэлэлцэх асуудалтай холбоогүй асуулт байна. Дараагийнх нь Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Өнөөдрийн энэ хэлэлцүүлэг бас ингээд хожим нь юм уу, Цэцийн дүгнэлт энэ байна л даа. Одоо ингээд мэдэн будилах ерөөсөө хэрэггүй. Хүчингүй болчих вий дээ л гэдэг хамгийн том үр дагавар л байгаад байна. Тэгээд сая хурал даргалагч маань уг нь асуудлыг ойлгоод явсан энд тэндээс утасдаад хэцүү байлгаж байх шиг байна. Ингэж бие биеийнхээ үйл ажиллагаанд хурал даргалагчийн хүртэл бүрэн эрхэд бас ингэж халдмааргүй байна. Тэгээд өөрөө л сүүлдээ Үндсэн хууль зөрчсөн асуудалд орчих вий дээ. Би энд нь л харамсаад байгаа юм. Дагаж байгаа хуулиуд бол маш ноцтой юмнууд байгаа. Энхбаяр сайд аа, та хүн даапаалах хэрэггүй ээ. Танд бол үнэхээр аймар дутагдалтай зан байдаг юм байна. Өөрийгөө бүр ингээд төрд 20 жил явчихсан энэ заалны хаан, бурхан гээд бодчихсон юм байна. Та тэгвэл цаашаа хараад суугаад, өөдөөс ингээд хүмүүсийг битгий даапаал тэгэх үү.

Б.Пүрэвдорж: Хэлэлцэх асуудалтай холбоотой яриарай.

П.Сайнзориг: Харин тийм Ийм зүйл байна. Тэгээд Пүүжээ дарга, Үндсэн хууль зөрчлөө. Пүүжээ дарга аа, ийм байна. Тэгэхээр энэ асуудлуудаар та горимын саналыг хураалгах ёстой байхгүй юу. Тэгчхээд та явахгүй бол та өөрөө зөрчөөд

явчихлаа. Ядаж гаргасан саналаараа горим хэлээд олонх чинь явахгүй бол та сүүлд нь энэ асуудал дээр чинь болоод Монгол Ардын намын энэ зодооны асуудлыг та үүрэх гээд байна шүү дээ. Тэгэхээр би энийг таныг оройтоогүй дээрээ горимоо хураалгаад, энэ танхимд олонхоороо шийдээд ядаж явахгүй бол би таныг бас хайрлаад байгаа байхгүй юу дарга. Тэгэхээр би уг нь асуулт асуумаар байна. Тэгээд энэ угаасаа ирцгүй, хууль хүчин төгөлдөр бус байгаа учраас яаж асуух юм. Ойлгомжгүй байна.

Одоо энэ Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээ дээр чинь Тавантолгойн ордыг шууд эдийн засгийн эргэлтэд оруул гэдэг гэрээ байгуулах эрхээ авч байна шүү дээ. Энэ дээр нөхөд өө, оффтейк гэрээ байгуулах гээд. Энэ гэрээг нь уншаад өгчихье л дөө. Урт хугацааны гэрээний үндсэн дээр иж бүрэн цогцоор нь ашиглах талаар олборлолт, тээвэрлэлт, экспортын гүйцэтгэх хамтрагч, хөрөнгө оруулагч санал болгож, хэлэлцээ хийх замаар эргэлтэд оруул гээд бид хэдэд буцааж эргэж танилцуулахгүйгээр шууд энийг чинь оффтейк гэрээ хийнэ гэдэг чинь энэ дээр орж ирчхээд байна нөхөд өө.

2 дугаарт энэ үнэт цаас гаргах асуудал дээр байна. 1 тэрбум долларыг гадаад зах зээл дээр гаргана гэж байгаа. Ямар зориулалтаар гээч. Өрийг дахин удирдах зориулалтаар. Дотоодын бондыг зөвхөн төсвийн орлогыг нөхөх зорилгоор гаргана гэж байна. Энэ асуудлууд дээр чинь бодитой хариулт авмаар байна шүү дээ. Энэ дэг зөрчсөн хурлаар чинь явахаар сүүлдээ энэ асуудлын чинь үр дагаврыг хэн хариуцах юм бэ. Тэгэхээр Пүүжээ дарга аа, та яг ярьснаараа саналаа хураахгүй бол өөрөө Үндсэн хууль зөрчлөө. Ингэж хурал даргалагчийн эрхийг хэрэгжүүлснээрээ та Монгол Ардын намын золиос боллоо. Энэ заваан юмны чинь золиос нь Ардчилсан намын дэд дарга байж болохгүй шүү дээ. Ардчилсан намаас сонгогдчихоод байгаа дэд дарга маань байж болохгүй. Тийм учраас Пүүжээ дарга ядаж саналаа хураагаад, та урагшлахгүй бол дарга аа, хэцүү шүү. Сүүлд нь тэгээд эд нар таныг хамгаалахгүй шүү дээ.

Б.Пүрэвдорж: Би нэг зүйлийг сануулъя. Тухайн өдрийн өмнөх 17 цагаас өмнө хэлэлцэх асуудлыг горимын санал гаргах эрхтэй. Бүлгийн даргаараа дамжуулж. Тийм учраас хойшлуулах санал ирээгүй. 1 дүгээрт.

2 дугаарт Цэцийн шийдвэрийг танаас өөр Их Хурлын гишүүд мэдэж байгаа юм ерөөсөө алга байна. Тэр нь тодорхой баримтаар ирээгүй байна. Дараагийн Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан алга байна. С.Эрдэнэбат гишүүн ирцэд ороогүй байна. Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: Өглөөний мэнд гишүүд ээ, би бас тодруулмаар л байгаа юм. Нөгөө төсвийн хэлэлцүүлэгт 2 дахь хэсэг дээр өчигдөр бид нар баахан цалин тэтгэвэр, тэтгэмжийн асуудлуудыг ярьчихсан байгаа. Тэгээд бас Байнгын хороон дээр санал энэ тэр хураагаад ярьсан байгаа. Харааны бэрхшээлтэй хүмүүсийн үйлдвэрийг босгох хөрөнгө оруулалтын асуудлыг, хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн асуудлуудыг зөндөө яриад ингээд дэмжээд явж байгаа. Байнгын хороон дээр. Тэгэхээр тэр маань өнөөдөр хэрвээ энэ дүгнэлтээр бол хүчингүй гэсэн үг үү. Дахиад эхэлнэ гэсэн үг юм уу. Тэр ажил дахиад эхэлнэ гэсэн үг үү. Нөгөө резет хийнэ гэдэг шиг дахина гэсэн үг үү. Энийг тодруулж авмаар байна. Танаас асууж байна.

Одоо энэ дүгнэлтийг харахаар тэр өдрийн хурал хүчингүй гээд явбал дараа дараагийнх нь ингээд залгамж хурлууд нь ойлгомжгүй болчихоод байна л даа.

Тэгэхээр өчигдөржингөө бид нар чинь нөгөө цалин, тэтгэвэр, асрамж, зардлын асуудлуудыг ярьсан. Тэгэхээр энэ чинь нөгөө 1, 2, 3 дугаар хэлэлцүүлэг гээд залгамж явж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ бүх юм маань хүчингүй болоод, дахиад эх нь л эхэлнэ гэсэн үг үү гэж би асуух гээд байгаа юм.

2-т гэвэл бид нар одоо байхгүй байгаа энэ танхимд бол манай нийт гишүүдийн 40 хувь нь байна уу, 50 хувь нь байгаа. Үлдсэн нь бол гараад явчихсан байгаа. Тэгэхээр энэ гарч явж байгаа гишүүн болгон өөрийнхөө санал нь татгалзаж байна гэдгээ бүгдээрээ мэдэхгүй байна гэж байхгүй шүү дээ. Бүгд санал хураавал байхгүй. Тэгэхээр энэ бүх юм чинь хүчингүй болчхож байгаа гэсэн үг юм уу. Дахиад бүх юмаа эхэлнэ гэсэн үг юм уу. Төсвийн хэлэлцүүлгээ. Би тэрийг л асуумаар байгаа юм л даа.

Б.Пүрэвдорж: Энэ даргын зөвлөлийн хурал цэцийн шийдвэр гарахаас үл хамааран тавигдсан асуудал. Тэгээд өнөөдөр энэ хэлэлцүүлэг явагдаж байна. Тийм учраас өнөөдрийн хуралдаан хүчинтэй юу, хүчингүй юу гэдэг асуудал бас тодорхой Цэцийн шийдвэр гарч байж л шийдэгдэнэ үү гэхээс бусдаар бол одоо юу гэдэг юм бид нар дээр цэцийн шийдвэр ерөөсөө ирээгүй байгаа гэдгийг хэлье. Банзрагчийн Түвшин.

Б.Түвшин: Та бүхнийхээ энэ өдрийн амгаланг эрье. Тэгэхээр өнөөдөр багш, ажилчид цалингаа нэмэхээр ингээд нэлээн жагсаал хийгээд, ажил хаялт зарлаад явж байна. Энийг бол зарчмын хувьд зүй ёсны асуудал гэж бодож байгаа. Тэтгэвэр нэмэх асуудал ч гэсэн бас яригдаж байгаа. Тэгэхээр манай улсын төсөв 2017 онд нийт 9 их наяд төсөв байсан. Өнөөдөр бид нар орлогоо бууруулж бууруулж, 33 их наядаар оруулж ирж байна. Энэ дотроо урсгал зардал бол 2017 онд 7 их наяд байсан. Өнөөдөр бид нар 24 их наядын урсгал зардлыг батлах гээд ингээд хэлэлцээд сууж байгаа. Тэгэхээр энд багш, эмч нарын цалинг нэмэх ямар орон зай гаргаж байна. Ер нь энэ төрийн албан хаагчдын цалин, нийгмийн даатгал, халамж, цалингийн нэгдсэн бодлогын асуудлаар ямархуу бодлого барьж байна. Төсвийн хэтрэлтийн асуудлыг хуваагаад авдаг юм байна. Цалин болгоод авдаг юм байна гэсэн бас асуудал яригдаж байна. Энэ үнэн үү. Боловсрол, эрүүл мэндийн үндсэн яг энэ хэсгийнхээ цалинг нэмэх боломжийг яг юу гэж харж байна. Энэ 4 дахин өсчихсөн урсгал зардлын хамгийн гол хэсэг нь юунаас болоод өсчхөв. Энэ дотор тэр бусад хүмүүсийн цалин, орлогыг нэмүүлэх боломж юу байна вэ. Энэ 1 дүгээр бүлэг асуулт.

2 дугаар бүлэг асуулт бол ерөөсөө төсвийн орлогын стратеги гэдэг зүйл байна уу. Төсвийн орлогыг бүрдүүлэх боломж ер нь хэр байгаа вэ. Цаашдаа тогтвор суурьшилтай төсвийн орлого авч байх тэр бодлогоо гаргасан байгаа юу. Энэ 2 асуултыг та бүгдээс асууя.

Б.Пүрэвдорж: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Сая төсвийн хүрээг оруулж ирэхдээ бол бид нар өмнө нь 33,5 их наядын орлого олно гэж төсвийн хүрээ баталчихсан байсан. Тэгэхдээ яг нөхцөл байдалтайгаа тохируулаад, бид бол энэ удаа орлогоо бууруулж тооцсон. Тэгэхээр орлого бууруулж тооцох бол мэдээж бараа бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дэх үнийн өсөлт, бууралттай холбоотой. Тийм ч учраас энэ удаагийн төсвийн хүрээ бол нэлээд бодитой болсон гэж бас үзэж байгаа. Тэгэхээр гол нь нөгөө энэ орлого бүрдүүлэх ажил дээр бид нар богино хугацааны стратегиудыг хэрэглэж байна. Энэ

ч утгаараа бас экспортыг нэмэгдүүлэх, орлого нэмэгдүүлэх чиглэлээр бид нар эдийн засгийн өсөлтийг тооцохдоо хүртэл яг салбарын яам болгон дээр нэгж хувийг бас тооцоод, дээр нь хийх ажлуудыг эрэмбэлсэн. Үүнтэйгээ уялдуулаад энэ төслүүдээ ч гэсэн бүрэн бүгдийг нь эрэмбэлж дууссан. Тэгэхээр яг орлого бүрдүүлэхэд шаардлагатай гэж тооцсон төслүүдээ тэргүүн ээлжид эрэмбэлээд, нийт 149 төсөл, дээрээс нь мега 14 төсөл гэж 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт оруулчихсан байсан төслүүдээ бол эрэмбэлсэн. Дээрээс нь яамнууд дээр бол жишээ нь орлого бүрдүүлэхэд яг ямар ямар ажил хийх вэ гэдэг дээр тэргүүн ээлжид бол ажлуудыг бас оногдуулаад явсан. Мөн төсвийн орлого бол эдийн засагтайгаа харьцуулахад зохистой түвшинд байх ёстой учраас хэт өндөр орлого төлөвлөх нь бол эдийн засаг дахь төрийн оролцоог нэмэгдүүлээд байдаг ийм сул талтай. Тийм учраас энэ удаагийн төсвийн бодлого бол өөрөө төрийн оролцоог бууруулахад чиглэнэ гэдэг ийм гол бодлогыг барьсан учраас бид нар тэнцвэржүүлсэн орлого, нэрлэсэн ДНБ-ий харьцааг бол 37 хувь байсныг 30,6 хувь руу бууруулсан. Ингээд эхлэхээр бол орлого зөвхөн татвараар бүрдэнэ гэхээсээ илүүтэйгээр жишээ нь зэс, алтны агуулга нэмэгдэж байна. Үүнтэй холбогдуулаад хэлэлцээрүүд явагдах ёстой. Үүнтэй холбогдуулаад мэдээж энэ шаардлагатай хууль, эрх зүйн орчныг сайжруулах ёстой. Тэр ч утгаараа зөвхөн орлого бол татвараар бүрдэхийг зориогүй. Энэ ч утгаараа бол бид нар энэ орлого GDP-ийн харьцааг бууруулж байгаа. Өнөөдөр энэ төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх энэ хуулийг баталснаар 50 төсөл хэрэгжлээ гэж бодоход 50 төсөл түншлэлээр санхүүжихэд бас орлогод хэрхэн нэмэр болох вэ гэдгийг эдийн засгийн өсөлт дээр хүртэл/минут дуусав/

Б.Пүрэвдорж: Түвшин гишүүн тодруулъя.

Б.Түвшин: Орлогын асуудал дээр бол ер нь тогтвортой орлогын стратеги барихгүй, бодлого гаргахгүй яваад байгаа учраас энэ орлого хэлбэлзэх, тасалдах ийм эрсдэл үүсэж магадгүй байгааг бас энд хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

2 дахь асуулт бол ялангуяа тэр багш, эмч нарын цалинг нэмэх асуудал дээр ямархуу бодлого барьж байна. Урсгал зардал 4 дахин өссөн байгаа. Өнгөрсөн 10 жилийн, 8 жилийн хугацаанд ер нь 4 дахин өссөн урсгал зардал юунаас болоод өсчхөв. Энэ дотор багш, эмч нарын цалинг хэдэн хувиар нэмэгдүүлэх боломжтой байна вэ гэдэг асуултаа дахиж тодруулж асууя.

Б.Пүрэвдорж: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Эмч нарын цалин дээр гүйцэтгэлээр санхүүжүүлнэ гээд хууль, эрх зүйн орчин бүрдээд, ажил явагдаад, алдаа оноо их гарч байх шиг байна. Багш нарын цалин хөлс дээр ч гэсэн гүйцэтгэлийн тогтолцоог нэвтрүүлнэ гээд төдийлөн бас үр дүнд хүрч чадахгүй байгаа. Уг нь бол бид нар энийг цогцоор нь харж шийдэхгүй бол багш, эмчийн цалинг өнөөдөр 20 хувь, 30 хувь нэмлээ гээд ирэх жил дахиад л нэмэгдүүлэх шаардлага бол үүснэ. Тэгэхээр тогтолцоогоор нь харж өөрчлөлт хийх шаардлагатай. Гэхдээ мэдээж улсын жилийн төлөвлөгөөнд энэ 24 хувиас илүү урсгал зардлыг нэмэгдүүлэхгүй гээд энэ босго байгаа учраас бид нар багш, эмчийн цалин дээр тодорхой нэмэгдэл хийе гэвэл төрийн зарим үйл ажиллагаагаа зогсоогоод, нэмэгдүүлэх бололцоо байна. Дээрээс нь жилийн төлөвлөгөөгөө 1 хувиар нэмэгдүүлэхэд 1 их наядын орон зай гараад, яам болгон дээр хийгдэх ажлуудаас урсгалаа танаад явахаас өөр арга зам бол өнөөдөртөө бол байхгүй.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж хариулъя.

Н.Учрал: Тэгэхээр тийм бололцоо байхгүй байгаа. Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийг бол тухайн үед би өөрөө санаачилж батлуулсан. Энэ Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль дээр бол багшийн гүйцэтгэлийн урамшууллын тогтолцоог нэвтрүүлнэ гэж зорьсон. Эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч энэ боловсрол энэ салбарт бол тэрнээс хойш яг тодорхой үр дүн гарсангүй. Энх-Амгалан сайдын үед бол энэ гүйцэтгэлийн урамшууллын ажлыг бол бас нэлээн эхлүүлж байсан. Тэгэхээр энэ тогтолцооны өөрчлөлт рүүгээ явъя. Тэгэхгүй энэ 10, 20 хувь нэмээд үр дүн гарахгүй байна. Тэгэхээр багшийн, эмчийн цалин хангамжийг сайжруулахгүйгээр бид нар цаашдаа энэ боловсролтой, эрүүл монгол хүнийг бэлтгэх бололцоогүй учраас зайлшгүй л энэ цалин хөлсийг ярих шаардлага үүслээ. Гэхдээ энэ удаа урсгалаа жилийн төлөвлөгөө дээр 1 хувь нэмэгдүүлээд, тэгээд 20 хувь хүртэл нэмэгдүүлээд явъя гэсэн ийм байр .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ренчинбямбын Сэддорж гишүүн асуулт асууна.

Р.Сэддорж: Өдрийн мэнд хүргэе. Учрал сайдаас асууя. Өчигдөр бас Байнгын хороон дээр энэ усны төслүүдийг дэмжихэд бас боломж бололцоо гарч, тэрийг гаргаж өгсөнд бас баярлалаа. Тэгээд төсөв эцсийн батлагдах хүртэл бас та бүхэн маань бас дэмжээрэй гэдгийг хүсэж байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль юу болж байгаа вэ. Энэ дээр яагаад ажил хийгдэхгүй байна вэ. Энийг гарц гаргалгаа гаргаж байгаа гэсэн юм. Хэзээ орж ирэх вэ. Улсын Их Хурлаар орж ирэх үү. Хэзээ орж ирэх вэ. Жишээ нь Даланзадгадын ДЦС 50 мегабайт барих гээд Эрчим хүчний яам бүгдээрээ л явж байна. Сангийн яам бонд гаргаад ингээд явж байгаа. Энэ яг ямар хуулиар баригдах вэ. Төсөв батлагдангуут бондын эрх нээгдэх байх. Ямар хуулиар баригдах вэ. Төр, хувийн хэвшлийн хуулиа хурдан шийдчихвэл энэ аймаг, орон нутгийн боломжууд чинь маш их байгаа юм биш үү. Улсын төсөв дээр ачаалал үүрүүлэхгүйгээр хийх ажлууд олон байгаа юм биш үү. Тэгээд энэ дээр тодорхой хэлээч. Их Хурлаар гаргах шийдвэрүүд хэзээ орж ирэх вэ. Энэ дээр бас Их Хурал дээр ажлын хэсэг гаргаад явах уу. Ямар боломж бололцоонууд байна вэ. Хамгийн гол нь бол аймаг, орон нутгуудын боломж, өөрөө өөрийгөө авч явах боломжуудыг нь л төрөөс дэмжиж өгье л гэж сүүлийн 30 гаруй жил ярьсан. Тэгээд энийгээ хэзээ хийх вэ гэсэн асуулт байна.

Б.Пүрэвдорж: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Сэддорж гишүүний асуултад хариулъя. Тэгээд Сэддорж гишүүн Эдийн засгийн байнгын хорооны даргын хувиар энэ Засгийн газрын олон төслүүдийг бол бас манлайлж дэмжсэн. Гэхдээ энэ олон төслүүд явлаа гээд усны асуудлыг бид мартаж болохгүй. Ялангуяа энэ говийн бүс нутагт энэ Орхон-Онгийн төсөл, Хэрлэн-Тооно гээд энэ олон усны төслүүдийг урагшлуулахгүй бол цаашаа бид нар ямар ч уул уурхайн салбарт ч бай, бусад салбарт ч бай төсөл хэрэгжүүлэхэд их бэрхшээлтэй болно. Тэгэхээр нийт зураг төсөв ТЭЗҮ бол Эдийн засаг, хөгжлийн яаман дээр төсөв нь тавигддаг. Хангалттай бол зардал биш. Гэхдээ энэ жагсаалтад энэ усны төслүүдийг бол тэргүүн ээлжид эрэмбэлээд явах гэдэг би ийм байр суурьтай Эдийн засаг, хөгжлийн сайдын хувиар байгаа. Орхон-Онгийн төсөл бол 2020 онд бас ТЭЗҮ нь хийгдсэн юм байна лээ. Гэхдээ шинэчлэх шаардлага байна. Онги-Цагаан бургастай төсөл, Хэрлэн-Тоонын усны төсөл, жишээ нь Хэрлэн-Тоонын төсөл бол ТЭЗҮ нь хийгдэж байгаа. Оюутолгойгоос санхүүжилт аваад. Тэгээд бид нар зураг төсөв, ТЭЗҮ бэлэн болгочоод гадна дотнын санхүүжилт,

дэмжлэг авах ажил руу орохгүй бол юу ч бэлэн биш цаашаа урагшлахгүй шүү дээ. Энэ утгаараа бол бид нар сая төслүүдийг эрэмбэлэхдээ энэ усны төслүүдийг бол тэргүүн ээлжид эрэмбэлсэн. Дээрээс нь сая улсын жилийн төлөвлөгөөнд 126 төсөл байсан. Жилийн төлөвлөгөөнд байсан төслүүдийн 76 нь улсын төсвөөс ямар нэгэн байдлаар санхүүжилт авч байсан. 50 төслийг хэн санхүүжүүлэх вэ. Санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй, тэгсэн мөртөө нийгмийн импакт өндөртэй. Ингээд одоо яах вэ гээд эрэлхийлж байж энэ өр Төр, хэвшлийн түншлэлийн хуулиа амь оруулъя л гэж зорьсон. Тэгэхээр энэ төсвийг дагалдуулаад яг таны хэлж байгаа төр хувийн хэвшлийн түншлэлийн хууль орж ирж байгаа. 50 төсөл түншлэлээр явна. Ингээд явах гэхээр одоогийн хэрэгжиж байгаа хуулиар бол бараг 8 үе шат, багадаа 1 жил 4 сар. Сангийн яамнаас 3 удаа зөвшөөрөл авдаг. Эдийн засаг, хөгжлийн яамнаас жагсаалтад оруулдаг. Тэгээд түншлэлийн төв дээр очоод урьдчилсан тэр шинжилгээ, бүрэн шинжилгээнүүд хийгддэг. Ингээд жил хагас гаднын хөрөнгө оруулагч нарыг авчраад, түншлэлийн төсөл хэрэгжүүлье гээд нөү хауг нь ашиглаж ашиглаж, хамгийн сүүлд нээлттэй сонгон шалгаруулалт зарлаад өөр компанид өгчихөөр яаж Монголд хүн хөрөнгө оруулж, хамтарч ажиллах вэ. Тэгэхээр аймаг, орон нутаг бие дааж төслөө хэрэгжүүлэх бололцоог нь олгоё. Нийслэл дээр өнөөдөр түншлэлийн төсөл амжилттай хэрэгжээд байгаагийн шалтгаан бол тэр 5 салбарт, дээрээс нь 100 тэрбумаас доош өртөгтэй төслүүдийг хялбаршуулсан журмаар хугацаа бага, үе шат бага байдлаар хийдэг Засгийн газрын хялбаршуулсан журам хэрэгжиж байгаа. Энэ хууль төсөв дагасан хууль батлагдсанаар аймаг, орон нутгууд бүгдээрээ түншлэлийн төслөө бие дааж хэрэгжүүлэх бололцоо бүрдэнэ.

Б.Пүрэвдорж: Сэддорж гишүүн тодруулъя.

Р.Сэддорж: Сангийн яамнаас хариулах ёстой байх. Бас Эрчим хүчний сайдаас асууя. Энэ 50мвт-ын станц хамгийн гол нь 1 аймаг бас хөлдчих гээд байна л даа. Энэ станц эвдэрвэл шууд хөлдөнө. Тэгээд 1 аймаг нь хөлдчихсөн байхад бид нар, миний хувьд бол бас энд суух тийм боломжгүй болж байгаа юм. Тийм учраас энэ ард иргэдийн хүсэлт шаардлага маш их байна. Жишээ нь Даланзадгадын өсөлт, тэлэлт дээр цахилгаан станц баригдахгүй л бол ер нь огт зогсчихсон байгаа. Тэгээд одоогийн станц нь бол маш хэцүү байдалтай ажиллаж байгаа. Тэгээд энэ 50мвт-ын станцыг яаж хурдан эхлүүлэх боломж байна вэ. Бондоор эхлүүлэх боломж байна уу гэдгийг Сангийн яамныхан маань хэлж өгөөч. Даланзадгадын хэрэглэгчдээс маш их хүсэлт, мессеж ирж байна.

Б.Пүрэвдорж: Учрал сайд хариулъя. Сангийн яам. Индрийн 4 номер.

С.Тулга: Тулгаа Сангийн яам. Гишүүний асуултад хариулъя. 50мвт-ын төслийн 500 тэрбум төгрөгийн бондын санхүүжилтээр хэрэгжихээр байгаа. Тэгээд энэ жилийн хувьд бол 150 тэрбумын эхний санхүүжилт нь бол 2026 төсвийн төсөлд туссан байгаа. Тэгээд энэ 2026 оны хууль батлагдмагц бондын ажиллагааг бол шууд эхлүүлээд явах боломжтой. Тэгээд дараа жил 350 тэрбум, 3 дахь жилдээ 50 тэрбум гэсэн ийм хуваарьтай ингэж орж ирж байгаа.

Худалдан авахын хувьд бол яг Төрийн худалдан авалтын тухай хуулийн дагуу явагдана.

Б.Пүрэвдорж: Одоо Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Монгол Ардын намын даргын сонгууль болсон. Энэ сонгуульд Ерөнхий сайд болон Улсын Их Хурлын дарга нар нэр дэвшиж, өрсөлдсөн. Тэгээд Монгол Ардын нам доторх эрх мэдлийн тэмцэл нь улмаар Улсын Их Хуралд орж ирж, өнгөрсөн Баасан гарагт эдгээр 2 субъект хоёулаа огцорсон. Гэтэл уг асуудалд энэ 7 хоногоос Үндсэн хуулийн цэц, Ерөнхийлөгч гэх мэт Монголын төрийн бүх институтууд оролцож эхэлснээр өнөөдөр бид хөл толгойгоо алдчихаад байж байна. Тэгээд энэ бүх зүйл юунаас эхтэй вэ гэхээр Монгол Ардын намын даргын сонгууль гэдгийг дахин саная. Тэгээд энэ эрх баригч намын даргын сонгууль хэрүүл тэмцэл дунд нүүрс л яригдаад байна. Явж явж нүүрсний мөнгөн урсгалаа хэн хянах вэ. Нүүрсний гэрээгээ хэн байгуулах вэ гэдэг тэмцэл та нарын дунд явдаг юм байна. Оюун-Эрдэнийн Засгийн газар хил холболтын гэрээ байгуулахдаа Тавантолгойн орд газрын Бортолгой, Ончхараат хэмээх 2 шинэ орд дээр гэрээ байгуулах эрх авсан байдаг. Энэ яг ямар гэрээ байгуулагдчихав. Ямар үнээр нүүрсээ зарахаар болов энэ тэр гээд асуухаар бас ерөөсөө хэлж өгдөггүй. Тэгвэл Занданшатарын Засгийн газар байгуулагдаад удаагүй байгаа. Анхны төсөв оруулж ирэхдээ мөн л дагалдуулаад Тавантолгойн орд газрын асуудлаар тодорхой эрх шилжүүлж авах тогтоол оруулж ирж байна. Энэ тогтоолыг зарим хэсгийг нь бас уншъя.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

1.1.Тавантолгой бүлэг ордын ашиглагдаагүй байгаа хэсгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, орд ашиглалтыг сайжруулж, тухайн орд газруудыг урт удаан хугацаанд үр ашигтай ашиглах бодлого хэрэгжүүлж, хөрөнгө оруулагч хуулийн этгээдүүдтэй хууль тогтоомжийн дагуу хэлцэл хийнэ гэнэ. Тэгээд өмнөх нүүрсний хулгайн эздүүд нь хэн байгаа юм. Ямар гэрээ яаж явчихсан юм гэдэг нь тодорхойгүй байхад шинэ Засгийн газар нь хүртэл дахиад л Тавантолгойгоороо оролдоод эхэллээ. Энэ Тавантолгой бүлэг ордын ашиглагдаагүй байгаа хэсэг гэж юу яриад байгаа юм бэ. Энэ өмнөх гэрээнүүд чинь хаана байгаад байгаа юм бэ. Тавантолгойн бүлэг орд гэдэг дэлхийн хамгийн том нүүрсний ордуудын нэг. 7 тэрбум тонны нөөцтэй. Монгол Улс өнгөрсөн хугацаанд нийтдээ 500 сая орчим тонн нүүрс экспортолсон байдаг. 46 тэрбум ам.долларын борлуулалт хийсэн. Үүнээс зөвхөн Эрдэнэс Тавантолгой төрийн өмчит компани 160 сая тонн нүүрс гаргаж, 36 их наяд төгрөгийн борлуулалт хийжээ. Энэ 160 сая тонн нүүрс тутмын 1 тонн тутмын гэрээг ил болгохыг яг энэ чуулганы танхимд хариуцлагатайгаар Занданшатар Ерөнхий сайдаа шаардаж байна. Тэгсний дараа энэ өөр тогтоолууд оруулж ирээ. Тиймээс энэ төсөвтэй дагалдаж орж ирж байгаа эрх авах гэсэн энэ тогтоолыг гишүүдийг бүү дэмжээсэй гэж хэлж байна. Үнэхээр нүүрстэй тэмцэх гээд, нүүрсний хулгайтай тэмцэх гээд байгаа юм бол яахаараа ийм шинэ гэрээ байгуулах эрхийг авах гээд байгаа юм бэ. Тэгэхээр энэ тогтоолыг бол эсэргүүцэж байна. Тэгээд саяын хэлсэнчлэн Ерөнхий сайдад албан ёсоор шаардлага тавьж байгаа нь юу вэ гэхээр та олон нийтэд мэдэгдсэнчлэн өнгөрсөн хугацаанд Эрдэнэс Тавантолгой төрийн өмчит компанийн гаргасан 160 сая тонн нүүрсний тонн тутмын гэрээг ил болгоод, ойлгомжтой байдлаар олон нийтэд нээлттэй болгоод тавьчих. Тэгээд бид нар бас дүгнэлтүүдээ хийе. Олон нийттэйгээ хамт, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэйгээ хамт. Тэгээд хэн нь яг нүүрсний хулгайч юм бэ гэдгээ мэдэж авъя л даа. Энэ Монгол Ардын нам дотор л ийм нүүрсний хулгай яригдаад байх юм. Цагаан байрандаа ярьж гэж хүртэл өөрсдөө ярих юм.

Б.Пүрэвдорж: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Тэгээд Занданшатарын Засгийн газар байгуулагдаад энэ Тавантолгой бүлэг орд дээр ажиллаж, шалгах, хянах ажлын хэсэг байгуулсан. Ингээд дараа нь 1 хүн биш бүрэн эрхт төлөөлөгчийн баг буюу зөвлөл байгуулаад, яам болгоны төлөөллийг багтаасан. Үүний үр дүнд экспорт 1.7, 1.8 дахин өссөн. Өнөөдөр Гашуунсухайтын боомт дээр очоод үзэхэд машин тэрэг овоороод байхаа болиод, 7, 8 бууж суухаа болиод экспорт хэвийн явагдаж байгаа. Ил тод байдал бол үр дүнд хүргэдэг. Хяналт бол бодит нөхцөл байдлыг илрүүлдэг. Өмнө нь бол бид нар 820 мянган юнит мэдээллийг ил болгоод, авлигын төсөөллийн индекс дээр яагаад манай улс эрэмбэ урагшилдаггүй юм бэ гэхээр олборлох салбарын ил тод байдлын санаачилгад нэгдсэн орон мөртөө Уул уурхайн салбарын ил тод байдлын хуулийг батлаагүй. Одоо бид Занданшатарын Засгийн газар бол олборлох салбарын ил тод байдлын хуулийг Их Хуралд өргөн мэдүүлнэ. Энэ бол ил тод байдал. Ингээд шалгалт хийхэд Тавантолгойн ашиглагдаагүй байгаа хэсгийг дахиад хулгай дээрэмд автчих вий дээ, энэ ашиглагдаагүй байгаа хэсгийг нь өмнөх шигээ янз бүрийн давуу байдлаа ашиглаад, хэн нэгэн оролцчих вий дээ гэдгээс болгоомжил, бид олон улсын аудит оруулж байгаа. Шалгалт оруулж бодитой дүгнэлт гаргаад, энэ дээр хэлэлцээр хийж, ард түмэндээ Үндэсний баялгийн сангийн хуулийн дагуу 34 хувийг Баялгийн сандаа авах хэлэлцээр хийхийг үүрэг болгож, хамгаалж авч байгаа энэ тогтоолоор. Тэрнээс биш энэ тогтоолыг хийснээрээ янз бүрийн гэрээ хийх гээд байгаа юм байхгүй. Хэлэлцээрийг бид нар ойлгох ёстой. Хэлэлцээр гэдэг бол харилцан буулт хийх зарчим. Ард түмэн ялж байх зарчим. Баялгийн сангийн хуулийн хэлэлцээр яаж явдаг вэ гэхээр төрийн эзэмшлийн 34 хувь баялгийн санд ордог. 34 хувийг АМНАТ-оор орлуулах бүтээгдэхүүн хуваахаар оруулах эрхийг зөвхөн Их Хурал хадгалж авч үлдсэн. Тэгэхээр Их Хуралгүйгээр энэ бүлэг орд тэнд Засгийн газар дээр хэрэгжээд явна гэж байхгүй. Харин ч энэ Их Хурлын тогтоол гаргаснаараа энийг Их Хурал шийднэ шүү. Энэ бол ард түмний мэдэлд байна шүү гэдгийг хамгаалж өгч байгаа юм. Наад тогтоолоо сайн уншвал олон улсын аудит оруулна гэдэг үг байгаа. Бид нар ямар ч асуудал дээр энэ олон улсын аудит оруулахгүйгээр асуудалд хандаад байдаг. Өнөөдөр олон компанийг Ай Пи Өү гаргая гээд Их Хурлын тогтоолоор биччихээд бид нар компаниудыг нээлттэй болгосон нь хаана байгаа юм. Энэ юу вэ гэхээр олон улсын аудит оруулаагүй компанийг листэж болгож чадахгүй л нөхцөл байдалтай байгаа байхгүй юу. Тэгээд ингэж хамгаалж авахгүй бол дахиад хулгайд нэрвэгдэх вий гэдэг энэ болгоомжлол .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Батбаярын Жаргалан гишүүн тодруулъя.

Б.Жаргалан: Учрал сайд өмнөх Монгол Ардын намын удаа дараагийн Засгийн газруудад бол ажиллаж байсан. Тэгэхээр өмнөх Засгийн газрууд бол ерөөсөө ил тод байдалгүй байсан юм байна гээд та сая хэлчих шиг боллоо. Тэгээд тэр асуудлаа бас та хэд маань нэг хянаад, тэгээд одоо миний хэлсэнчлэн Эрдэнэс Тавантолгой дээр явсан бүх гэрээг ил тод болгохыг шаардаж байна.

Тогтоолын төслийг маш сайн уншиж танилцаж байгаа. Энэ тогтоолыг хэрэгжүүлэхдээ урт хугацааны гэрээний үндсэн дээр иж бүрэн цогцоор нь ашиглах талаар олборлолт, тээвэрлэлт, экспортыг гүйцэтгэгч, хамтрагч, хөрөнгө оруулагчдад санал болгож, хэлцэл хийх замаар Эрдэнэс Тавантолгойн ашиглагдаагүй орд газрыг эргэлтэд оруулна гээд байгаа юм. Тэгэхээр тэнд гэрээ байгуулна л гэсэн үг шүү дээ. Тэгээд Тавантолгойн бүлэг ордын ашиглагдаагүй байгаа хэсэг гэж яг юуг хэлээд байгаа юм бэ. Тэр Ончхараат, Бортолгой бас яг юу болсон юм бэ.

Б.Пүрэвдорж: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Би Оюун-Эрдэнийн Засгийн газрын Хэрэг эрхлэхийн дарга, Цахим хөгжлийн сайд, 820 мянган юнит мэдээллийг ил болгосон. Оюун-Эрдэнийн Засгийн газар бол цахим засаглалын индексээр Монгол Улсыг 28 байр урагшлуулсан Засгийн газар. Би бол төрийн ажлын залгамж чанарыг үргэлж хүндэтгэдэг. Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрөө би бас Оюун-Эрдэнийн Засгийн газрын Хэрэг эрхлэхийн даргын хувьд ололт амжилтаа ахиулаад урагшилж байгаа.

Энэ удаа бол Занданшатар Ерөнхий сайдын хувьд өөрийнх нь барьж байгаа зарчим бол олон улсын аудит оруулж, энэ Тавантолгойн бүлэг ордод шалгалт оруулж, экспортоо нэмэгдүүлэе. Цаашдаа энийг Их Хурлын тогтоолоор хамгаалж авъя. Энэ хулгай дээрэм, авлига, ашиг сонирхолтой тэмцэх ажлыг үргэлжлүүлэе. Ингээд энэ Тавантолгой ашиглагдаагүй байгаа хэсгүүд ямар ямар хэсгүүд байна, энэ аудит оруулчхаад, эцсийн үр дүнд нь хэлэлцээр хийгээд, эндээс олсон орлогоороо хүний хөгжлийг дэмжсэн төслүүд болоод багш, эмчийн цалин нэмэгдүүлэхэд нэмье гэсэн ийм л зорилготой ажиллаж байгаа.

Б.Пүрэвдорж: Батбаярын Жаргалан гишүүн дахин тодруулъя.

Б.Жаргалан: Би Засгийн газрын гишүүдээс маш тодорхой зүйл асуугаад байхад ерөөсөө хариулахгүй юм. Энэ тогтоолд чинь заасан Тавантолгойн бүлэг ордын ашиглагдаагүй байгаа хэсэг гэж аль хэсэг юм бэ. Ямар эрх та нар авах гээд байгаа юм бэ. Өмнө нь тэр Ончхараат, Бортолгой дээр гэрээ байгуулагдсан юм уу, байгуулагдаагүй юм уу. Ямар хөнгөлөлттэй үнээр гэрээ байгуулагдсан юм бэ. Энэ гэрээнүүдээ ил тод болгох юм уу, болгохгүй юм уу. Энэ бид чинь нүүрсний асуудал юу болчихсон ю, нүүрсний хулгай гээд бие биеийгээ та бүхэн цоллоод байна. Энэ бүхэн дээр ямар асуудал гарчихсан гэдгийг Монгол Улс орон даяараа бид нар мэдэхийг хүсэж байна шүү дээ. Тэгээд урдаас ийм ойлгомжгүй зүйл яригдаад байх юм. Дамдинням сайд хариулах юм шиг байна. Тийм үү.

Б.Пүрэвдорж: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Жаргалан гишүүн ээ, энэ их тийм ойлгомжгүй юм байхгүй. Монгол Улсын Ерөнхий сайд төсөв танилцуулж байхдаа, бас тэгээд огцруулах тухай асуудал орж ирж байхад ч гэсэн энэ бол нөгөө Тавантолгойн бүлэг ордод байгаа Бортээгийн орд гээд тодорхой хэлчихсэн шүү дээ. Нийтэд ил байгаа. Бортолгой, Ончхараат энэ тэр чинь нөгөө Чайна энерги рүүгээ явчихсан шүү дээ. Бүгдээрээ бас мэдэж байгаа.

Энэ тогтоол гарснаар бол олон нийтэд ил тод болж байгаа, олон улсын аудит оруулъя гэж байгаа, гэрээ хэлцлийг нь Их Хурал өөрөө хянадаг болох ёстой юм гэсэн ийм л утгатай тогтоол шүү дээ. Энэ чинь өмнө нь ерөөсөө орж ирдэггүй л байсан шүү дээ. Тэгэхээр энийг нийтэд ил болгож байгаа. Олон улсын аудитыг нь оруулъя. Тэгээд Улсын Их Хурлын хараа хяналтад оруулъя. Олон нийтийн нүдэн дээр ил болгож байгаад явуулъя гэдэг ийм л утгатай тогтоол шүү дээ. Нэг их айхтар нуугаад хаагаад, зугтаад байгаа юм байхгүй. Би түрүүн хэллээ. Ерөнхий сайд бол хэлчихсэн. Энэ бол Бортээгийн орд гээд.

Б.Пүрэвдорж: Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Ер нь энэ Тавантолгойн бүлэг ордыг Эрдэнэс Тавантолгой компани дээр Их Хуралд ч хэлэхгүйгээр, Засгийн газар ч төдийлөн мэдээлэлгүйгээр ингэж хэмжээлшгүй эрхтэйгээр хадгалж, хав дарж суух нь бол зохимжгүй л байхгүй юу.

Тийм учраас Их Хурал дээр тогтоол оруулж ирээд, энийг нь хаагаад явахгүй бол дахиад ирээдүйд юу үүсэхийг хэн ч хэлж мэдэхгүй байгаа байхгүй юу. Бортолгой, Ончхараат хэсгийг чинь Чайна Энержид гэрээгээр ашиглуулах эрхийг нь өгчихсөн байгаа. Тэгээд одоо зөвхөн тэр Бортээгийн орд нь эдийн сэргэлтэд ороогүй байгаа юм байна. Тэгэхээр энэ хэл ам, хэрүүл шуугиан тариад байгаа асуудлыг Их Хурал дээр тогтоолоор хамгаалж аваад, аудит оруулаад, тэгээд яах вэ гэдгийг хэлэлцээрийг нь Их Хуралд оруулж ирээд, Их Хурлаараа шийдээд л явах ёстой. Тэрнээс биш энийг зүгээр нэг компанийн мэдэлд та нар хэнтэйгээ гэрээ хийх нь хамаагүй шүү гээд байх юм бол энэ асуудал дагуулна. Тэгэхээр энийг Их Хурал өөрөө хадгалах хэрэгтэй. Энэ бол газрын хэвлийн баялаг шүү дээ. Ард түмэн баялагтаа эзэн.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Батбаярын Жаргалан гишүүн. Хамгийн сүүлийн удаа.

Б.Жаргалан: Нүүрсний хулгай ингэж улс орон даяар яригдаж байгаа, өнгөрсөн хугацаанд ер нь Эрдэнэс Тавантолгойн олборлосон тэр миний түрүүн дурдсан 160 сая тонн нүүрс, 36 их наяд төгрөгийн борлуулалт хэний шийдвэрээр яаж зарцуулагдсан бүх зүйл маш ойлгомжгүй нууцлаг байгаа энэ цаг үед дахиж Эрдэнэс Тавантолгойн эзэмшлийн орд газрууд дээр Засгийн газарт ямарваа нэгэн эрхийг Улсын Их Хурлаас өгөх нь зохимжгүй юм гэсэн ийм байр суурьтай байгаа.

Тэгэхээр Засаг бол жишээлбэл энэ ашиглагдаагүй байгаа орд газрыг хамгаална гэж яриад байгаа боловч цагаан дээр хараар хэлцэл хийх эрхээ авах гэж байгаа ийм тогтоол оруулаад ирчихсэн сууж байгаа. Энэ бол ерөөсөө буруу юм. Бид нар эхлээд улс орон даяараа энэ нүүрсний өнгөрсөн хугацаанд гарсан мөнгө хаачив гэдэг дээр үнэлэлт, дүгнэлт өгчихмөөр байна. Тэгээд дараа нь энэ орд газраа ашиглалтад оръё.

Б.Пүрэвдорж: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Би 2 багц асуудлаар байр сууриа илэрхийлье. Юуны өмнө сая Энхбаяр гишүүнийг сайдад томилох асуудлыг хэлэлцэх асуудлыг Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийг зөрчөөд, өөрөөр хэлбэл зарчмын зөрүүтэй санал бүлгүүд гаргаагүй байхад оруулж ирээд, санал хураагаад явчихлаа. Энийг хуралдаанд тэмдэглүүлье.

2 дугаарт энэ нэр дэвшиж байгаа гэх юм уу гишүүн Энхбаяр гэх хүн удаа дараа энэ гишүүдийг сүрдүүлээд байна. Өчигдөр Хууль зүйн байнгын хороо дээр миний гаргасан саналыг буюу прокурорын байгууллагын 4,3 тэрбум төгрөгөөр хөрөнгө оруулалт нэмэгдүүлэх зарчмын зөрүүтэй саналыг Энхбаяр гишүүн унагаад, унагахдаа намайг доромжилсны чинь төлөө энэ саналыг унагалаа гэж хэлсэн. Маш олон гишүүд тэрийг сонссон. Тэнд байсан хуулийн байгууллагынхан бүгд сонссон. Энэ хүнд ерөөсөө хуулийн салбарын асуудал ерөөсөө сонин биш. Зөвхөн хувийн өш хонзонгоо авах зорилготой. Намайг зүгээр үг хэлж байхад чимээгүй байгаач, та нар битгий зэрэгцээд яриад байгаач гэж хэлсний төлөө Прокурорын байгууллагын төсвийг унагасан ийм хүн байж болох юм уу. Тэрийг гишүүд бас мэдээсэй гэж бодож байна.

2 дугаарт гол хэлэх гэж байгаа бас нэг санал бол Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг бид нар бичгээр аваагүй байна гээд. Гэтэл өнөө өглөө 8 цаг 30 минут, 8 өнгөрч байхад Үндсэн хуулийн цэц олон нийтэд нээлттэй сайт дээрээ байршуулчихсан. Цэцийн хуралдаан болох үед бол бас бүх зүйлийг бид нар нээлттэй зараа байршуулсан гээд ингээд цахимаар явж байгаа бүх үйл ажиллагаагаа Цэц бол хүчин төгөлдөр гэж үзээд, бүх процессыг цахимаар явуулсан энэ зүйлүүдээ хүчин төгөлдөр гэсэн. Тэгэхээр бас дүгнэлтийг дахиад л хүчин төгөлдөр гээд л явах нь бол ойлгомжтой. Дээрээс нь Ж.Энхбаяр гишүүн бас Цэц дахиж ийм дүгнэлт гаргахгүй, наадах чинь зөвхөн Ерөнхий сайдад хамааралтай гэж тайлбар хэлээд байх шиг байна. Энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн 35 дугаар хуудсанд ерөөсөө зөвхөн Ерөнхий сайдад хамааралтай гэдэг дүгнэлт гаргаагүй. Тэр байтугай Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн энэ гишүүд саналаа биетээр өгөөгүй асуудлыг Үндсэн хууль зөрчсөн гээд ингээд дүгнэчихсэн байна. Энэ нь өөрөө маш их үр дагавар дагуулна. Би бас найдаж байсан. Өнөөдөр энэ бичгээр харах хүртлээ зөвхөн энэ огцруулах асуудал дээр л ингэж биечилж санал өгөхөөр дүгнэж байгаа болов уу даа. Тэгэхгүй бол бусад асуудал дээр арай ч тэгж дүгнэхгүй байх гэж бас найдаж байсан. Гэхдээ бүх асуудал дээр ингээд Цэц дүгнэчихсэн байна. Тэгээд энийг манай Их Хурлын дэг, Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл энэ асуудлыг маш чухалчилж авч үзэхгүй бол болохгүй. Одоо ингээд энэ танхимд хаяад гарсан хүмүүсийг бүгд саналаа өгөөгүй гэдгээр тооцох нь байна шүү дээ. Эсрэг санал гэдгээр тооцохгүй гэсэн үг. Маш тодорхой биччихсэн байна. Тэгэхээр энийг цаашид энэ чигээр нь явах юм уу, яах юм. Тэгээд Цэцийн дүгнэлтийг хэлэлцэхгүй гэж байгаа учраас энийг бид нар дагаж мөрдөхөөс өөр аргагүй байдалд орно. Тэгээд цаашид Их Хурал асуудлаа хэлэлцэж чадахгүй болох нь.

Хэлэлцэж байгаад асуудалтай холбоотой 1 зүйлийг хэлье.

Хэлцэл байгуулах гэдэг эрх дотор гэрээ байгуулах эрх орно. Иргэний хуульд байгаа. Сая Учрал сайд Бортээг эдийн засгийн эргэлтэд ороогүй гэлээ. Тэгээд юугаа хийгээд Бортээгээс баахан нүүрс аваад идчихсэн юм шиг ийм мэдээлэл олон нийтэд явуулаад байгаа юм бэ. Улсын Ерөнхий прокуророос мэдээлэл гаргаад нүүрсний гэх хэрэг дээр нийтдээ 153 хүн, хуулийн этгээдийг шалгаад, 88 хүнд ял өгөөд, одоогийн байдлаар шалгагдаж байгаа 40 хэрэг байна гээд мэдээллээ гаргачихсан. Энэ 40 хэрэг дотор энэ танхимд байгаа хүмүүс байгаа юм уу, байхгүй юм уу гэхээр байгаа гэдэг мэдээлэл өгөөгүй байна одоогийн байдлаар.

Тэгээд ингээд хүмүүсийг бүр ингээд бүх хүмүүсийг эргэлзээнд оруулаад, төрд итгэх итгэлийг хаяад, зөвхөн та нарт л итгэж байвал болно гэж та нар бодоод байгаа юм уу. Та нарт ч итгэхгүй байгаа шүү дээ. Тийм учраас энэ дагалдаж орж ирж байгаа энэ хэлцэл байгуулах эрх гэдэг дотор саяын тэр гэрээ байгуулах эрх ороогүй гэж худлаа хэлээд байгааг нь би эндээс мэдэгдэх нь зөв байх гэж бодож байна.

Б.Пүрэвдорж: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Тэгээд би мэддэг мэддэг гэхэд Үндсэн хуулийн цэцийн Их суудлын хуралдаан тайлбарлах хэмжээний хүн биш. Тийм учраас та бид 2 бол энэ асуудлаар ярих нь цагийн гарз болно. Би бас мэдэмхийрч тэгж хамаагүй юм яримааргүй байна.

2-т бол бас мэддэг мэддэг гэхэд Их Хурлын чуулган дээр хууль хяналтын байгууллагын тэр нарийн ширийн мэдээллийн талаар мэдэгдэхүүн, мэдээлэлгүй байж байж ийм бас илүү долоон юм яримааргүй байна.

2-т бол ингээд иргэдэд хамаагүй бас төөрөгдөл учруулсан мэдээлэл яримааргүй байна. Их Хурлын тогтоол дээр хэлэлцээр хийнэ гэж байгаа. Хэлэлцээр гэдэг бол negotiation хийнэ. Газрын хэвлийн баялгийн дийлэнхийг ард түмэн эзэмшинэ. Үндсэн хууль. Үндэсний баялгийн сангийн хууль тэр 34 хувь, түүнийг бүтээгдэхүүн хуваах АМНАТ-өөр орлуулах эсэх асуудлыг гагцхүү Их Хурал шийдвэрлэнэ. Энэ чинь хэн ч дураараа хийдэггүй юм. Эрдэнэс Тавантолгой компани наад нэг хэдэн ордуудыг чинь дэргэдээ авч эзэмшиж, дураараа хэлцэл, гэрээ хийсээр байгаад өнөөдөр энэ олон нүүрсний сонсгол чинь болчихоод, хэрээс хэтэрчхээд байна шүү дээ.

Багш, эмч нар нь цалингаа нэмүүлье гадаа зогсож байхад хэний ч сонсож байгаагүй хэдэн 10 тоогоор ярьдаг. Тооныхоо хэмжээгээ алдчихсан. Одоо бүр мөнгөний баримжаа алдчихаад байна шүү дээ энэ зарим улс төрч нар чинь. Тэгээд үүнээс чинь болоод Их Хурлын гишүүдийг бүгдийг нь хулгайч дээрэмчин гэж ойлгоод байна шүү дээ. Тэгээд 2 талд гарч жүжиглэж байгаагаа хэдүүлээ болих хэрэгтэй шүү дээ. Наад Их Хурлын тогтоол дээр чинь хэлэлцээр хийнэ гэж байгаа. Гэрээ хийнэ гэж байхгүй. Энийг чинь Их Хурлын тогтоолоор оруулахгүй бол угаасаа наадхыг чинь Эрдэнэс Тавантолгой компани Их Хуралтай, Их Хуралгүй, Засагтай, Засаггүй өөрсдөө шийдвэрлээд явна. Тэгээд хэдэн жилийн дараа нүүрсний сонсгол дахиад энд хийгдэнэ. Тэгээд юу гэх үү. Энэ чинь хэлэлцээр, хэлэлцээр. Харилцан буулт хийх зарчим, санхүүгийн банк, хуулийн банк, аудит оруулж байж хэлэлцээр хийдэг. Би бас энэ гуравдагч хөршийн хөрөнгө оруулалтын гэрээг ахалсан корпорэйт гэрээ хийсэн. Харин би энийг бол Монголд ашигтай гэрээ хийсэн гэж боддог шүү.

Тэгэхээр ийм тохиолдолд энэ эрхийг Их Хурал аваасай. Хууль тогтоох дээд байгууллага нь энийг эзэмшээсэй гэж бодоод байгаа юм. Тэрнээс нэг төрийн өмчийн компани ингээд даварчихсан бүх юмыг мэдэж байдаг байна гэж байхгүй шүү дээ. Хэлэлцээрээ хийгээд, Их Хурал руу орж ирээд, тогтоол бариад ингээд л явах хэрэгтэй л гэдэг ийм л байр суурьтай байгаа.

Тийм учраас хэдүүлээ энэ вакумаасаа салаад, улсаа бодоод урагшаа хараад явах хэрэгтэй. Төрийн ажил бол амаргүй юм байна лээ шүү. Энэ улс төрийн ажил бас их амаргүй шүү. Тийм учраас 2 хүний хооронд ярьсан яриаг энд яриад байх нь бол .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Баасанжаргал гишүүн нэмж тодруулъя.

Х.Баасанжаргал: Би сая тэр нүүрсний гэх нэршлээр эрүүгийн хэргүүдэд 88 хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгээд байна гэдэг мэдээллийг Улсын Ерөнхий прокурорын цахим сайт дээр мэдээлэл нь 10 сарын 6-ны өдөр гарчихсан байна. Энийг би уншиж танилцуулж, хэллээ. Нэг их нарийн ширийн мэдээллийг би мэдээд байгаа юм байхгүй. Нээлттэй мэдээлэл.

2 дугаарт Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн 35 дугаар хуудсыг бас уншиж танилцууллаа. Би тайлбарлаад байгаа юм байхгүй.

3 дугаарт Их Хуралд оруулж ирсэн Их Хурлын тогтоолын төсөл дээр нь дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар Занданшатарт даалгасугай гээд хэлцэл хийж гээд биччихсэн байна. Хэлэлцээр гээд байгаа таны дахин дахин хэлээд байгаа хэлэлцээр гэдэг үгийг чинь бичээгүй хэлцэл хийж, хэлцэл хийж, хэлцэл, хэлцэл гэж бичсэн байна.

Хэлцэл гэдэг нь Иргэний хуулийн 39 дүгээр зүйлийн 1. Иргэний эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, шилжүүлэх, дуусгавар болгох зорилгоор хүсэл зоригоо илэрхийлсэн иргэн, хуулийн этгээдийн эс үйлдэл, үйлдлийг .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Хэлцэл хийгээд шууд хүчин төгөлдөр хэрэгжээд явахгүй. Наадах чинь Монгол Улсын Үндсэн хуультай, Баялгийн сангийн хуультай, би хэлээд байна шүү дээ. Бүтээгдэхүүн хуваах тэр АМНАТ-өөр орлуулна уу, бүх тэр гэрээ, хэлцэл чинь Их Хурлаар батлагдана. Тийм болгохгүй бол тэнд дураараа авирлаад байна. Тэр Бортээгийн асуудал гэдгийг зөвхөн нүүрсийг нь зөөж ашигласнаар үүснэ гэж л ойлгож яриад байна. Нууцаар ашиглахаар завдсан асуудал. Давуу байдал олгож гэрээ байгуулсан асуудал байгаа шүү дээ. Тийм биз. Тэр гэрээ байгуулсан учраас тухайн компани чинь уурхай дотор нь газар аваад, үйлдвэр хүртэл барьчихаад байна шүү дээ. Энийг чинь Их Хуралд хэлэхгүйгээр, Засагт хэлэхгүйгээр компани дээр сууж байгаа гүйцэтгэх захирал гэдэг нэр нэртэй хэдэн нөхөд дураараа авирлаад байна. Энийг чинь зогсооё гээд байхаар ингээд тэмээ гэхээр ямаа гээд байх юм. Тэгээд 2 хүн хоорондоо ярьсан асуудлыг Их Хурлын чуулганд битгий ярь. Төрийн ажил тийм амар биш. Ярих юм байна. Ярихгүй юм байна.

Н.Учрал: Баасанжаргал гишүүн нэмж тодруулъя.

Х.Баасанжаргал: Их Хурлын тогтоолын та бүхний өргөн барьсан тогтоолын төсөл дээр хэлцэл гэдэг үг чинь байгаа. Дахиад би хэлье. Та хэлэлцээр гэж дахин дахин дурдсан. Тэгвэл би хэлцэл гэдгийг чинь хэлье. Хэлцэл гэдгийн цаана гэрээ байгуулах эрх чинь бүгдээрээ байгаа. 1.1 дээр чинь байна. 1.1.3 дээр байна. Хэлцэл, гэрээ байгуулах эрхийг та нар Занданшатарт олгуулах гээд ингээд сууж байна шүү дээ. Засгийн газарт олгуулах гээд сууж байна шүү дээ. Тэгээд энийгээ худлаа энэ чинь гэрээ биш гэж тайлбарлаад байх юм.

2 дугаарт 2 хүний хооронд болсон Энхбаяр гишүүн бид 2-ын хувийн асуудал биш байхгүй юу тэр прокурорын төсөв чинь. Энэ чинь бүхэл бүтэн хуулийн салбарын байгууллагын төсөв ярьж байхад намайг доромжилсны чинь төлөө энэ саналыг чинь унагалаа гээд тэр тэгээд хэвийн үү. Би Ёс зүйн хороонд энийг хандана, өгнө. Тэгээд энийг ингээд хэвийн мэт. Та нар ингээд хүмүүсийг бүр айлгаж сүрдүүлсээр байгаад, тэрийгээ бүр яг нэг хэвийн зүйл гээд бодчихсон. Ийм балмад, ийм бүдүүлэг, ийм хөгийн байж болох юм уу энэ танхимын гишүүд чинь.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Болсон уу. Баасанжаргал гишүүн ээ, та бас ингээд Цэц дээр очсон хүний хувьд бол би танд нэг зүйлийг хэлчихье. Тэгэхээр Цэц бол хүсэлт өгөөд, тэрнийх нь дагуу шийдвэр гаргаж байгаа. Өөрөөр хэлбэл Ерөнхий сайдыг огцруулсан тухай асуудлаар шийдвэр гаргасан. Тэрийг хэлэлцэх явцдаа өөрөөр хэлбэл тэр хууль зөрчсөн байна гэдэг, Үндсэн хууль зөрчсөн байна гэдэг л ийм дүгнэлт гаргасан. Цэцэд аливаа нэгэн ирцийн талаар болон Улсын Их Хурлын

цэцийн шийдвэр гарахаас өмнөх бусад шийдвэрийн асуудлаар ерөөсөө хүсэлт өгөөгүй.

Тийм учраас өнөөдрийн энэ хэлэлцэж байгаа асуудал бол тухайн өдрийн асуудал бол ямар ч цэц урагшаа шийдвэр гарахгүй шүү дээ. Тийм учраас энэ асуудлыг бид нар хэлэлцээд явж байна. Тийм учраас ямарваа нэгэн асуудал байхгүй ээ гэдгийг бас хэлье.

Яагаад гэвэл энэ цэцийн чинь дүгнэлтийг дөнгөж сая тарааж байна. Би энийг уншаад тэр Цэцийн шийдвэрийг чинь хараад л ярьж байна. Цэцэд бол ирцийн асуудлаар ямарваа нэгэн хүсэлт очоогүй. Жишээ нь маргаан шийдвэрлэх хүсэлт. Бусдаар бол Ерөнхий сайдын асуудлыг л тэнд хууль бусаар юу байдаг юм хууль зөрчсөн байна уу, шийдсэн үү, үгүй юу гэдэг асуудал яасан болохоос бусад асуудлыг хэлэлцээгүй гэдгийг бас Сайнзориг гишүүн бас танд бас хэлчихье. Дээрээс нь би бас Баасандорж даргад бас итгэхгүй байна. Яагаад гэвэл урд талын дарга нь байхгүй болчихсон. Дахиад дээрээс нь Их Хурлын дэд даргаа хууль зөрчүүлчихсэн. Тэгэхээр надад бол маш сайн зөвлөх байгаа. Хуулийн. Тэр бол Эрдэнэбат гэж зөвлөх байгаа. Тэр хүн бол энэ асуудал чинь ямар ч хуулийн зөрчилгүй гэдгийг бас хэлж байгаа шүү гэдгийг хэлье. Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуулт асууя.

Б.Пунсалмаа: Баярлалаа. Иргэд өнөөдөр бид нар төсөв хэлэлцэж байгаатай холбогдоод хэлчихэд гадаа жагсаал цуглаан хийгээд тийм ээ, хөдөө малчид маань бас малынхаа арьс ширийг боловсруулж чадахгүй хаяж байгаадаа маш их бухимдалтай байгаа гээд бид нарын асуудлууд их байна. Гэтэл өнөөдөр энэ төсөв хэлэлцэж байгаа яг энэ үед энэ иргэдийн хүсээд байгаа зүйл өнөөдрийн бид нар хэлэлцэж байгаа төсөв 2 газар, тэнгэр шиг л ялгаатай байх юм. Өнөөдөр Монгол хүмүүс дунджаараа 3,5 сая төгрөгийн цалинтай болчихье л гээд байна шүү дээ. Хэрвээ ийм цалинтай болчихвол бүгдээрээ сайхан гараад, ажил хөдөлмөр хийгээд, л өндөр цалин аваад, халамж авахгүй харин ч халамжийн зардал чинь буурна шүү дээ. Гэтэл одоо ингээд л энийгээ хийчихгүй, дээрээс нь энэ ажил хөдөлмөр хийчих аж үйлдвэржилтийн паркуудаа ч тавьчихгүй ингээд л яваад байх юм. Нөгөө л нэг эрээлжилсэн олон жижиг зам, байшин, төслүүд л орж ирээд л байна. Ээлж дараагаараа. Хамгийн хортой нь энэ дотор нэг зүйл байгаа. Бид нар гишүүд өөрсдөө бас анхаарах хэрэгтэй байна. Эхлээд төсөвт өртөг дээр тавьсан төсөвт өртөг маань жилээс жилд шилжих хөрөнгө оруулалтад орж ирэхдээ өсөж орж ирээд байх юм. Сүүлийн 2023 он оноос хойш ерөөсөө 3 жилийн дотор 1,9 их наядаар өсчихлөө шүү дээ. Энэ төсөвт өртөг маань ингэж өсдөг байж болмооргүй байна. 1,9 их наяд төгрөг гэдэг бол бид нар бүх эмч, багш нарынхаа цалинг нэмээд, ахмадуудынхаа тэтгэврийг нэмээд, аж үйлдвэржилтийнхээ паркийг Эмээлт аж үйлдвэржилтийн паркаа ч юм уу эхлүүлээд, хэрвээ тэр аж үйлдвэржилтийн паркийг эхлүүлчих юм бол жилдээ 7 сая малын арьс ширээ бид нар боловсруулчихна, экспортод гаргачихна. Монгол Улсын төсөв дахиад нэмэгдэнэ. Орлого өснө. Энэ боломжоо бид нар өөрсдөө бараг байхгүй болгочхоод байх юм. Тэгэхээр бид нар энэ жилээс жилд орж ирж байгаа энэ шилжих хөрөнгө оруулалт дээр орж ирж байгаа энэ төсөвт өртөг нэмэгддэг байдлыг ер нь зогсоох боломж байх уу. Хуулийн ямар боломж байдаг юм. Хэрвээ нэмэгдэхээр бол инфляцын түвшнээр л нэмэгддэг байя. Түүнээс биш 3, 4 дахин төсөвт өртөг нь өрт нэмэгддэг ийм байдал чинь өөрөө бид нар Монгол Улсын татвараар орж ирж байгаа бүх орлогоо ийм дэмий зүйлд, ийм үрэлгэн зүйлд зарцуулах ийм шалтгаан болоод байна. Тэгэхлээр энэ тал дээр та бүгдийн саналыг сонсьё.

Б.Пүрэвдорж: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Ер нь тэгээд олсныхоо хэрээр үрдэг, урсгалаа багасгадаггүй. Тэгээд татвараар бүрдүүлж байгаа орлогоо нэрлэсэн ДНБ-ийхээ харьцааг буулгадаггүй. Ингээд төслүүдээ эрэмбэлдэггүй. Тэгээд шаардлагагүй санхүүжилтүүдийг хийдгээс болоод өнөөдөр тэгээд яг ийм байдалд очсон. Тийм учраас зүгээр миний хувьд бол сая шинэ Засгийн газарт анх удаа энэ төсвийн хүрээ, төсвийн бодлого хариуцах ийм үүрэг оногдлоо л доо.

Тийм учраас юу гэж зорьсон бэ гэхээр Сангийн сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд 2 бол их тийм харилцаа сайн байж ер нь болохооргүй ажил юм байна лээ. Ажлын онцлог бол. Тэр макро тоонуудаараа чанга бариад, тэрэнд нь төсвийг төлүүлж явах ёстой болохоос биш, Сангийн сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд 2 бол хэт найзын дундаа орвол нөгөө GDP-ийг нь хоосон нэмдэг, орлогыг нь хэт их өндөр тавиад, тэгээд нөгөө гаргаж байгаа экспортын бүтээгдэхүүнүүдийнхээ үнийг нэмээд, тэгээд тэндээ баахан юм шингээх гэж дайрсаар байгаад ингээд будаа болно.

Тийм учраас энэ удаагийн төсөв дээр яг таны хэлж байгаа энэ урсгал зардлыг л ер нь 24 хувьд барья л гэж их зорьсон юм. Урсгал зардлыг ингээд 24 хувьд барьчихаар цаашаа бол энэ улсын эдийн засаг өөрөө их эрүүлжинэ. Жишээ нь өмнө жил бараг 26,6 хувьтай байсан шүү дээ. Урсгал одоо бол ингээд 24 байхгүй юу. 2028 онд 22 байх ёстой. Гэтэл ингээд багш, эмчийн цалингаа нэмье гэхээр яг үнэндээ 24 чинь 25 хувь болоход л 1 их наядын орон зай гарахад яам дээр байгаа төрийн үйл ажиллагаа дээр таналт хийхэд 841 тэрбумыг гаргаж болох бололцоо байна л гэж ингэж үзээд байхгүй юу. Тэгэхээр нөгөө эдийн засгийнхаа яаж цаашаа эрүүл болгох вэ гэдгийг харъя гээд зориод л урсгалаа бариад, орлого, зарлагаа бууруулаад, тэгээд л тэр нэрлэсэн дотоодыг нийт бүтээгдэхүүн тэнцвэржүүлсэн орлогоо аваад, тэгээд суурь тэнцлийг 2 хувь эерэг байлгана гэж тооцоод, тэгээд л үзсэн. Тэгээд мэдээж ингээд багш, эмчийн цалин үнэхээр бага байгаа. Тийм учраас шийдэхээс өөр арга замгүй гэдгийг шаардаж байгаа учраас Засгийн газрын зүгээс бол явагдъя гээд төлөвлөж байсан ажлуудаа зогсооё. Тэгээд урсгалаасаа таная. Тэгээд яах вэ, жилийн төлөвлөгөөний 24-ийг 25 болгох. Ер нь бүгдээрээ ер нь төсөв дээр цаашдаа бол эдийн засгаа богино хугацаанд эрүүлжүүлье гээд хэдэн макро тоогоо хатуу бариад явах нь зөв юм байна л гэж дүгнээд байгаа юм.

Б.Пүрэвдорж: Бадамдоржийн Пунсалмаа гишүүн тодруулъя.

Б.Пунсалмаа: Уг нь бид нар урсгал зардал маань ДНБ-ий 30 хувь байхаар уг нь баталсан юм байгаа юм л даа. Тэгээд энэ жил бид нар 30 хувьдаа хүрэхгүй байгаад байгаа юм. Яагаад гэхээр энэ орлого чинь хангалттай бүрдэхгүй байна шүү дээ. Энэ татвар төлөгчид чинь бүр ингээд төлж чадах чинээ эндээ тулчхаад байгаа юм. Тэгэхээр ер нь татвар төлөгчдийн татвар төлөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд Хөдөө аж ахуйн яамнаас л би асуугаад байгаа юм л даа. Энэ аж үйлдвэржилтийн парк дээрээ бид нар дэмжих хэрэгтэй байна энэ төсвөөр. Тэгээд Эмээлт аж үйлдвэржилтийн парк дээр энэ жил олигтой юм тавигдаж чадсангүй. Тэгээд л би энийг асуугаад байгаа юм.

Хэрвээ Эмээлт аж үйлдвэржилтийн паркийг бид нар яг хугацаандаа оруулах юм бол 2027, 2028 онд орчих юм. 2027, 2028 онд орчих юм бол тэнд 7 сая малын арьс шир боловсруулагдана. Бид нар жилдээ 20 орчим сая мал арьс шир гаргаж байгаа гэж бодоход энэ бол бас багагүй тоо шүү. Тэгэхээр энэ дээрээ бид нар төсөв

дээрээ бас тодорхой хэмжээнд юм суулгаж чадахгүй байна. Та энэ тал дээр ер нь өөрийнхөө саналыг хэлээч.

Б.Пүрэвдорж: Учрал сайд хариулъя. Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Улсын Их Хурал маань Цагаан алт гээд томоохон үндэсний хөтөлбөр баталсан. Энэ арьс шир, ноос ноолуурын боловсруулалтын түвшнийг ахиулах зорилготой. Батлагдсан төсвийн хүрээнд ажил явж байна. 3 Аж үйлдвэрлэлийн паркийн ажил урагшилж байгаа.

1 дүгээрт Ховдынх. Ховдын төсөл дуусах шатад орж байна. Энэ жилийн 2026 оны төсөв дээр эцсийн мөнгөнүүд нь тавигдаад, дуусна буюу Ховдын үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтэц бүрэн дуусна. Үүнтэй холбоотойгоор хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд тэнд хөрөнгө оруулах, газар олгох, үйлдвэрлэл явуулах шаардлагатай бүх дэд бүтэц хангагдсан ийм боломж үүснэ.

2 дугаарт. Улаанбаатар хот, Эмээлт. Монгол Улсад 27 арьс ширний үйлдвэр байгаа юм. Түүний 24 нь Улаанбаатар хотын суурьшлын бүс дотор орчихсон байгаа юм. Тэгээд энийг гаргах үүднээс Эмээлтийн аж үйлдвэрийн паркийг Нийслэлийн төсөвт.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж тодруулъя. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Ж.Энхбаяр: Нийслэл Улаанбаатар хотод байгаа 24 арьс ширний үйлдвэрүүдийг суурьшлын бүсээс гаргах бодлогын хүрээнд Эмээлтийн аж үйлдвэрлэлийн паркийн ажил явж байгаа. 24Мвт-ын цахилгаан, дулааны станц, цэвэрлэх байгууламж, холбогдох дэд бүтэц нийт 235 байсан байх тэрбум төгрөгийн төсөв нийслэл хотын төсөв дээр суугдаад, ажил явагдаж байгаа.

3 дахь нь Дархан хот. Дарханд хөнгөн үйлдвэрлэлийн төвлөрөл байгаа. Дараагийн гол төв. Дарханд үйлдвэр технологийн паркийн ажил явж байгаа. Өнгөрсөн жил 7 тэрбум төгрөгийн эх үүсвэр суусан. Түүгээр үйлдвэр технологийн парк хүрэх замын ажил тавигдаад дуусаж байна. Энэ жилд 2026 оны төсөв дээр 8 тэрбум төгрөгийн эх үүсвэр баталж өгсөн. Үүгээр эрчим хүчний асуудал явагдана. Тэнд нийт 25 га газарт хувийн хэвшил хөрөнгө оруулалт хийх газар үнэгүй олгогдоно. Хөрөнгө оруулалтын хөнгөн хүнсний үйлдвэрүүдэд зориулж олгогдож байгаа. Ийм л хэмжээнд байгаа төсвийн хэмжээнд ийм байна. Уг нь жоохон/минут дуусав/

Б.Пүрэвдорж: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хууль тогтоолын төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. Индэрт Эрдэнэболд гишүүн, дараа нь Саранчулуун гишүүн байгаа шүү. Үг хэлэхгүй юм уу тээ. Эрдэнэболд гишүүн үг хэлье.

С.Эрдэнэболд: Өнөөдөр яг энэ асуудал дээр 4 асуудал хэлэлцэж байгаа.

1 дүгээрт нь болохоороо Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа;

2 дугаарт татвар;

3 дугаарт бол нэмэгдсэн өртгийн албан татвар;

4 дүгээрт нь 2 тогтоол гэсэн асуудлууд хэлэлцэж байгаа. Тогтоолын нэгд нь болох юм бол бондтой холбоотой, 2 дугаарт нь бол Үндэсний баялгийн санг дэмжих. Учрал сайд аа, энэ бас танд хандаж хэлж байгаа үг. Тэгэхээр зарчмын хувьд бол дэмжиж байгаа. Ер нь бол бид нар цаг хугацаа тулчихлаа. Өнөөдөр 10 сарын 24 гэдэг маань бол 20 хүрэхтэй үгүйтэй хоногийн дараа гэхэд төсвөө батлах ёстой. Үндсэндээ бол сүүлийн сар гаруй Монгол улс асар их улс төржсөн. Ялангуяа төрийн ордон бол хөл хөдөлгөөн ихтэй байлаа. Гэхдээ энэ бол том зургаараа улсад хэрэгтэй, ач холбогдолтой үйл явдал болж байгаа гэж харж байгаа.

Яагаад гэхлээр ер нь бол хэн нь ямар зарчим баримталж байгаа юм. Хэн нь Үндсэн хууль, парламентын засаглал хийгээд ардчилсан, чөлөөт нийгмийнхээ үзэл санаанд тууштай байгаа юм. Хэн нь болох юм бол сандал суудал, явцуу ашиг сонирхлын төлөө үзэл бодлоо илэрхийлж байгаа юм бэ гэдгийг нь ус тосоороо ялгарсан мөчүүд болж байна. Үр дүнд нь ер нь энэ олон жил ужгирсан, удсан, ялзарсан хулгай нь Монгол Улсын ядуурлын шалтгаан, авлига, хээл хахуулийн үндэс болоод байгаа гэдгийг олон нийт танин мэдэхэд асар чухал, хэрэгтэй зүйл болж байна. Энэ утгаараа бол ач холбогдолтой.

Гэхдээ одоо цаашлаад Монгол Улсын хамгийн том эрх ашиг бол үндэсний язгуур ашиг сонирхол. Энэ танхимд сууж байгаа хууль тогтоогч нар бүгдээрээ 2024 оны 7 сарын 2-ны өдөр тангараг өргөсөн. Энэ тангарагтаа үнэнч зүтгэх шаардлагатай болсон. Тэгэхээр саяын асуулт хариултын зүгээс бас тодорхой харагдахгүй байгаа зүйл нь болохлоор өнгөрсөн жил Засгийн газар байгуулсан. Тэр Засгийн газрын бодлогыг энэ Засгийн газар үргэлжлүүлээд авч явж байна гэж ойлгож байгаа. 578 зүйл заалттай мөрийн хөтөлбөр, 11 хэмжих нэгжээр хэмжигдээд явж байгаа. Тэгэхээр ингээд Үндэсний баялгийн санг бүрдүүлэх уул уурхайгаас орж ирж байгаа тэр баялгийн сангийн тухай ярьж байгаа юм. Тэгэхээр тэгэхээр Ерөнхий сайд бол саяхан ямар мэдэгдэл гаргасан бэ гэхээрээ нүүрсний хулгайн асуудлыг ярьж байгаа юм. Нүүрсний хулгай энэ далд эдийн засгийг яаж өөгшүүлсэн, үүнтэй тэмцэнэ. Тэгэхийн тулд Энхбаяр гишүүнийг Хуулийн сайдаар томилно гэдэг асуудал гарч байгаа. Өнөөдөр хэлэлцэх асуудал нь 4-д ороод явж байгаа.

Тэгэхээр энэ дээр яг би тодорхой юм асуух гээд байгаа юм. Иргэдэд юу ойлгомжтой, ойлгомжгүй байна гэхээрээ ер нь энэ бүх зүйл чинь ингээд улс төржилт юм уу, яг зарчмын шаардлага хийгээд, ажил хэргийн хандлага юм уу гэдгийг ялгах хэрэгтэй болчихоод байгаа юм. Тийм учраас засаг энэ төсөв, төсөв дагасан хууль, төсвийн хүрээ орж ирэнгүүт араас нь дагасан хуулиудын асуудлыг тэр болгон анзаарахгүй. Өнөөдөр чуулганы танхимын тал нь эзгүй байж байгаа. Энэ дээр яах вэ гэхээрээ үнэхээр энэ нүүрсний асуудал чинь хэдэн их наядаар хэмжигдэж байгаа энэ хулгай зэлгийн асуудал чинь энэ Үндэсний баялгийн санд төвлөрөх ёстой байсан тэр орлого, тэр мөнгөн сангийн хувьд ямар хэмжээний lost opportunity гэж хэлдэг алдагдсан боломж болоод байгаа юм бэ. Одоо энэ яриад байгаа зүйлүүдээ тал талаас нь яг энэ тооцоо судалгаа үндэслэлтэй аргумент болгож хэлмээр байна.

2 дугаар асуудал надад одоогийн байдлаар 500 орчим мессеж ирсэн. Та бүхэнд бас ирсэн байх Их Хурлын гишүүд ээ, багш нараас өдөр болгон ирж байгаа. Зарим нь учирлаж бичиж байна. Зарим нь цөхөрч бичиж байна. Зарим нь уурлаж бичиж байна. Гэхдээ энэ бүх зүйлийг бид нар сонсох ёстой. Тэгэхээр ер нь бол багш нарын цалин, эмч нарын цалин, ахмадуудын тэтгэврийн асуудлуудыг Засгийн газар

үе шаттайгаар нэмье гэдэг байр суурьтай байгаа. Тэгвэл тэрнийхээ эх сурвалжуудыг нь маш тодорхой болгох ёстой. Өчигдөр зарим гишүүн тэр эмч нарын цалинг 50 хувиар нэмэгдүүлэхийг Төсвийн байнгын хороогоор дэмжүүлээ гэж яриад байгаа. Тэгэхээр энэ мэт асуудлууд дээрээ гарц шийдэл, тооцоо судалгаагаа Засгийн газар луу танилцуулмаар байна. Хурал даргалагчаа 1 минут нэмээд авчихъя.

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минут.

С.Эрдэнэболд: Тэгэхээр урт хугацааны бодлого бол ойлгомжтой байгаа. Монгол Улсад хөгжлийн богино, дунд, урт хугацааны нийт 11 бодлогын бичиг баримт байгаа. Тэгэхээр яг өнөөдөр бодит байдал дээрээ морь унасан толгойгүй хүн шиг, нөгөө талд хөгжлийн бодлогын бичиг баримтууд, шийдвэр гаргах тооцоо, судалгаа үндэслэлүүдээ ор тас умартаад, зөвхөн улс төрийн нөхцөл байдалд тохируулж тааруулж явж байна. Энэ дээрээ бас Засгийн газар анхаармаар байна. Тэгэхээр төлөөлж сууж байгаа учраас Тэргүүн Шадар сайдад хэлэхэд ер нь энэ тооцоо судалгаа, үндэслэл гэдэг юмаа гаргаж ирж тавимаар байна.

Тэгээд Монгол Ардын намын бүлгийн гишүүддээ хэлэхэд улс төрийн асуудлаа жоохон хойш нь тавимаар байна. Улс орны өмнө тулгамдсан байгаа шийдэл хүлээсэн асуудлууд дээрээ ажил хэрэгч зарчмын байр суурьтай явмаар байна. Энэ бүх асуудал дээрээ та бүхэн анхаараач ээ. Өргөсөн тангарагтаа үнэнчээр Монгол Улсын нийт иргэдийн эрх ашгийн төлөө шийдвэр гаргаач ээ гэж уриалмаар байна.

Б.Пүрэвдорж: Би уул нь асуултад байсан юм. Тэгэхээр үг хэлчихье.

Тэгээд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл бас явж байгаа. Тэгэхээр энэ дээр 5 хувийн буцаалтын асуудал явж байгаа байх. Тэгэхээр ер нь бол энэ нэмэгдсэн өртгийн албан татварыг 5 хувь болгох хуулийн төслийг би өөрөө өргөн барьсан. Гэвч Монгол Ардын нам 1 удаа хэлэлцээд, 2022 онд унагаасан байгаа. Дахиад өргөн барьсан. Тэгэхээр энэ нэмэгдсэн өртгийн албан татвар яагаад өнөөдөр хэрэгжихгүй байна вэ гэхээр Монгол Улс 2 зах зээлээс бараа бүтээгдэхүүн орж ирж байна. Нэг нь бол малчид хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн орж ирж байна. Малчид, тариаланчид болон бусад. Тэгэхээр энэ дээр ихэнх нь яаж байна гэхээр малчдаас жишээ нь малын ноос, ноолуур, арьс шир, сүү, мах энэ тэр нь НӨАТ төлөгдсөн гэж орж ирсэн боловч яг жишээ нь махны үйлдвэр дээр мах очлоо гэхэд дараагийн ресторан руу мах явдаг ч юм уу, аль эсвэл хиамны үйлдвэр лүү явдаг юм уу. Тэгэхдээ НӨАТ-гүй, НӨАТ-тай гээд ингээд л явчхаж байна. Энэ юунаас болж байна вэ гэхээр НӨАТ-ын татвар өндөр учраас зах зээл рүү энэ НӨАТ-гүй бараа бүтээгдэхүүн бүгдээрээ орж ирж байна.

Дээрээс нь бид нар ихэнх бараагаа Хятадаас авдаг. Замын-Үүдээр орж ирж байгаа бараа бүтээгдэхүүнүүд дандаа ерөөсөө ширхэгчлэн бүрдүүлэлт хийгддэггүй. Хамгийн өндөр жинтэй, хамгийн хүнд жинтэй, овор ихтэй барилгын материалаар ихэнх нь цемент гээд л ороод ирдэг. Тэгээд орж ирсэн бараанууд бүгдээрээ яаж байна вэ гэхээр Нарантуул дээр очдог. Нарантуулаасаа Монгол Улсын өнцөг булан бүрд тархахдаа бүгдээрээ анхнаасаа бүртгэгдэж орж ирээгүй учраас бүгдээрээ НӨАТ-гүй гээд явчихдаг. Жишээ нь 1 барилгын компани 2000 гаруй ажилчныг ажиллуулж байна. Гэтэл тэр доод талын туслан гүйцэтгэгч хийж байгаа 20 гаруй компани бүгдээрээ НӨАТ-гүй л бүх бараа үйлчилгээг хийж байгаа. Тэгэхээр ингээд

энэ НӨАТ-ын татвар чинь өндөр байгаа учраас ерөөсөө энэ бараа бүтээгдэхүүнийг бүртгэх энэ татвар чинь ерөөсөө хэрэгжихгүй байгаад байна. Зах зээл дээр тэр чигээрээ НӨАТ-гүй бараа бүтээгдэхүүн ингээд үйлчилгээ явчхаад байна.

Тийм учраас энэ НӨАТ-ын татвар өндөр байгаа учраас энэ татвар чинь компаниудыг эргэлтгүй, хөрөнгөгүй ийм нөхцөл байдал руу аваачиж байгаа учраас энэ НӨАТ-ын татварыг 5 хувь болгож багасгаад, тэгээд харин тэрийгээ яс төлдөг. Бүх хүмүүс бараа үйлчилгээгээ бүртгүүлдэг. Үүний үр дүнд татварын бааз суурь нэмэгдэх замаар, мөн түүнчлэн бусад бараа бүтээгдэхүүнийг бүртгэх тэр үндсэн үүргээ хэрэгжүүлсний үндсэн дээр ер нь татварын хураалт чинь илүү өснө гэдэг ийм эдийн засгийн тооцоолол гарсан байгаа. Тийм учраас энэ татварын буцаалт буюу 5 хувь чинь ерөөсөө явахгүй.

Хөдөө Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум дээр 15 дэлгүүр байгаа. 15 дэлгүүрийн 1 нь алдаг оног НӨАТ-ын баримт өгч байгаа. Тэгээд үлдсэн бүх дэлгүүрүүд нь бүгдээрээ НӨАТ-ын баримт өгдөггүй. Тийм учраас хүн амын чинь тал хувь буюу хөдөө орон нутагт амьдарч байгаа тэр хүмүүс бол бүгдээрээ НӨАТ-гүй бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ авч байна шүү дээ. Тийм учраас тэр НӨАТ-ын баримт байхгүй, НӨАТ-ын баримт өгөхгүй учраас НӨАТ-ын сугалаанд оролцохгүй, шивэлт байхгүй, НӨАТ-ын буцаан авалт байхгүй хэсэг хүмүүс нь ингээд 2 хувиа ерөөсөө хүртэхгүй байна шүү дээ. Тэгэхээр энэ 5 хувь чинь ерөөсөө хүртэхгүй. Улаанбаатар хотод яах вэ, бараа, үйлчилгээ авсан хүн болгон НӨАТ-ын баримтаа аваад, шивээд болж байх шиг байна. Гэтэл энэ 5 хувийн буцаалт боллоо гэхэд буцаад энэ Монголын ард түмний тал нь энэ хуулийн хэрэгжилтэд хамрагдаад, тал нь хамрагдахгүй ийм нөхцөл байдал руу бол очно шүү дээ. Тэгээд тийм учраас энэ дээрээ би зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа. Тэгээд Байнгын хороон дээрээ санал хураалгана.

Ингээд хэлэлцэх асуудлын санал хураалтыг ирц хангалтгүй байна. Тийм учраас түр хойшлуулъя.

12.08 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдааны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэг танилцуулна. Индэрт урья.

П.Батчимэг: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Улсын Их Хурал хэлэлцэж, Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар

хэлэлцэж гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн хамтарсан хуралдаанаараа дээрх хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хийж, хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1.4-д заасны дагуу нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсөлд нэмж тусгасан төслийн эцсийн хувилбарыг танилцуулгын хамт та бүхэнд хүргүүлсэн.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар дээрх хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хийх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд өөрчлөгдсөн байгааг тодруулж, хэрэглээний үнийн өсөлтийн түвшин 7 хувь байсныг 7,5 хувь болгож өөрчлөгдсөн талаар болон ахмад настны тэтгэвэр, эмч, багш нарын цалинг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор төсвийн урсгал зардал өөрчлөгдсөн тохиолдолд төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүд дахин өөрчлөгдөх эсэх, Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд нэгдсэн төсвийн орлого, зарлагыг тус тус 490 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагуудыг хангасан эсэх, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлттэй танилцаж, энэ асуудлаар эргэн хэлэлцэх боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа инфляц 7,5 хувь болж өссөнтэй холбоотойгоор Монголбанкнаас инфляцыг бууруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн талаар, мөн уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит хуулийн этгээдүүдийн улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашиг Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татварын талаар асуулт асууж хариулт авлаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулж, төслийн эцсийн хувилбарыг бэлтгэсэн талаарх танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Батчимэг гишүүнд баярлалаа. Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гарсан санал, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төсвийн тусгай шаардлагад нийцсэн эсэх талаарх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг Зөвлөлийн дарга Намжилдоржийн Энхбаяр танилцуулна. Индэрт урьж байна.

Н.Энхбаяр: Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн хүрээний мэдэгдлийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулахад Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан санал нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн тусгай шаардлагад нийцсэн эсэх талаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүгнэлт

гаргаж, нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэгтэй гэж Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 164.1.5-д заасан.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дугаар хэлэлцүүлгийн явцад Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд дэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ 2026 онд 31 их наяд 600 тэрбум төгрөг гэснийг 490 тэрбум төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 2026 онд 32 их наяд 980 тэрбум төгрөг гэснийг 490 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, үүнтэй уялдуулан холбогдох эдийн засгийн үндсэн үзүүлэлт болон харгалзах ДНБ-д эзлэх хувьд өөрчлөлт оруулах тухай зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбоотой дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх. Зарчмын зөрүүтэй саналын тухайд.

Төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх.

Санал болгосон өөрчлөлт нь орлогын дүнг өсгөх тухай бөгөөд нэмэгдэл орлогын эх үүсвэрийг тодорхойлоогүй, орлогыг тооцох аргачлалд шууд нөлөөлөхгүй байна.

Төсвийн урсгал зардал ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй байх.

Санал болгосон өөрчлөлт нь эдийн засгийн нийт эрэлтийг өсгөх, нийт нийлүүлэлтийг багасгах буюу өөрчлөхгүй байх, бодит ДНБ-ийг бага зэрэг өсгөх, үүн дээр эрэлтээс улбаалсан үнийн өсөлтөөр дамжин нэрлэсэн ДНБ өсөх макро эдийн засгийн нөлөө үзүүлэхээр байна. Тус нөлөөг боломжит дүнгээр тооцоход 2026 онд төсөөлсөн 102,4 их наяд төгрөгийн ДНБ-ээс 512 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна. Энэ тохиолдолд санал болгосон өөрчлөлт нь Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал зардлын ДНБ-д эзлэх хувийг 24,8 хувь болгон өөрчилж байгаа нь 30 хувийн дотор байх хязгаартай байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн суурь тэнцэл ДНБ-ий 2 хувь болон түүнээс дээш ашигтай байх.

Тэнцвэржүүлсэн орлого болон төсвийн урсгал зардлыг ижил дүнгээр өсгөх нь зээлийн ашиглалтад нөлөөлөхгүй тохиолдолд суурь тэнцлийн дүнд нөлөө үзүүлэхгүй буюу суурь тэнцэл хуулийн төсөл дээрх 2 их наяд 48 тэрбум төгрөг хэвээр үлдэхээр байна. Харин нэрлэсэн ДНБ-ийг 512 тэрбум төгрөгөөр өсгөх бөгөөд энэ тохиолдолд суурь тэнцлийн ДНБ-д эзлэх хувь 1,9 хувь болж төсвийн суурь тэнцэл 2 хувийн ашигтай байна гэсэн шаардлага зөрчигдөхөөр байна.

Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээрх үлдэгдэл ДНБ-ий 50 хувиас хэтрэхгүй байх.

Санал болгосон өөрчлөлт нь Засгийн газрын өрийн үлдэгдэлд шууд нөлөөлөхөөргүй байна. Харин нэрлэсэн ДНБ-ийг бага зэрэг өсгөх буюу тус харьцаа өргөн мэдүүлсэн төслийнхөөс илүү буурах буюу 60 хувийн хязгаар дотроо байна.

2 дугаарт Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн төсөлд үзүүлэх нөлөөллийн тухайд.

2.1. Төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх.

Төсвийн хүрээний мэдэгдэл дэх орлогын доод хэмжээг нэмэгдүүлснээр төсвийн төсөл нь төсвийн хүрээнд нийцтэй байх ёстой гэсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5.1.3 дахь заалтын дагуу 2026 оны Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогыг хамгийн багадаа 490 тэрбум төгрөгөөр өсгөх шаардлагыг үүсгэж байна.

2 дугаарт төсвийн урсгал зардал ДНБ-ий 30%-аас хэтрэхгүй байх.

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1.7-д улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. Ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно гэсэн.

Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 71.7.2 дахь заалтын дагуу Улсын Их Хурал төсвийн нийт зарлагыг нэмэгдүүлэх эрх зүйн боломжгүй. Иймээс төсвийн хүрээний мэдэгдэл дэх зарлагын дээд хэмжээг 490 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн ч 2026 оны нэгдсэн төсвийн төсөлд тусгагдсан зарлагын хэмжээгээ өсгөх боломжгүй байна.

Санал болгосон өөрчлөлтөөр нэрлэсэн нь ДНБ-д үзүүлэх цэвэр нөлөөг баримжаалан тооцвол 2026 оны нэрлэсэн ДНБ хуулийн төсөлд тусгагдсан дүнгээс 307,2 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна. Энэ тохиолдолд санал болгосон өөрчлөлт нь нэгдсэн төсвийн урсгал зардлын ДНБ-ий эзлэх хувийг 24,8 хувь болгож, 30 хувийн хязгаар дотор байна гэсэн хязгаарт бол багтахаар байна.

3. Монгол Улсын нэгдсэн төсвийн суурь тэнцэл ДНБ-ий 2 хувь болон түүнээс дээш хувийн ашигтай байх.

Санал болгосон өөрчлөлт нь 2026 оны нэгдсэн төсвийн хувьд тэнцвэржүүлсэн орлогыг 490 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх, нийт зарлага, цэвэр зээлийн дүнг үл өөрчлөх, мөн дүнгээр гадаад зээлийн ашиглалт буурах, зарлагад орох тус орон зайгаар урсгал зардлыг нэмэгдүүлснээр суурь зарлага мөн дүнгээр өсөх учир 2026 оны Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөл дээрх суурь тэнцлийн нэрлэсэн дүнд өөрчлөлт гарахгүй. Улмаар нэрлэсэн ДНБ-д гарах 307 тэрбум төгрөгийн өөрчлөлтөөс үүдэн суурь тэнцэл ДНБ-ий 1,9 хувийн ашигтай болж, тусгай шаардлага хангагдахааргүй нөхцөл үүсэхээр байна.

4. Засгийн газрын нэрлэсэн дүнгээрх үлдэгдэл ДНБ-ий 60 хувиас хэтрэхгүй байх төсөв нь төсвийн хүрээнд нийцэх тухай Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5.1.3 дахь заалтын дагуу санал болгосон өөрчлөлт нь төсвийн орлогыг нэмэгдүүлж харин Улсын Их Хурал төсвийн зарлагыг нэмэгдүүлэхгүй байх Монгол Улсын Үндсэн хуулийн 25.1.7 дахь заалтын дагуу төсвийн зарлагад өөрчлөлт

орохгүй тул гадаад зээлийн ашиглалт буурч, Засгийн газрын өрийн үлдэгдэл ДНБ-ний 60 хувийн хязгаар дотроо хадгалагдахаар байна.

Дүгнэлт.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зүгээс Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар дэмжигдсэн зарчмын зөрүүтэй санал нь 1 дүгээрт төсвийн хүрээний мэдэгдлийн хувьд ДНБ болон суурь тэнцлийн нэрлэсэн дүнд нөлөө үзүүлэхгүй боловч төсвийн хүрээний мэдэгдэл дэх суурь тэнцэл нь ДНБ-ий 2 хувь буюу түүнээс дээш хувьд ашигтай байх төсвийн тусгай шаардлагыг зөрчих.

2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн төслийн хувьд ДНБ төсвийн орлогод болон зарлагын бүтцэд үзүүлэх нь нөлөөнөөс үүдэн төсвийн төсөлд тусгагдсан суурь тэнцэл ДНБ-ий 2 хувь буюу түүнээс дээш хувийн ашигтай байх төсвийн тусгай шаардлагыг зөрчих.

3.Төсвийн хүрээний мэдэгдлийн дагуу төсвийн зарлагыг өөрчилж болзошгүй байдал нь Монгол Улсын Үндсэн хуулийн 25.1.7 дахь заасан заалттай зөрчилдөх нөхцөлүүдийг үүсгэж болзошгүй байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 65.1.5-д заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлгээр дахин хэлэлцүүлэхээр холбогдох Байнгын хороод буцаах нь зүйтэй гэж үзэж байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Намжилдоржийн Энхбаяр даргад баярлалаа. Тэгэхээр энэ төсөв хэлэлцэж байх явцад ер нь бол Засгийн газрын оруулж ирсэн зардал болон орлогыг бол тэнцүүлэх зайлшгүй шаардлагатай. Тэрнээс илүү юм уу, дутуу гаргах илүү гаргаж болохгүй зардлыг. Гэтэл Их Хурлын гишүүд янз бүрийн санал гаргаад буцаагаад, зардал бууруулах саналаа ерөөсөө гаргахгүйгээр зардлыг нэмэгдүүлэх ийм санал хураалтыг маш их явуулсан.

Та нар хэрвээ зардал нэмэгдүүлэх гэж байгаа бол манай Бямбасүрэн гишүүн, Цэнгүүн гишүүн, Лодойсамбуу нарын гишүүд маш их олон саналуудыг өөрөөр хэлбэл тэвчиж болох зардлуудыг хасах санал гаргасан байгаа. Тэрийг илүү дэмжиж болох байхгүй юу. Тэгж байж өөрсдийнхөө нэмэгдүүлэх гэж байгаа тэр зардлуудыг, шаардлагатай зардлуудыг нэмэгдүүлэх ийм зарчмын зөрүүтэй саналыг гаргах ёстой.

Гэвч харамсалтай нь бууруулах саналаа гаргахгүйгээр зардал нэмэгдүүлэх саналуудыг маш их гаргасны үндсэн дээр орлого, зарлага тэнцвэржихгүй байх ийм нөхцөл байдал руу очиж байна.

Тэгээд яг энэ асуудал дээр Ерөнхий нарийн бичгийн дарга Баасандорж 1 номер. Дэгийн хуулийг танилцуулъя.

Б.Баасандорж: Саяын Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг Энхбаяр дарга уншиж танилцуулсан. Тэгээд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тусгай 4 шаардлагыг заасан. Энэ тусгай 4 шаардлагын 1-ийг зөрчсөн байна гэдэг дүгнэлтийг сая уншиж танилцууллаа.

Тэгэхээр манай Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлд Төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэх зохицуулалт байгаа. Энэ дэгийн хуулийн 64.1.5 дээр “нэгдсэн хуралдаанаар гурав дахь хэлэлцүүлгийг явуулахад хамтарсан хуралдааны танилцуулгатай холбогдуулан гишүүд асуулт асууж болох бөгөөд санал хураалт явуулахгүй. Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гарсан санал Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн тусгай шаардлагад нийцсэн эсэх талаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд дүгнэлт гаргаж, нэгдсэн хуралдаанд танилцуулна. Төсвийн тусгай шаардлага хангагдаагүй нөхцөл үүссэн тохиолдолд тодорхой асуудлаар чиглэл өгч, хоёр дахь хэлэлцүүлгийг дахин явуулахаар Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодод хуралдаан даргалагч төслийг буцааж болно.” гэсэн манай дэгийн хууль дээр ийм зохицуулалт байгаа. Пүрэвдорж дарга аа.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Тэгэхээр энэ орлого, зарлага тэнцүү байх ёстой. Энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг зөрчиж байгаа. Тийм учраас энэ хуулийг би нэрээр нь уншаад өгье.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт буцаалаа. Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо энэ асуудлаар хуралдаж, шийдвэр гаргана.

12.23 цаг.

Одоо чинь 3 дахь асуудал тийм ээ. Дараагийн асуудалд оръё.

“Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” асуудлыг оруулж байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Материалаа өгчхөөрэй.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22.1.3-д Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 22.1.1, 22.1.2-т заасны дагуу ирүүлсэн саналыг нэгтгэн нам, эвслийн бүлэгтэй зөвшилцөж, Байнгын хорооны бүрэлдэхүүний талаарх саналаа нэгдсэн хуралдаанд танилцуулах гэж заасны дагуу зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол.

“Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны

дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргалыг Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс хасаж, Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны гишүүнээр баталсугай.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоол байна.

Санал хураалтыг үдээс хойш нэгтгэж явуулъя.

12.26 цаг.

Хэлэлцэх асуудал 4 дэх асуудал. 4 дэх асуудалд гишүүдийн санал хураалтаар энэ асуудал орсон байгаа. Засгийн газрын гишүүнийг танилцуулах тухай асуудал.

Гэтэл материал нь бэлтгэгдээгүй, хуралдаан даргалагч дээр ирээгүй байна. Тэгээд одоо 12 цаг 30 минут болж байна. Үдээс өмнөх хуралдааныг завсарлууллаа.

12.26 цаг.

ЗАВСАРЛАГА.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан эхэллээ. Танилцуулах асуудал 4.

Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг огцруулах, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулга. Би энийгээ танилцуулаадахъя. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг огцруулах, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсоно.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Бат-Эрдэнэ дарга үг хэлнэ.

Ж.Бат-Эрдэнэ: Бид нар үндсэндээ бол Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гарч, 2025 оны 10 сарын 22-ны өдрийн дүгнэлт гарсан. Мэдээж Уулсын Их Хурал хууль дээдлэх гэдэг утгаараа бол энэ дүгнэлтийг хүлээж авч байгаа. Энийг бол бүгдээрээ мэдэж байгаа. Тэгээд өглөөнөөс хойш бид нар нэг зүйлд л маргалаа шүү дээ. Энэ дүгнэлт гарсантай холбогдуулаад өнөөдрийн чуулганыг бид нар бас арай ондоогоор хуралдах ёстой гэж бодож байгаа. Өөрөөр хэлбэл 10 сарын 17-ны өдрийн чуулганы хуралдаан ирцтэй юу, үгүй юу. Тэр хуралдаанаар хэлэлцсэн бид нарын асуудлууд, төсөвтэй холбоотой асуудлууд, төсвийн хүрээний мэдэгдэл гэх зүйлүүд чинь үндсэндээ бол хүчингүй болоод байна шүү дээ. Тэгэхээр бид цааш цаашдаа Үндсэн хуулиа зөрчихгүйн тулд, энэ дүгнэлтийг хүлээж авахын тулд энэ хуралдааныг түр завсарлуулах шаардлагатай байна л гэж үзэж байгаа юм. Энэ дүгнэлтийг би та бүхэнд нэг уншаад танилцуулаадахъя.

Энэ хамгийн сүүлийн хуудсан дээр 36 дугаар хуудсан дээр. Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “хууль, зарлиг Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцээгүй гэж Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргавал зохих хууль, зарлиг, батламж, шийдвэр хүчингүй болно.” гэж заасныг хэрэгжүүлэх шаардлагатайг дурдах нь зүйтэй гэсэн байна. Хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ юу хэлж байна гэхээр Цэц бол тогтоол гаргаагүй, дүгнэлт гаргачихсан. Дээрээс нь өнөөдрийн энэ гаргасан тогтоолууд хүчингүй болно гэдгийг Улсын Их Хурал өөрсдөө шийдвэрлэ гэсэн ийм утга агуулж байгаа энэ дээр. Өөрөөр хэлбэл хүчингүй болно гэж заасныг хэрэгжүүлэх шаардлагатай гэж байгаа шүү. Улсын Их Хурал энийг хэрэгжүүлэх шаардлагатай. 1.

2 дугаарт түрүүн Пүрэвдорж дарга бас хэлсэн. Хурлаа эхлэхэд, 17-ны өдрийн хуралдааны ирц маргаантай байгаа. Өөрөөр хэлбэл 17-нд хэлэлцсэн бүх асуудлууд маргаантай болж байгаа. Дээрээс нь ирцтэй холбоотой асуудал Цэц нэг зүйлийг гаргаад тавьчих шиг боллоо. Идэвхтэй үйлдэл, идэвхгүй үйлдэл гэсэн нэг зүйлийг гаргаад тавьчихлаа. Өнөөдөр яг энэ ирцтэй холбоотой өнөөдөр яг идэвхтэй нь юм уу, идэвхгүй нь юм уу гэдэг асуудлууд бий болчихлоо. Энэ мэтчилэн нэлээн маргаантай зүйлүүдийг, өөрөөр хэлбэл бид нар Дэгийнхээ хуульд Цэцэд нэгэнт гарсан шийдвэр байгаа бол энэ шийдвэрийг хэдүүлээ хэрэгжүүлээд, Дэгийнхээ хуульд тодорхой хэмжээний өөрчлөлт оруулаад, Улсын Их Хурал цаашаагаа зөв зүйтэй, өөрөөр хэлбэл дахин хууль зөрчихгүй байх ийм нөхцөлийг бид нар бий болгох шаардлагатай. Нарийн яривал Пүрэвдорж дарга өнөөдөр хэд хэдэн дэг зөрччихлөө. Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн хуралдааны тов дараалал тогтоох баримтлах журмын, өөрөөр хэлбэл Дэгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн хэд хэдэн заалтыг өнөөдөр Пүүжээ дарга маань зөрччихлөө. Пүрэвдорж дарга зөрччихлөө. 1.

2 дугаарт, үүнтэй холбоотой магадгүй Цэцэд өгөх асуудлууд ч цаана чинь яригдаж байгаа. Түрүүн Пүүжээ дарга өөрөө хэлсэн шүү дээ. Энэ асуудлуудыг хойшлуулбал яасан юм бэ гэсэн горимын санал гаргасан. Мэдэхгүй, яагаад больчихов. Горимын саналыг тэгээд буцаад дахиад цаашаа явчхаж байгаа юм. Тэгэхээр Пүрэвдорж дарга бол үндсэндээ бас дэг зөрчөөд байгаа гэдгийг бол мэдэж байна. Өнөөдөр энэ хуралдааныг Пүрэвдорж дарга удирдах эрх зүйн орчин бүрдээгүй. Тогтоол байхгүй. Энэ тогтоол Булгантуяа дарга дээр байж байгаа. Тэгэхээр энийг бид нар засаад цаашаа явах ёстой шүү дээ. Өөрөөр хэлбэл Пүрэвдорж даргад дахин Булгантуяа дарга .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Засгийн газрын гишүүнийг огцруулах томилох тухай асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд Үндсэн хуульд заасан онцгой бүрэн эрхийнхээ дагуу Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаярыг Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдаар томилох шийдвэр гаргаж байгаагаа олон нийтэд мэдээлсэн.

Улмаар энэ асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгчид албан ёсоор танилцуулсан. Мөн Монгол Улсын Их Хуралд танилцуулахаар 2025 оны 10 дугаар сарын 1-ний өдөр Засгийн газрын 1/111 тоот албан бичгээр хүргүүлснээс хойш эдүгээ 24 хоног өнгөрөөд байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх хэсэгт заасны дагуу Лхагвын Мөнхбаатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх болон Баттөмөрийн Энхбаярыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар томилох асуудлыг Улсын Их Хуралд үүгээр танилцуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар томилох Баттөмөрийн Энхбаярын дэлгэрэнгүй намтрыг Улсын Их Хуралд хүргүүлсэн албан бичгийн хавсралтаар хүргүүлсэн болно.

Баттөмөрийн Энхбаяр нь улсад нийт 27 жил ажилласан бөгөөд 2016-2018 онд Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд, 2023-2024 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар тус тус ажилласан туршлагатай.

Харин 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дараа хамтарсан шинэ Засгийн газар байгуулагдсан тул Энхбаяр нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын албан тушаалаас чөлөөлөгдсөн.

Эрхэм гишүүд ээ,

Баялгийн хулгай, нүүрсний хулгайг таслан зогсоож, учирсан хохирлыг арилгаж, гэм буруутайд хуулийн хүрээнд хариуцлага тооцож, далд эдийн засгийг бууруулж, эдийн засгийн өсөлтийг хангаж, багш, эмч нарынхаа тэтгэвэр, тэтгэмж авагчдынхаа цалин хөлсийг шаардлагатай түвшинд хүртэл нэмэгдүүлж, улсынхаа эдийн засгийг сэргээж ард түмний нийтлэг эрх ашгийг хангах нь бол бидний бас туйлын зорилго юм.

Тиймээс далд эдийн засгийг бууруулах, баялгийн хулгай, нүүрсний хулгайтай тэмцэхэд хууль, эрх зүйн салбарын тогтолцоо, бодлогын өөрчлөлтөд шинэчлэлт хийх нь зүйтэй гэж үзэж, энэхүү шийдвэрийг гаргасан.

Баттөмөрийн Энхбаяр нь хууль зүйн салбарт 20 гаруй жилийн ажлын туршлагатай, мэргэжлийн боловсон хүчин бөгөөд ард иргэдийнхээ итгэлийг дааж, энэ асуудлыг тогтолцооны хувьд болон хууль зүйн салбарын хүрээнд шийдэж, хуулийн хүрээнд хуулийг дагаж мөрдөж, хуулийг дээдэлж ажиллаж чадах улс төрч гэж үзэж байна.

Өнгөрсөн өдрүүдийн хий хоосон улс төржилт нь улс орон, ард түмэн, төрийн алба, хувийн хэвшлийн хэвийн үйл ажиллагаанд тодорхой бус байдлыг бий болгож, өвөлжилтийн бэлтгэл, бензин шатахуун, цалин хөлс зэрэг цаг үеийн шинжтэй нийгэм, эдийн засгаас хойшлуулшгүй нэн яаралтай шийдвэрлэх албан асуудлуудыг тодорхой хэмжээгээр гацааж, саад бэрхшээл учруулж байна.

Ард түмэн улс төр биш, ажлаа хий, асуудлаа шаард гэж, асуудлаа шийд гэж та биднээс шаардаж байгааг төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурлын

гишүүд та бүхэн хүндэтгэн үзнэ гэдэгт гүнээ итгэж байна. Иймд Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж, энэ тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна. Зуны 3 сар бид бол цаг наргүй ажиллаж, эдийн засгийн өсөлтийг хангаж, валютын нөөцийг нэмэгдүүлж, тодорхой амжилтад хүрсэн.

Харамсалтай нь сүүлийн сарын хугацаанд үндсэндээ Засгийн газарт ажил хийх боломж олдохгүй, сандал, ширээ огцруулах, асуудал яригдсаар бидний энэ ажилд төрийн албаны бүх шатад тодорхой хэмжээний тогтворгүй байдлыг үүсгэж байна.

Иймд Баттөмөрийн Энхбаярыг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар томилох асуудалтай Улсын Их Хуралд танилцаж, Засгийн газрын гишүүний тангараг өргөх боломжоор хангаж, Засгийн газрын хэвийн үйл ажиллагааг хангаж өгөхийг та бүхнээсээ хичээнгүйлэн хүсье.

Эрхэм гишүүд ээ,

Засгийн газар баялаг, нүүрсний хулгайтай тууштай хатуу тэмцэнэ. Тавантолгойн бүлэг ордын нэг болох Бортээгийн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2026 оны төсвийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр өргөн мэдүүлснээс хойш өнөөдөр бараг 2 сарын хугацаа өнгөрөх гэж байна.

Уг тогтоолын төсөл батлагдсанаар эмч, багш нарын цалин хөлс, ахмадуудын тэтгэвэр, тэтгэмжийг шаардлагатай түвшинд нь хүртэл нэмэгдүүлэх, мөн бусад олон тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх нөхцөл боломжийг бид бүрдүүлэх юм.

Ард түмний баялгийг хулгайлсан аливаа үйлдэлд хуулийн хариуцлага хүлээлгэж, нууж хаасан үнэнийг илчлэн дэлгэж, ард түмний хатуу хараа хяналтыг тогтоон дархлахын төлөө Засгийн газар улам эрчтэй ажиллах болно.

Монгол Улсын Ерөнхий сайд Үндсэн хуульд заасан онцгой бүрэн эрхийнхээ дагуу Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээр ажиллаж, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, үндсэн чиг үүргээ биелүүлэхэд нийт ард түмэн болон Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхнийг дэмжиж ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Баялагтаа Эзэн Монголын төлөөх тэмцэл үргэлжилж байна. Монгол Улсад хулгай худал биш, үнэн ялах болтугай. Үнэн ялж Үндсэн хуулиа дээдлэн сахин хүндэтгэж, дагаж мөрдөж байж хулгай худал биш үнэн ялах болно.

Анхаарал хандуулсанд баярлалаа. Мөнх хөх тэнгэрийн хүчин дор Монгол Улс минь мандан бадрах болтугай.

Б.Пүрэвдорж: Ерөнхий сайд болон томилогдох этгээдээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн нэрээ өгнө үү. Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Монгол Улсын Үндсэн хуулийн хууль дээдлэх зарчмыг зөрчиж, хуралдаж байгаа чуулганы хуралдаанаас ирцээс хасаж өгөхийг танаас мэдэгдэж байгаа юм. Ямар үндэслэл байна гэхээр энэ Цэцийн чинь 22-ны өдрийн 08 дугаар тогтоолын 35 дугаар хуралдаан дээр 16, 17-ны өдрийн хуралдааны ирц ерөөсөө хангагдахгүй байна гэдэг зүйл байсан. Өмнөх асуудлууд чинь ингээд Үндсэн хууль зөрчсөн байдлаар явчихлаа Пүүжээ дарга аа.

2 дугаарт энэ цэц дээр чинь 95 дугаар тогтоолоо хүчингүй болгох арга хэмжээг аваарай гээд энэ заачихсан байгаад байгаа байхгүй юу. Хэрэгжүүлэх, энэ шийдвэрийг хүчингүй, хэрэгжүүлэх шаардлагатайг дурдах нь зүйтэй гэххэж. Тэгэхээр 95-ыг чинь хүчингүй болгож, Цэцийн шийдвэрийн дагуу хүчингүй болгоод, Засгийн газрын чинь эрх сэргээд, тэгээд Энхбаяр сайдыг томилох асуудлыг Ерөнхий сайдын эрх хэмжээний хүрээнд шийдэх ёстой байхгүй юу. Бид хэд ингээд асуудлуудыг дэнсэлдэг газар нь дэнслээд ингээд асуудлаа процессын дагуу явуулъя л гэж байгаа шүү дээ. Тэгэхээр ийм Үндсэн хуулийн цэцийн шийдвэртэйгээ хүртэл зөрчилдөж байгаа ийм хуралдаан явж байгаа учраас би танд бас Дэгийн хуулийн дагуу хүсэлтээ тавьж байна. Намайг ирцээс гаргаж өгнө үү. Би бол Үндсэн хууль зөрчиж чадахгүй. Одоо энэ танхимд чинь цөөхөн хүн сууж байна шүү дээ. Ирцэд орсон ч гэсэн танхимдаа суухгүй байвал энэ чинь эсрэг санал өгснөөр тооцогдохгүй. Үндсэн хуулийг нь зөрчиж болно шүү гээд Цэц чинь ингээд шийдчихээд байгаа байхгүй юу Пүүжээ дарга аа. Тийм учраас ирцээс гаргаж өгөхийг хүсье. Одоо 102 гишүүн байна. Та намайг яг одоогийн байдлаар 14 цаг 16 минут болж байна. Энэ яг цаг мөчөөс ирцээс гаргаж өгөхийг хүсье.

Б.Пүрэвдорж: Ирцээс гаргах бол энэ хуралдаан даргалагчийн бүрэн эрхийн асуудал байгаа. Та албан бичгээр аваад ирээрэй. Тэгвэл та бол хуралдаандаа оролцох үүрэгтэй. Тийм учраас ирцээс хуралдаан даргалагчийн хувьд гаргахгүй. Тэгээд энэ бусад асуудлаар Занданшатар дарга хариулъя.

Г.Занданшатар: Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрыг бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллах боломжийг олгож өгөхийг хүсэж байна. Засгийн газрын хуралдаан хуралдаж асуудал шийдэхэд Хууль зүй, дотоод хэргийн сайдын санал, дүгнэлт зайлшгүй шаардлагатай байдаг. 1 дүгээрт.

2 дугаарт Цэцийн дүгнэлт бол хар дээр цагаанаар Үндсэн хуулийн цэцийн Их суудлын шийдвэр эцсийнх байна гээд заачихсан юм байна лээ. Түүнийг хянан хэлэлцэхгүй гээд заачихсан юм байна лээ. Цэцийн дүгнэлтээ бүрэн унших хэрэгтэй. Цэцийн хяналт хэрэгжүүлэх ёстой гэдэг нь өнөөдөр Засгийн газар цаашдаа хэвийн ажиллах тэр боломжийг хэрэгжүүлж хангах ёстой гэсэн утгатай заалт.

Тийм учраас Үндсэн хуулийг, Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг Сайнзориг гишүүн бид 2 тайлбарлах, аль эсвэл хянан хэлэлцэх ямар ч эрх байхгүй. Бид Үндсэн хуулиа дээдлэн сахих ёстой. Хүндлэх ёстой. Ийм учраас ингэж Үндсэн хуулийг, Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг бид гуйвуулж, өөрийнхөөрөө тайлбарлаж болохгүй. Энэ бас л ахиад зөрчил болно шүү гэдгийг анхааруулаад, ер нь бол энэ 17-ны хурлын асуудал бол зүгээр үндэслэл дээр шалтгаануудыг нэгд дурдсан болохоос биш Цэцийн дүгнэлт Улсын Их Хурлын 95 дугаар тогтоолыг хүчингүй болгосон болохоос биш, бусад тогтоол, шийдвэр, чуулганыг хүчинтэй, хүчингүй гэж үзсэн шийдвэр гаргаагүй.

2 дугаарт үдээс хойших чуулган 14-өөс хойш хуралдсан үдээс өмнөх хуралдааны ирцтэй холбоотой асуудал хөндөгдөөгүй гэж ойлгож байгаа. Ийм учраас энэ цэцийн шийдвэрийг гуйвуулж, бусад асуудалд нялзааж хэрэглэхийг хориглох нь Үндсэн хуулийг дээдлэх үндсэн зарчим. Бид Үндсэн хууль дээр гараа тавьж байгаад Үндсэн хуулиа дээдэлж сахина гэж тангараг өргөсөн.

Ийм учраас энэ бол танилцуулах асуудал, хэлэлцүүлэх асуудал биш. 24 хоног өнгөрч байна. Ийм учраас 24 хоногийн завсарлага авчхаад дахиад завсарлах, хойшлох цаг хугацааны боломж алга. Засгийн газрын түвшинд шийдвэрлэх олон асуудлууд байна. Багш, эмч нарын цалинтай холбоотой, тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой, бензин шатахуунтай холбоотой, улсын нөөцтэй холбоотой, өвөлжилтийн бэлтгэлийг хангахтай холбоотой олон асуудлууд энэ Хууль зүй, дотоод хэргийн сайдыг томилогдсоноор Засгийн газрын хууль цаазын зөвлөх байдаг, Засгийн газрын гишүүн томилогдож байж хэвийн ажиллах боломж бүрдэнэ. Өнөөдөр ч гэсэн татвар төлбөр цуглуулахаас авхуулаад, татвараа төлдөг тогтворгүй байдлаас болоод татвараа төлөхгүй байх үзэгдэл ер нь нийгмийн бүх шатад бас ийм хүлээлт төрийн албанд ч гэсэн ийм тогтворгүй байдал нүүрлээд байгааг эрхэм гишүүд ойлгож, төрөө тогтвортой ажиллуулахын төлөө улс орныхоо том эрх ашгийг бодож ажиллахыг хүсэж байна.

Энэ дээр завсарлах ямар ч шалтгаан байхгүй гэж харж байна. 2023-2024 онд Засгийн газрын гишүүнээр Энхбаяр сайд ажиллаад л бүгдээрээ Их Хурлаар тэр үед хэлэлцэж томилдог байсан. Хэлэлцээд, танилцаад л ингээд л хэвийн явж байсан процесс өнөөдөр яагаад болохгүй байгаа юм бэ. Энэ чинь ард иргэдэд эргэлзээ төрүүлээд байна. Хууль зүй, дотоод хэргийн сайд бол хүний эрхийг дээдлэх, хуулийг дагаж мөрдөх үүрэгтэй ийм албан тушаалтан. Ийм учраас Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхнийг улс орны эрх ашгийг бодож, өнөөгийн тулгамдаад байгаа нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг ухаарч, эрүүл саруулаар асуудалд хандаж, энэ асуудлыг түргэн шуурхай шийдэж өгөхийг хүсэж байна.

Өнөөдөр ч гэсэн Засгийн газар ээлжит бусаар хуралдаж бас шатахуунтай холбоотой олон асуудлууд шийдэх шаардлагатай байна. Тийм учраас ажиллах боломжийг олгох шаардлагатай байна. Энэ бол зөвхөн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу танилцуулах процесс, танилцах процесс явагдаж байгаа.

Б.Пүрэвдорж: Ирцээс гаргахгүй. Дуламын Бум-Очир гишүүн асуулт асууна.

Д.Бум-Очир: Энхбаяр гишүүнийг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар томилох асуудлыг хэлэлцэж байгаад баяртай байна. Тэгээд ямар процесс, ямар алдаа гарч байгааг Үндсэн хуулийн цэц шаардлагатай бол дахиад шалгана биз. Шаардлагатай бол дахиад шалгаад өг гээд хүсэлтээ явуулна биз. Өмнө нь яг ийм асуудал гараад, 30 хэдэн гишүүн бид нар ирцдээ орохгүй байсаар байтал тэгээд л хүч түрээд л ирцэд оруулаад л асуудал хэлэлцсэн шүү дээ. Тэгээд Цэцийн бүлэгт Үндсэн хуулийн цэц дээр очиж энэ асуудал шийдэгддэг юм байна лээ. Тэгэхээр бид энэ танхимд энэ тухай асуудал яриад ямар нэгэн байдлаар үр дүнд хүрнэ гэж бодохгүй байна.

Энхбаяр гишүүнийг бол Хууль зүйн сайд болох гэж байгаад бол бас дэмжиж байгаагаа илэрхийлмээр байна. Бидний өнөөдөр энд хүрчихсэн байгаа асуудал эхэлсэн цэг нь бараг энэ болов уу гэж би бодож байна. Энхбаяр сайд Их Хурлын даргыг нүүрсний асуудал, хэрэгт холбогдсон юм байна гэдэг ийм зүйл мэдэгдсэн. Дараа нь үргэлжлүүлээд Ерөнхий сайд бас ийм зүйл ярьсан. Энэ нөхөд маань хүн гүтгэсэн гэдэг ийм өнгө аястай болон явсан. Нөгөө хүн маань гүтгүүлсэн гэдэг хэрэгт орсон. Ингээд бид бол нэг талдаа нэг хэсэг нь гүтгэсэн, нөгөө талдаа гүтгүүлсэн гэдэг ийм байр сууринд оччихсон байж байгаа. Эндээс нөгөө яриад байгаа талцал хуваагдал, хэлцэл, хэрүүл маргаан болтол үргэлжилж байгаа. Энийг нэг талд нь гаргах хэрэгтэй. Нэг талд нь гаргах хэрэгтэй. Их Хурлын гишүүд ч тэр, энгийн иргэд ч тэр энэ үнэхээр хүн гүтгэчихсэн юм уу, үгүй юм уу. Тэр хүн үнэхээр нүүрсний хэрэгт

холбогдчихсон, нотлох баримт нь байгаа юм уу, үгүй юм уу гэдгийг одоо болтол бид хүлээж байна. Хэсэг бүлэг нөхөд маань Засгийг хамгаалаад засгийн талд гарчихсан, 37, 38 болчихсон юм шиг харагдаж байгаа. Энэ яг зөвхөн Засгийг хамгаалах тухай асуудал биш л дээ. Зарчмын хувьд хэрвээ нөгөө талд нь хулгайч байгаа бол хулгайчийг өмөөрөхгүй гэдэг тэр л талд гарсан хэрэг шүү дээ. Мэдээж хулгай хийсэн эсэхийг нь мэргэжлийн байгууллагууд нь эцэслэн тогтоох ёстой. Тэгэхээр энийг тодорхой болгож нэг талд нь гаргахгүй бол өнөөдрийн энэ хэрүүл маргаан эцэслэгдэхгүй байна шүү гэдгийг хэлмээр байна.

Тэгээд дахиад нэг зүйлийг бид нар ч сонсмоор байна. Олон нийтэд ч гэсэн сонсох хэрэгтэй болов уу гэж бодож байна. Үнэхээр тэр нотлох баримт энэ тэр юм нь байгаа юм уу. Байгаа гээд л яриад байгаа шүү дээ. Тэр мэргэжлийн байгууллагууд нь ямар нэгэн байдлаар тэр нөхцөл байдлаа илэрхийлээд, шалгаж байгаа бол шалгаж байгаа гэдгээ хэлээд, энэ байдал дээр тодорхой хэмжээний мэдээлэл өгөх хэрэгтэй байна. 1 дүгээрт.

2 дугаарт энэ ажлаа жаахан хурдлуулмаар байна. Үүнээс чинь болоод үндсэндээ өнөөдрийн энэ улс төрийн, нийгмийн нөхцөл байдал бий болчихоод байна гэдгийг онцгойлон анхааруулж хэлмээр байна. Тэгэхээр энэ бол үндсэндээ зөвхөн засгийг хамгаалаад нэг хэсэг гишүүд нэг талдаа гарчихсан хэрэг биш. Зарчмын хувьд зөв талдаа гарч байгаа гэж л ойлгож байгаа. Би бол тэр талд гарсан гишүүдийнх нь нэг. Өөрөөр хэлбэл хулгайчийн талд ормооргүй байгаа учраас, шалгах нь зөв гэж бодож байгаа учраас, тэр хүн шалгуулах нь зөв гэж бодсон учраас энэ талд гарчихсан байгаа шүү гэдгийг бас мэдэгдмээр байна.

Б.Пүрэвдорж: Нэр дэвшигч Баттөмөрийн Энхбаяр хариулъя.

Б.Энхбаяр: Бум-Очир гишүүний асуултад хариулъя. Сүүлийн 1 сарын хугацаанд миний биеэс Улсын Их Хурлын дарга асан Амарбаясгалангийн хамаарал бүхий хүмүүс Админерал гэх компанитай холбоотойгоор Тавантолгойн бүлэг ордын 2 дахь том орд Бортээг гэх уурхайд Эрдэнэс Тавантолгой компаниас нүүрс баяжуулах үйлдвэр барих гэдэг халхавчаар Бортээгийн нүүрсийг зах зээлийн үнээр худалдан борлуулах онцгой монопол эрхийг давуу байдал эдэлж авсан гэх асуудлыг ярьсан. Энэ одоо яригдаагүй. 2023 оны 12 сард Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд Улсын Их Хурлаас байгуулсан нүүрсний хулгайтай холбоотой хянан шалгах түр хороон дээр нэг өдрийн турш хянан шалгагч шинжээч нар нотлох баримттайгаар Монголын ард түмэн, нийтэд шууд дамжуулж яригдсан асуудал.

Харин энд яригдсан асуудлыг гөлөг төөрүүлэх, сонсгол зохион байгуулагчдыг дайруулах, хэвлэл мэдээллээр түгээхгүй байх ийм идэвхтэй үйл ажиллагаа явагдсан. Тэгэхээр энэ шинэ асуудал яригдаад байгаа зүйл биш шүү дээ. Тэр 2023 оны 12 сард нүүрсний сонсгол зохион байгуулагдаж байх үед одоо энэ нэр дурдагдаад байгаа Монгол Ардын намын Нарийн бичгийн дарга Чулуунзагд, түүний төрсөн ах Ламжав, талийгаач этгээд нар яллагдагчаар татагдаж, шалгагдаж байсан асуудал. Одоо ч үргэлжилж байгаа. Тэгэхээр одоо ингээд гэнэт гараад л ирчихсэн, гэнэт шүгэл үлээчихсэн ерөөсөө асуудал биш.

Энэ нотлох баримтууд нүүрсний сонсгол дээр яригдсан нотлох баримтууд. Энд гаргасан хянан шалгах шинжээчдийн дүгнэлт одоо Улсын Их Хурлын Тамгын газар архивд байгаа. Хүссэн хэн бүхэн, тэр дотроо Улсын Их Хурал дахь намын бүлгүүд,

Улсын Их Хурлын гишүүд тухайн хянан шалгах шинжээчдийн тайлан, дүгнэлт, материалтай бүрэн танилцах, хуулбарлан авах бүрэн эрхтэй. Тэгэхээр энэ асуудлыг хөндөж байгаа гишүүд маань Улсын Их Хурлын Тамгын газарт хандаад энэ материалуудыг үзээч ээ. Энийг зохион байгуулсан Хянан шалгах түр хороо дээр нотлох баримтыг танилцсан, мөн холбогдох гэрчүүдээс асуулт асуусан хүний хувьд надад энэ асуудалд холбогдсон гэсэн 100 хувийн итгэл үнэмшил байгаа. 100 хувийн итгэл үнэмшил байгаагүй бол би өдийд ийм итгэл үнэмшилтэйгээр ярихгүй байсан. Энэ асуудал одоо ч хуулийн байгууллагад шалгагдаж байгаа. Өнгөрсөн хугацаанд Улсын Их Хурлын 2 жилийн хугацаанд Улсын Их Хурлын дарга асан Амарбаясгалан нүүрсний сонсгол дээр яригдсан нотлох баримт, шинжээчийн дүгнэлттэй холбоотой асуудлаар 1 ч удаа хууль хяналтын байгууллагад нэр төрөө сэргээлгэхээр хандаагүй.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Бум-Очир гишүүн асуулт.

Д.Бум-Очир: Сайдаар томилогдоод Энхбаяр гишүүн маань энэ асуудлаа нэг талд нь гаргаж өгөөсэй гэж маш олон гишүүдээ төлөөлөөд, Монголын олон ард иргэдийг төлөөлөөд хүсэж байна. Яагаад гэхээр энэ нь нэг талдаа гарахгүй бол жишээ нь бид мэтийн гишүүд нөгөө хүн гүтгэсэн хүмүүсийн талд орсон юм шиг ийм нөхцөл байдал үүсэж байгаа байхгүй юу. Тэгээд явж явж бид нар энэ хэрэг хэрвээ мухарлагдахгүй бол тэгээд хүн гүтгэсэн хүмүүсийг өмгөөлж, хамгаалсан ийм байр сууринд орчих ийм нөхцөл байдал үүсчихсэн байгаа шүү. Танд болоод энэ асуудал дээр энэ талд зогсож байгаа олон гишүүд энэ талд зогсож байгаа олон гишүүд мөн ийм байр суурьтай байгаа болов уу гэж бодож байна. Тэгээд энэ ажилд нь амжилт хүсье.

Б.Пүрэвдорж: Асуулт асуугаагүй. Одоо Жамбын Батсуурь гишүүн асуулт асууна.

Ж.Батсуурь: Бүгдэд нь өдрийн мэнд. Би уг нь Ж.Бат-Эрдэнэ гишүүнийг энэ хуралдааны танхимд орилоод байнгуут нь хандаж үг хэлэх гэсэн. Тэгээд өөрөө гараад явчихсан байна. Гэхдээ нэгэнт үг авсан юм чинь би бас хэд 3 зүйл хэлье гэж бодож байна.

Өнөөдөр болж байгаа асуудал бол олон жилийн ужиг ард түмнийг хуурсан нөхцөл байдлаас үүссэн. Саяхан л төрийн хямралаас гаръя, түмнээ ядуурлаас аваръя, гадаад, дотоод зээлээ багасгая гэж ингэж эхэлсэн. Уж 10 гаруй жил болчихсон байна. Ард түмэн та бүхэнд бол 3 удаа 64-өөр, 65-аар, 68-ын бүлэг байгуулж өгсөн. Төрийг хямралаас гаргах, түмнийг ядуурлаас гаргах, гадаад, дотоод зээлийг багасгах бүх боломжийг та бүгдэд өгсөн. Гэтэл төрөө хямралаас гаргах биш, төрийг бүр хямрал руу чирээд, бүтэн хэмжээнд оруулчихсан байна. Тэгээд энэ хямралаас гарах боломж бол уг нь танай бүлэгт бүрэн байгаа. 10 гаруй жил байна. Гэхдээ сүүлийн үеийн нөхцөл байдлууд бол нэг л их Үндсэн хууль ярьсан. Тэгсэн мөртөө Үндсэн хуулиа өөрсдөө зөрчсөн ийм нөхцөл байдлууд үүсчихжээ. Тэгээд энэ зүйл бол нэг газар очиж заавал тайлагдаж, учиг нь тайлагдах ёстой. Тийм учраас би Энхбаяр гишүүнийг энэ ярьж байгаа зүйлээ богино хугацаанд хийж, энэ төрийг хямралаас гаргах анхны учгийг бас татаж, мөн энэ цэг тавьж өгөх байх гэж л ингэж найдаж байна.

Хорвоо дээр 2 үнэн гэж байхгүй. Хэрвээ та хүн гүтгэсэн бол та өөрөө хариуцлага хүлээх ёстой. Хүмүүсийг гүтгэсэн бол. Хэрвээ таны Нүүрсний сонсголын

үеэр, мөн өнгөрсөн Ногоон автобусны хулгай, Хөгжлийн банкны хулгай гээд энэ хулгай бол замаа алдсаныг Монгол орон даяараа мэдэж байгаа. Анх л 60 тэрбумын хулгай, 1 тэрбумын ЖДҮ гэж ярьж байсан. Одоо ер нь 60 их наядаас доош юм ер нь ярихаа больчихсон байна. Учраа ч олохоо байлаа. Тэгээд одоо өөрсдийнхөө 3 удаа дараалан сонгогдсон олонхын засаглалыг биелүүлж чадахгүй, тэгээд буруу буруу, бусдын буруу. Бүх л юм бусдын буруу гэсэн энэ байдалд цэг тавьж өгөх боломж нь бол үүсэх байх гэж энэ байдлаар бас таныг дэмжиж байна.

Гэтэл би танаас үгийнхээ эцэст юу гэж асуух гэж байна вэ гэхээр хорвоо дээр 2 үнэн байдаггүй. Хэрвээ та энэ асуудлуудыг нотолж, нийгэмд байгаа хардлагыг цэг тавьж өгч чадахгүй бол та өөрөө хариуцлага хүлээхэд бас бэлэн үү гэдгээ бас Монголын ард түмэнд хэлж өгөөч ээ.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: 1 минут нэмж өгье.

Ж.Батсуурь: Төрийг хямралаас гаргах боломжийг нээж өгөөч ээ гэж ингэж хэлэх гэсэн юм. Ер нь бол энд Ардчилсан нам энэ сүүлийн парламентад маш зарчимтай, анхааралтай, бас төлөвшсөн улс төрийн хүчин шиг ажиллаж байгаа гэдгийг та бүхэн анзаарч байгаа байх. Хуучин нөхцөл байдлуудыг бид нар сэдэрээж хэзээ ч ярьдаггүй. Энэ төр хурдан төлөвшөөсэй, төсвөө хурдан батлаасай, хүмүүсийн хүсээд байгаа цалин мөнгөний асуудал, багш нарын цалин, эмч нарын цалин, төрийн үйлчилгээний ажлын цалин нэмэгдээсэй, авлига нь багасаасай. Тэр ой тойгүй яриад байгаа олон их наядынх нь мөнгө нь хүмүүсийн бүлэглэлийн карманд биш, ард түмний карманд төрийн албан хаагчдын цалин болж орж ирээсэй гэсэн ийм хүсэл эрмэлзлийн үүднээс танд бас итгэж байна. Та бас энэ итгэлийг бас алдуулсан дараагийн нэг бүлэглэлийн толгойлогч болчхов гэдгийг бас энэ индэр дээрээс сануулж .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр.

Б.Энхбаяр: Нүүрсний Улсын Их Хурлаас байгуулагдсан хулгайтай холбоотой сонсгол бол өнгөрсөн парламентад Монгол Ардын нам, Ардчилсан намын гишүүдийн тэгш оролцоотойгоор Занданшатар Ерөнхий сайдыг Улсын Их Хурлын дарга байх үед Монгол Улсын Үндсэн хуульд орсон өөрчлөлт, мөн түүний манлайлал доор гарсан хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд зохион байгуулагдсан. Би ялагдахгүй ээ. Яагаад. Нүүрсний сонсголоор сая нэр дурдагдаад байгаа Админерал гэх компанитай холбоотой Бортээгийн уурхайд баяжуулах үйлдвэр гэдэг халхавчаар хууль бус тендер зохион байгуулсан гэдгийг Улсын Их Хурал тогтоож, тогтоол гаргачихсан. Одоо тэр түр хороонд жишээлбэл Ардчилсан намаас гэхэд Цогтгэрэл дарга ажиллаж байсан. Ганбат гишүүн ажиллаж байсан. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн ажиллаж байсан. Бид 100 хувийн саналаар энэ хөндөгдөөд байгаа асуудлыг хууль бус зохион байгуулсан байна гэдэг Улсын Их Хурлын тогтоол гаргачихсан байхгүй юу. 2024 оны 1 сард. Энэ тогтоол хүчинтэй байгаа. Тэгэхээр би ч ялагдахгүй, бид ч ялагдахгүй. Энийг Улсын Их Хурал тогтоочихсон. Одоо энэ гэмт хэргийн шинжтэй тэр цаад асуудал нь бол харин шалгагдаж байгаа. Гэхдээ би энэ асуудлыг зөвхөн авлигын гэмт хэрэг гэж үзэхгүй байгаа. Яагаад гэхээр 30 сая долларын авлигын баримт нь Монгол талаас биш гадаад улсаас гарсан. Гадаад улсад авлигын баримт нь байгаа этгээд бол Монгол төрд шийдвэр гаргаж, тамга дарж, алх барьж болохгүй гэж би үзсэн. Энэ бол ердийн авлигын хэрэг биш. Монгол Улсын үндэсний аюулгүй байдалтай холбоотой, тэр

дотроо Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүн нь өөр улсад барьцаалагдсан этгээд би байж болохгүй гэж үзсэн.

Тийм ч учраас итгэл үнэмшилтэйгээр, хожим хойно би харамсахгүйгээр үхнэ гэж өөртөө тангараглаж энэ сонсголыг зохион байгуулсан. Амархан байсан гэж бодож байна уу. Монгол Ардын намын Ерөнхий нарийн бичгийн дарга буюу Улсын Их Хуралд хэнийг нэр дэвшүүлэх, дэвшүүлэхгүйг шийддэг, Засгийн газраас эхлээд төрийн өмчийн бүх компаниудын захирал хэн байхыг мэддэг тэр этгээдийг би ямар хувийн итгэл үнэмшилтэйгээр гэрчээр дуудах байсан бэ. Тэгвэл яагаад өөрөө зугтсан юм бэ. Ирээгүй юм бэ гэдэг асуудал байгаа. Тийм учраас би миний дахин нэр дэвших дараа дараагийн улс төрийн замнал саад болох эсэхээс үл хамаарч хэзээ нэгэн цагт би ийм хулгайчийг төрийн алх бариулж байсан гэж харамсахгүй үхнэ гэсэн ийм итгэл үнэмшлээр энэ сонсгол зохион байгуулагдсан шүү.

Б.Пүрэвдорж: Жамбын Батсуурь гишүүн тодруулъя.

Ж.Батсуурь: Яах вэ, таныг дэмжиж байгаагийн шалтгаан юм бол зөвхөн нүүрсээр зогсмооргүй байна. Үнэхээр энэ ард түмний цөхрөлд цэг тавьж өгөөч ээ. Нөгөө яригдаж байсан үнийн дүнг анх гарч ирэхдээ аймшгийн л үнийн дүнгүүд байдаг. Дараагийнх нь гарч ирэхдээ өмнөх нь бүр өө яасан жижиг юм бэ л гэсэн л ийм асуудлууд бий болчихдог. Жишээлэх юм бол Ногоон автобус ямар аймшгийн зүйл байлаа. Хөгжлийн банк, ЖДҮ, одоо энэ нүүрс бол бөөнөөрөө явж байх шиг байна. Авлига, хээл хахуулийн асуудал. Тэгээд энэ бүх зүйлд цэг тавьж өгнө. Өөрийн чинь хэлж байгаа шиг харамсахгүйгээр энэ амьдралаа үдэхэд бэлэн байна гэсэн санааг илэрхийлж байна. Тэгэхээр харамсахгүйгээр зөвхөн та нүүрсээр хязгаарлагдахгүйгээр өнгөрсөн 2016 оноос .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ерөнхий сайд Занданшатар хариулна.

Г.Занданшатар: Тийм ээ. Ер нь энэ асуудал бол зөвхөн нүүрсний хулгайн асуудал биш. Энэ бүх шатанд ужгирчхаад, ялзарчхаад байгаа тендер, худалдан авалт, авлига, хээл хахууль, ашиг сонирхлын зөрчил дээр өнөөдөр цэг тавихгүй бол Монгол Улсын ирээдүйн цаашдын хөгжлийн хувь заяанд ч, Үндэсний аюулгүй байдалд ч ноцтой хохирол учруулах хэмжээнд хүрчхээд байгаа учраас бид амь бие үл хайрлан тэмцэнэ гэж. Энэ бол 1 хүний ч юм уу, 1 хэсэг хүний хүсэл зорилгоор биш, нийт бидний хамтын хичээл зүтгэлээр хамтдаа бүтэх ёстой. Тэгэхдээ бид нар бол энийг мөсийг нь зүсэж, эргэж буцахгүйгээр айдас байхгүй, эх орондоо өргөсөн тангарагтаа, төр ард түмэндээ өргөсөн тангарагтаа үнэн ч байж энэ ажлын ард гарах ёстой гэж үзэж байгаа юм. Энэ хэн нэгнийг буруутгах гэж байгаа юм биш. Энэ Монголын төрд итгэх итгэл .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Дахин 1 минут хариулъя.

Г.Занданшатар: Ийм учраас энэ бол төрд итгэх ард түмний итгэлээ сэргээх, итгэлцлийг сэргээх, эдийн засгаа сэргээх ийм цогц ажил бол ерөөсөө эндээс л эхлэх юм байна лээ. Хулгайтай тэмцэхээс. Ер нь баялгийн хулгайтай тэмцэх ажил зөвхөн энэ Тавантолгойгоор хязгаарлагдаж байгаа юм биш. Оюутолгой дээр ч гэсэн худалдан авах ажиллагаа, энээ тэрээ болоод энэ бидний ашигт ажиллагаанд нөлөөлөөд байгаа ажиллагаа дээр ажиллагаа явуулсан. Бүх стратегийн орд газрууд дээр бид тэмцэл явуул гэж даалгавар өгсөн. Хууль хяналтын байгууллагууд ажиллаж байгаа. Доторх нарийн ширийнийг нь мэдэхгүй. Өнөөдөр гэхэд 10 гаруй

тэрбум төгрөгийн асуудалтай Оюутолгойн зарим худалдан авах ажиллагааны албан тушаалтнууд баригдаж байна. Бүх шатад хууль очих болно шүү. Энийг төрийн бүх албан хаагчид, тендер, нүүрс, баялагтай холбоотой асуудалдаа өнөөдөр цэг тавьж эргэж харах ёстой шүү. Шатыг дээрээс нь шүүрдэх ёстой гэдэг шиг үүнээс бид хэзээ ч зогсохгүй.

Ийм учраас авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхыг бид энэ төрийн өндөр индрээс .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Одоо Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууна.

Д.Энхтүвшин: Энхбаяр гишүүнээс 2 асуулт байна. Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2 асуудалд эрх зүйн шинэтгэл болон нөгөөдөх нь болохоор төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах гэсэн 2 ийм эрхлэх асуудлын талаар асуулт байна.

Тэгээд сүүлийн үед энэ хулгай нэмэгдээд байгаа, төр томроод байгаагийн гол шалтгаанууд нь энэ төрийн өмчит компаниуд байгаа. Тэгэхээр энэ эрх зүйн шинэтгэлийн бодлогын хүрээнд төрийн болон нийтийн өмчийн энэ талаар та ямаршуу бодлого хэрэгжүүлж гэж бодож байгаа вэ. Энэ талаар танд тодорхой тийм бодлого бодчихсон юм байгаа юу. Энэ талаар өөрийнхөө бас санаа бодлоо илэрхийлээч гэж хүсэж байна.

2 дугаарт нь бас энэ хулгайтай холбоотой нууцад оруулдаг. Нууцад оруулж байгаад тодорхой өмч хөрөнгийг шамшигдуулдаг, хулгай хийдэг ийм асуудлууд байгаа. Тэгэхээр төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудлыг хариуцахын хувьд яг энэ нууцтай холбоотой энэ төрийн ил тод байдалтай холбоотой асуудлаар та ямар тодорхой ажил хийе гэж бодож байгаа вэ. Ийм 2 асуулт байна.

Б.Пүрэвдорж: Нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр хариулна.

Б.Энхбаяр: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Ер нь нууц гэдэг тамганы ард их олон хулгай болдог гэдэг нь одоо ил болсон. Энэ дээр миний бие ярих биш, тодорхой үйлдэл өмнө нь хийж байсан. Тухайлбал 2023 оны 10 сарын сүүлээр миний бие Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хувьд Засгийн газраас Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барьж, батлуулж байсан. 11 сард нь батлуулж байсан. Энэ ямар заалтыг өөрчилж байсан бэ гэхээр албаны нууцыг тухайн төрийн өмчийн компаниудын захирлууд, байгууллага, агентлагийн дарга нар өөрийн үзэмжээр дарах эрхийг хязгаарлаж, тагнуулын байгууллагын дүгнэлтийг авсны үндсэн дээр тэр албаны нууцын тамгыг дарж байна гэдэг хуулийн өөрчлөлтийг хийсэн. Тэгэхдээ энэ өөрчлөлт би хангалттай хэмжээнд бас биш юм байна гэж үзэж байгаа. Төрийн болон албаны нууцын тухай хуулийг миний бие шинэчлэн найруулах хэлбэрээр бүрэн өөрчилж, Улсын Их Хуралд оруулж ирнэ гэсэн итгэл үнэмшилтэй байгаа.

Ингэхдээ төрийн нууцын тухайтад Улсын Их Хурал төрийн нууцад ямар ямар нууцыг оруулах вэ гэдгийг Улсын Их Хурал шийддэг байх ёстой. Одоогийн хуулиар төрийн нууцад оруулах, гаргуулах асуудлыг Монгол Улсын Засгийн газар шийдэж

байгаа. Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага нь өөрөө шийдээд байгаа юм. Тийм учраас энэ нууцтай холбоотой асуудал ард түмний төлөөллийн байгууллагын Улсын Их Хурлын хяналтаас гарчхаад байгаа юм.

Та бүхэн анзаарч байгаа бол төрийн нууцаас ийм мэдээллийг гаргахаар Монгол Улсын Засгийн газар шийдвэрлэлээ гэдэг мэдээнүүдийг сүүлийн хэдэн жил үзээд байгаа. Улсын Их Хурал мэдэхгүй, гишүүд та бүхэн маань мэдэхгүй байгаа. Тийм учраас би энэ нууцтай холбоотой асуудлыг хуульчилж, яг ямар асуудлыг төрийн онц чухал, маш нууц гэж үзэх вэ гэдэг жагсаалтыг Улсын Их Хурал батлах ёстой гэсэн итгэл үнэмшилтэй ийм үзэл баримтлалаар би энэ Нууцын хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг санаачилж, Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулна гэсэн ийм бодолтой байна.

Төрийн өмчийн компанийн засаглалын хувьд миний хувьд сүүлийн 10 жил итгэл үнэмшил болж ярьдаг энэ асуудал дээр концепцын зөрүү, Монгол Ардын нам болон Ардчилсан намын хооронд байдаггүй. Байдаггүй. Өөрөөр хэлбэл зарчмын хувьд төрд хамгийн бага өмч байх ёстой. Төрийн өмчийн компаниуд зөвхөн улс орны стратегийн чиглэлийн асуудлууд дээр л байгуулагдах ёстой, хувийн хэвшилтэй өрсөлдөх ёсгүй гэж концепц барьдаг. Энэ үзэл баримтлал Монгол Улсын Засгийн газраас хуулийн төсөл хэлбэрээр Улсын Их Хуралд өргөн баригдсан. Миний бие ахалж байгаа. Миний бие ахлах гэж нэлээн юм болсон бас. Энийг миний бие 2016 онд Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд болоод, бүр 2016 оны Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт хийж, суурь судалгааг нь эхлүүлж байсан юм. Энэ суурь судалгаанууд 4 жил хийгдсэн. Улмаар өнгөрсөн парламентын үед Улсын Их Хуралд бас өргөн баригдсан байсан. Миний бие бас ажлын хэсгийг нь ахлаад, батлуулахын даваан дээр сайд болчихсон юм. Тэгээд ч сонгууль болох гэж байна гээд хуулиуд батлагдаж чадахгүй үлдээд, тэгээд шинэ хуулийн дэгээр нөгөө өмнөх Улсын Их Хурлаар өргөн баригдсан хуулиудыг бүгдийг нь буцаадаг хууль гарчихсан чинь энэ хуулиуд буцаагдаад, дахиад орж ирэх гэж нэлээн юм болсоор байгаад саяын өргөн баригдаад, тэгээд ингээд явж байгаа асуудал. Тийм учраас энэ дээр бол би хамгийн бага .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн нэмж тодруулна.

Д.Энхтүвшин: Та саяын оршил ярьчихсан. Тэгээд яг энэ Төрийн болон орон нутгийн өмч, нийтийн өмчтэй холбоотой ямаршуу бодлогын шинэчлэл хийе гэсэн ерөнхий төсөөлөл байгаа вэ. Тэр талаар илүү дэлгэрэнгүй ярьж өгөөч.

Б.Пүрэвдорж: Баттөмөрийн Энхбаяр гишүүн хариулъя.

Б.Энхбаяр: Ер нь бол онолын хувьд бол төр өөрөө ард түмнээс эхтэй учраас ард түмнээс эхтэй байгуулагдсан зүйл өөрөө өөртөө тусдаа бие даасан өмч, эдлэх ёсгүй гэдэг онолын суурь асуудал байдаг. Тодорхой хэмжээнд ард түмнийг төлөөлөхийнхөө хувьд agent гэж ярьдаг онолын хувьд. Ийм agent-ийн үүргийг төр гүйцэтгэдэг. Энэ agent-ийн тодорхой эрх, үүргийг маш нарийн хуульчлах ёстой гэж үздэг. Тухайлбал, төрийн өмчийн компаниудын орлог, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнөөс эхлүүлээд Төлөөлөн удирдах зөвлөл, Засгийн газар, холбогдох сайд нар төрийн өмчийн компанийн удирдлагад ямар эрх хэмжээтэй шийдвэрүүд гаргах вэ гэдгийг хуульчлан зааглах хэрэгтэй байгаа. Ингэхгүйгээс тодорхой сайд нар тэр өмчийг хувийн өмч мэт захиран зарцуулдаг байдал 30 жил үүрлэсэнтэй холбоотой хулгай даамжирсан. Энийг таслан зогсоох ёстой байгаад байгаа юм.

Хуулиар нь эхлээд. Тэгэхээр энэ хуулийн шинэчлэлийг би Их Хурлын гишүүдтэйгээ хамт Засгийн газрын гишүүн болсон ч .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

А.Ариунзаяа: Өчигдөр орой 8 цаг 24 минутад даргын дэргэдэх зөвлөлийн дундын цахим групп дээр Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар сайдын асуудлыг оруулж ирье гэдэг ийм саналыг тавьсан. 5 хүн дэмжсэн. 16 гишүүнээс 5 хүн дэмжсэн, бусад нь дэмжээгүй. Тэгээд энэ асуудлыг Цэцийн асуудал орж иртэл хойшлуулъя гэдэг ийм даргын дэргэдэх зөвлөлийн шийдвэр гарсан.

Өнөө өглөө Пүрэвдорж дарга маань Дэгийн хуулийн 6.6, 6.9, 6.10-ыг зөрчин байж энэ асуудлыг оруулж ирлээ. Та эдгээр Дэгийн хуулийн заалтуудыг зөрчсөн. Өчигдөр 17 цагаас өмнө Цогтгэрэл дарга бичгээр саналаа өгөөгүй л бол бичгээр өгсөн саналыг нь та уншиж танилцуулаагүй л бол энэ асуудал орж ирсэн нь өөрөө Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийг зөрчсөн гэдгийг протоколд тэмдэглэн үлдээмээр байна.

Бид ер нь зарчмыг л ярьж байгаа. Хуулийг л ярьж байгаа. Занданшатар Ерөнхий сайдад Үндсэн хуулийн цэцийн шийдвэр таны талд гарсан бол ойлгомжтой. Энийг Улсын Их Хурал авч хэлэлцэхгүй, эцсийн шийдвэр гэдгийг бүгд ойлгоод байгаа. Гагцхүү 95 дугаар тогтоолыг яг хүчингүй болгож байгаа тэр процесс нь ингээд Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай гэсэн тамга тэмдэгтэй, гарын үсэгтэй Улсын Их Хурлын тогтоол байх ёсгүй юу гэдгийг л асуугаад байгаа юм. Ингэж байж сая таны 95 дугаар тогтоол хүчингүй болж, та Ерөнхий сайдаар үүрэг гүйцэтгэгч биш үндсэн Ерөнхий сайд гэдэг энэ легитим чанар чинь босож ирнэ гэж зүгээр би бодох юм. Магадгүй та намайг чи хууль тайлбарлах хүн биш гэж дахиж бөөрөлхөх байх. Би зөвхөн энийг л хүссэн. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг огт үгүйсгээгүй шүү дээ. Шийдвэр гарлаа. Гагцхүү 95 чинь одоо хүчингүй болох ёстой байхгүй юу даа. Энийгээ хүчингүй болгочхоод, Энхбаяр нүүр бардам орж ир. Ийм асуудлыг л хүссэн. Гэвч хүч түрээд, энэ асуудлыг оруулаад явлаа. Бид ямар нэгэн санал хураалт хийхгүй, танилцуулагдаад л асуултуудаа асуугаад л дуусчихна.

Энхбаяр сайд тан дээр Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатын тойргийн шүүхийн шүүгчийн захирамж 2025 оны 10 сарын 10-нд хүний нэр төр, алдар хүндэд халдсан, ажил хэргийн нэр хүндийг гутаасан болохыг тогтоож, мэдээллийг тараасан хэлбэрээр няцааж, залруулга хийлгэхийг даалгуулах тухай иргэний хэрэг үүсгэсэн байгаа байхгүй юу. Та энэ иргэний хэрэг үүсгэсэн зарга дээрээ очсон байгаа юу. Хүлээж авсан уу. Түрүүн над дээр ямар нэгэн гомдол гараагүй гэж хэлсэн. Та энэ шүүх дээр уг нь ороод, нотлох баримтуудаа өгөөд, гэм буруугүй гэдгийгээ нотлуулаад, гарч ирэх ёстой эцсийн процесс нь бол тэндээ орж ирэх ёстой юм гэж би бол ойлгож байгаа. Дарга аа, 1 минутаа авчих уу. Эсвэл араас нь явах уу. Би уг нь 1 минутаа авчихмаар байна.

Б.Пүрэвдорж: 1 минутаа нэмээд авчихъя.

А.Ариунзаяа: Ер нь бол процесс яаж эхэлсэн, юу болж байгаа вэ гэдгийг бүгдээрээ мэдэж байгаа. Магадгүй та бүхэн маань энэ залуу гишүүд, эмэгтэйчүүд ер нь их дайрч байна л гэж хараад байх шиг байна. Хаан шалдан байна гэдгийг 1 залуухан жоохон хүүхэд, хөвгүүн хэлдэг шүү дээ. Үлгэрт. Тэгээд тэр хөвгүүн яагаад

түүнийг хэлдэг вэ гэхээр айдас айдасгүй байхгүй юу, айх айдасгүй. Юу болох үр дагаврыг нь мэдэхгүй. Үнэнийг л хэлж байгаа юм. Бидэнд ч гэсэн чамайг ёстой байхгүй болгоно гэж өнөөдөр хүртэл заналхийлж байна. Магадгүй бид нар айх айдасгүй, эсвэл барьцаалагдах барьцаагүй байгаа учраас үнэнийг хэлээд, зарчмын талд нэлээд хүчтэй дуугарч байгаа байх. Юу болж байгааг хэзээ нэгэн цагт хүмүүс ойлгох байх л гэж бодож байна. Хаан шалдан байгаа. Тэгээд үүн дээр 95 дугаар тогтоолтой холбоотой мөн шүүхтэй/минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар хариулна.

Г.Занданшатар: Аюушийн Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Цэцийн шийдвэр бол хэн нэгний талд гэхээсээ илүү Үндсэн хуулийн талд гарсан гэж би ойлгож байна. Үндсэн хуулийг дээдлэн сахиулахын баталгаа нь Үндсэн хуулийн цэц байдаг. Тэгээд энэ дээр хар дээр цагаанаар Үндсэн хуулийн цэцийн эцсийн шийдвэр гарсан бол уг заалт хүчингүй болно гэж заачихсан. Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцээгүй гэж Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргавал зохих хууль, зарлиг, батламж, шийдвэр хүчингүй болно гэж заасан гэж байгаа юм. Тэгэхээр энэ хүчингүй болго л гэсэн ийм зарлиг гарчихсан. Хүчингүй болгоё гэж хэлэлцээд, хянаад, шийдвэр Улсын Их Хурлаар тогтоол, төсөл батална гэхээсээ илүү энийг хэрэгжүүл гэсэн ийм агуулгатай Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гарсан. Үндсэн хууль өөрөө тэгээд заачихсан. Үндсэн хуульд нийцээгүй бол тэр хүчингүй гээд заачихсан. Энэ Цэцийн шийдвэр нь бичээстэй байна. Үндсэн хуулийн 70 дугаар зүйлийн 1-д байх, Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллага, албан тушаалтны бүх шийдвэр бүрнээ нийцсэн байвал зохино гээд заачихсан. Ийм учраас энэ Үндсэн хуулийн асуудал бол тодорхой. Тэгээд Ерөнхийлөгчийн хориг ч гэсэн тодорхой гэж ойлгож байгаа. Ийм учраас Засгийн газар хэвийн үйл ажиллагаа явуулах шаардлагатай байна. Төр, ард түмний эрх ашиг тэгж шаардаж байна.

Харин бидэнд айдас байхгүй учраас, худал, хулгай, луйврын асуудал байхгүй учраас, худалтай эвлэрэхгүй, хулгайтай эвлэрэхгүй энэ тэмцлийг тууштай үргэлжлүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа учраас бид энэ асуудлыг хөндөж гаргаж, явж байгаа юм. Төрийн бүх шатанд төрийн өмчит компаниудад энэ баялгийн хараал хулгай болчихоод байгаа энэ асуудлуудад өнөөдөр цэг тавихгүй бол энэ эргэлзээ маргаан дагуулаад байгаа асуудлуудыг шалгаж нэг тийш болохгүй бол ард түмний итгэл алдагдаж байна. Төрийн бүх эрх мэдэл ард түмнээс эх сурвалжтай гэж Үндсэн хуульд заасан. Ард түмэн үүнийг шаардаж байна. Ийм учраас энэ тэмцлээс бид ухрахгүй. Ингэж байж Монголын төр цэвэршиж, авлига, хээл хахуулийн асуудал цэгцлэгдэж, нийгэм, эдийн засгийн амьдрал сэргэнэ. Үүнд бид хатуу итгэлтэй байгаа.

Бид баялгийн хулгай, нүүрсний хулгайг таслан зогсоож байж, учирсан хохирлыг арилгаж, гэм буруутнуудад хариуцлага тооцож байж, далд эдийн засгийг ил тод болгож байж Монгол Улсын эдийн засаг сэргэнэ. Ийм учраас энэ асуудал бол бид худал биш хууль үнэн ялах ёстой гэж энэ зарчмаар явж байгаа. Ийм учраас бидний хийж байгаа бүх үйл ажиллагаа, зорилго зөв. Бидний тэмцэж байгаа арга хэлбэр зөв, хуулийн дагуу явж байгаа.

Харин зорилго буруу, арга буруу байгаа энэ улайрсан, албан тушаалд хэт шунасан, өс хонзон айдсаар өдөөгдсөн энэ улайрал бол Монголын төрийн үйл ажиллагаанд саад учруулж байна. Ийм учраас бид үнэний төлөө бол тууштай явна.

Б.Пүрэвдорж: Нэр дэвшигч Баттөмөрийн Энхбаяр гишүүн хариулна.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын дарга асан Амарбаясгалан иргэнийхээ хувьд миний биеийг нэр төрд халдсан. Нэр төрөө сэргээлгээ гэдэг хүсэлтийг иргэний шүүхэд хандсан. Энэ иргэний шүүхийн надад мэдэгдэх хуудас өнгөрсөн 7 хоногийн 5 дахь өдөр буюу одоогоос яг 7 хоногийн өмнө миний гэрт ирсэн. Би хүлээж авсан байгаа. Энэ бол иргэний хэрэг гэж Амарбаясгалан гомдол гаргасан.

Амарбаясгалан энийг гэмт хэрэг гэж үзэж ерөөсөө цагдаад ч хандаагүй, өөр хуулийн байгууллагад хандахгүй байгаа. Яагаад. Өөрөө айж байгаа. Хэрвээ гэмт хэрэгт намайг гүтгэлээ гэж эрүүгийн журмаар өгөх юм бол хууль хяналтын байгууллагад өөрсдөө нотлох баримтыг цуглуулах ажиллагаа хийдэг байхгүй юу.

Б.Пүрэвдорж: Аюушийн Ариунзаяа гишүүн нэмж тодруулъя.

А.Ариунзаяа: Яах вэ, шүүхийн аль шатанд нь ямар гомдол гаргах нь өөрөө бас ялгаатай байдаг юм байна гэдгийг ойлголоо. Зарим шүүхийг нь бол та үл тоодог юм байна. Заримыг нь бол чухал гэж үздэг юм байна.

Хууль ч гэсэн ер нь өөр өөр хүнд өөр өөрөөр үйлчилдэг юм байна гэдгийг үндсэндээ харж байгаа. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дараах Хүрэлсүх Ерөнхий сайдын өөрөө огцрох хүсэлтийг дэг байхгүй байгаа учраас 32 гишүүн тухайн үеийн нөгөө гишүүдийн тоогоороо өргөн барьсантай, огцруулах бичиг өргөн барьсантай адилтган үзэж дэгээр явъя гэдэг саналыг Бямбацогт сайд тухайн үед гаргаж байсан. Тэмдэглэл нь байгаа юм. Яг адилхан зарчмаар яг адилхан л асуудал явсан. Хуралдааныг та удирдсан. Тэгээд яг адилхан үг үсэгтэй, яг адилхан зарчим нь явж байхад эмэгтэй дарга маань буруутаад, Занданшатар дарга маань тэгээд зөвтгөөд явдаг юм байна лээ. Тэгэхээр хууль өөрөөр үйлчилдэг гэдгийг ойлгосон.

Б.Пүрэвдорж: Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар хариулна.

Г.Занданшатар: Ариунзаяа гишүүн ээ, энийг би маш тодорхой танд тайлбарлая гэж бодож байна. Та бас анхааралтай уншаарай. Ойлгохыг хүсье. Ерөнхий сайд Хүрэлсүх тухайн үед гишүүдийн саналаар биш ¼-ээс дээш гишүүдийн саналаар биш, өөрийн хүсэлтээр огцрох хүсэлтээ тавьсан.

Үндсэн хуульд нийт гишүүдийн ¼-ийн огцруулах санал гаргасан бол уг саналаар санал хураалт явуулахаар зохицуулсан. Өөрийн хүсэлтээр гэж байхгүй. Тэгэхээр өөрийн хүсэлтээр санал гаргасан хүнийг огт гаргаагүй гишүүдийн санал хураалтаар санал хурааж болохгүй байсан учраас Байнгын хороо дээр горимын санал гаргаж шийдвэрлэсэн юм. Ойлгож байна уу. Яаж адилтгах юм. 1 нь гишүүдийн саналаар огцрох процесс, нөгөөдөх нь нэг нь нийт гишүүдийн ¼-ээс намайг огцруулах санал гаргачихсан. Хүрэлсүх дарга чинь өөрөө огцрох хүсэлтэйгээ өгчихсөн. Өөрөө огцрох хүсэлтээр гэсэн Үндсэн хуулийн заалт байхгүй. Тэр угаасаа өөрийнх нь хүсэлтээр санал хураалт явуулах заалт .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Тэгэхээр тэмээ, ямаа 2-ыг адилтгаж үзэх гээд байгаад чинь л би гайхаад байгаа юм. Ариунзаяа гишүүн ээ. 1 нь өөрийнхөө хүсэлтээр огцорч байгаа процесс. Өөрийнхөө хүсэлтээр огцорч байгаа хүнийг гишүүдийн саналаар санал хураалт яаж явуулж болох юм бэ. Гаргаагүй гишүүдийн санал хураалтаар явуулах ёстой гэж та шаардаад байх юм. Энэ чинь жинхэнэ давхар стандарт. Нөгөө дабл стандарт. Өөрөө огцрох санал гаргачихсан хүнийг чамайг гишүүдийн саналаар санал хураалт болгож огцруулъя гэх юм уу. Өөрийнх нь саналаар санал хураалт явуулж болохгүй байсан учраас Байнгын хороо дээр горимын санал гаргаад, түүний горимын саналыг Байнгын хорооны гишүүд дэмжээд, дэгд байхгүй зохицуулалтаар шийдвэрлэж явсан юм. Тэр үед 76 гишүүнтэй байсан парламентын дэг, бас өөрөө огцрох санал гаргасан энэ 2 шал өөр прецидент жишгийг одоогийн гишүүдийн олонхын саналаар гаргаж явна гэсэн 126 гишүүнтэй парламентын дэгтэй авчирч мөргүүлээд, тэмээ, ямаа 2-ыг харьцуулаад, 1 өндрөөр хаалгаар гарах ёстой гэж шаардаад байгаа чинь өөрөө .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Тэгэхээр би Ариунзаяа гишүүний асуудлаар би бас тодорхой зүйлийг хэлчихье. Над дээр ийм 2 бичиг ирсэн. Энэ бүлгийн даргыг чөлөөлөх тухай Жадамбын Бат-Эрдэнийг Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй. Нөгөөдөх нь бүлгийн гишүүдийн олонхын саналаар Жигжидийн Батжаргалыг Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн даргаар сонгосугай гэдэг ийм 2 бичиг ирсэн байгаа. Тэгээд энэ дээр нь хоёулан дээр нь 36 гишүүн гарын үсэг зурсан байна. Тэгэхээр энэ 1 дэх өдөр бүлгийн хурал болох ёстой. Би энийг өнөөдөр танилцуулахгүй. Ер нь бол та бүхэн хоорондоо бас энэ бүлгээ бүрэн бүрэлдэхүүнээрээ хуралдуулаад, бүлгийн даргаа албан ёсоор сонгоод, хүрээд ир. Би тэгэнгүүт уншаад танилцуулахад бэлэн байна гэдгээ хэлье.

Бас энийг танилцуулах юм бол 1 хэсэг хүмүүсийн эрхийг зөрчих ийм асуудал гарч байна. Тийм учраас энэ 1 дэх өдрийн хуралдаанаараа энэ бүлгийн даргынхаа асуудлаа шийдвэрлээрэй гэж хүсье. Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Ерөнхий сайд орж ирсэн учраас би 1 захиас бас ярианыхаа өмнө захиж хэлэх гэсэн юм.

2, 3 хоногийн өмнө энэ Сангийн сайд хэвлэлийнхнийг цуглуулж байгаад багш нарын цалин 2 сая гарчихсан байна, 3 сая гарчихсан байна гээд нэлээн хангалуун цалин аваад байгаа юм шиг худлаа яриад байна лээ. Яг өчигдөр бол жишээлэхэд Баянхонгор аймгийн Номгон сургууль болон бусад сургуулиудаас багш нар над руу маш олноороо мессеж бичиж байна. Гар дээрээ 1 сая 200 мянган төгрөг авч байна. 1 сая 400 мянган төгрөг авч байна. Цалин нэмэгдүүлээд өгөөч ээ л гэж гуйж байна.

Тэгэхдээ багш нартаа хандаж хэлэхэд цалин нэмэгдэх асуудал дээр Улсын Их Хурлын гишүүд бол багш нарынхаа талд буюу цалин нэмүүлэх талд байгаа шүү. Тийм учраас аль болох энэ ажил хаях асуудлаа нэг талд нь хурдан гаргаад, хүүхдүүддээ эрдэм боловсрол олгох ажилдаа анхаараарай гэж захиж хэлэх гэсэн юм.

Тэгээд сайдад нэр дэвшигч Энхбаяр гишүүнээс асууя. Улсын Их Хурлын дарга байсан Амарбаясгалан дарга бол хэвлэлийн хурал хийхдээ хэлсэн. Монгол Ардын

намын тодорхой нэр бүхий гишүүд тойрч сууж байгаад сэтгүүлчийг ялладаг байдлаар яриа яригдаж байсан гэж. Энэ үнэн үү. Энэ бас маш хариуцлагатай яриа яригдсан гэж би бол бодож байгаа. Танаас бас маш хариуцлагатайгаар хариулт хүлээж байна энэ дээр.

2 дугаарт нь Монгол Ардын намын өмнөх дарга, Ерөнхий сайд Авлигатай тэмцэх газрын даргыг санал болгож томилуулсан. Гүйцэтгэх засаглал өөрөө авлигатайгаа тэмцээд, Авлигатай тэмцэх газрын даргыг санал болгож томилуулдаг энэ нөхцөл байдалд авлига буурахгүй байна гэж би бол харж байгаа. Тэгээд тийм учраас Авлигатай тэмцэх газрын даргыг Улсын Их Хурлаас санал болгоод, томилдог байдал руу шилжүүлэх тал дээр та бүгдийн байр суурь ямар байгаа вэ. Тэгэхгүй энэ сүүлийн 10-аад жил завсаргүй засаглаж байгаа Монгол Ардын намын цүнхчингүүд төрөөр дүүрчихсэн. Дунд шатаар дүүрчихсэн. Энд бөөн авлига үүсдэг болсон. Үүний энэ толгой нь гарч ирээд, Монгол Ардын намынхан хоорондоо авлигачин, хулгайч биш, мөн гээд л хэрэлдээд байгаа юм. Энэ дээр та нөхдийн бас байр суурийг сонсох гэсэн юм.

Тэгээд дараагийн дугаарт нь энэ өмнөх Засгийн газрын Хууль зүйн сайдаар ажиллаж байсан Оюунсайханы Алтангэрэл сайд энэ Хөрөнгө хураах хуулийн төслийг 2025 оны 5 сард өргөн барьсан. Энэ хуулийг батлах уу Ерөнхий сайд аа, Хууль зүйн сайд аа, нэр дэвшигч ээ.

Тэгээд эцэст нь болохоор төрд үүсээд байгаа, засагт үүсээд байгаа энэ хямрал бол энэ танай намын буюу энэ Монгол Ардын намын энэ бага хурлаас, бага хурлын шийдвэрээс болсон. Тэгээд энэ асуудлууд дээр чинь энэ даргынхаа сонгуулиас боллоо гэдэг асуудлууд яригдаад байгаа. Энийг нэг талд нь цэгцлээд, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр ч гарчихлаа. Одоо хэдүүлээ урагшаа хараад, цалин нэмүүлье гэж байгаа төрийн албан хаагч зөвхөн багш, эмч нар биш, бүх төрийн албан хаагч нар ер нь цалингийн хүнд нөхцөлд ажиллаж байгаа. Энэ цалингийнхаа нэмэгдлийн асуудлуудыг яриад, утаа боллоо, өвөл боллоо, хүйтэрлээ, одоо/минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар хариулна.

Г.Занданшатар: Даваагийн Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7-д “Засгийн газар хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн дэг журмыг сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж Засгийн газрын бүрэн эрхийг томьёолсон байдаг. Хууль тогтоох эрх мэдэл бол хууль тогтоож, түүнийг хууль биелүүлэх үүргийг Засгийн газар хариуцдаг. Энэ Үндсэн хуулийн зарчмын хүрээнд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дараа Монгол Улсын Ерөнхийлөгч Авлигатай тэмцэх газрын даргыг санал болгож, Улсын Их Хурлаар томилдог байсныг өөрчилж, тэр үед чинь хонгил энэ тэр үүсээд байна гээд Засгийн газар, Ерөнхий сайд санал болгож, Авлигатай тэмцэх газрын даргыг томилдог болсон. 6 жилийн хугацаатай томилдог болсон. Энэ хуулийн өөрчлөлтийн дагуу өнгөрсөн онд шиг санаж байна. Тийм ээ. Монгол Улсын Их Хурлаас өмнөх Засгийн газрын үед Авлигатай тэмцэх газрын даргыг 6 жилийн хугацаагаар томилсон. Энэ бол томилгооны хариуцлага, томилгооны тогтвортой байдлыг хангасан. Энэ хэн нэгнээс хамаардаггүй, бие даасан, хараат бус Авлигатай тэмцэх газар үйл ажиллагаа явуулахын тулд ямар ч Ерөнхий сайд томилогдсон, түүнээс үл хараат бус байдлаар авлигатай тэмцэх үйл ажиллагаа зохион байгуулахын тулд 6 жилийн

хугацаагаар томилдог болсон байгаа юм. Тэгэхээр энэ хэн нэгэн Ерөнхий сайдын юм уу, Хууль зүй, дотоод хэргийн сайдын өнгө үзэмжээр хэрэг нээдэг, хаадаг, шалгадаг, үздэг, хардаг юм байхгүй. Энэ Үндсэн хуулийн заалтаа л хэрэгжүүлэх ёстой.

2 дугаарт нь бол өнгөрсөн 3 сарын хугацаанд бид өдөр, шөнөгүй ажиллаж, эдийн засгийг сэргээж, төсөв дээр ч гэсэн нэмэлт орлого олж, экспорт нэмэгдэж, цалин, тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх боломж бий болсон. 9 дүгээр сарын 1-нд даанч төсөв өргөн барьдаг болчихсон. Тэгтэл 9 дүгээр сарын гүйцэтгэлээр бид нар төсвийн орлого нэмэгдэх боломжтой. Гагцхүү энэ тогтворгүй байдал, Засгийн газрыг огцруулах ажиллагаа төрийн бүх шатад экспортод ч нөлөөлж байна. Төсвийн орлогод нь нөлөөлж байна. Татвар төлөлтөд ч нөлөөлж байна. Энэ багш, эмч нарын цалинг нэмэгдүүлэх боломжийг хязгаарлаж байна. Би өнөөдөр сая хэлсэн үгэндээ хэлсэн. Бортээгийн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг Их Хурал шийдээд өгөөч ээ гээд би үндсэндээ 2 сар болох гэж байна. Энэ тогтоол батлагдах юм бол багш, эмч нар, тэтгэвэр тэтгэмжийг шаардлагатай түвшинд нэмэгдүүлэх боломж бүрдэнэ. Энэ авлига, нүүрсний хулгайтай тэмцсэний үр дүнд бид цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлнэ. Шаардлагатай бол төсвийн тодотгол хийнэ. Үүний чинь орлого, далд эдийн засаг хэдээр ил болохыг бид өнөөдөр тодорхой хэлж чадахгүй ч үүгээр ард түмэндээ баялгийн үр өгөөжийг хүртээж, тэгш шударга, хүртээмжтэй болгож чадна. Хуваарилалтыг ил тод болгож чадна гэдгээ баттай итгэж байна. Ийм ч учраас бид бүгдийг ил тод болгож байгаа. Ард түмнийхээ хяналтад оруулж байгаа. Жаргалан гишүүн шаардаад байсан. Бид тэр Тавантолгойн нүүрсний гэрээнүүдийг нууцаас бусдыг нь бүгдийг нь ил болгосон. Нууцыг нь ил болгосон. Зарим гэрээ бол 2 улсын хоорондын гэрээ харилцан бие биеэсээ зөвшөөрөл авах ёстой гэсэн ийм агуулгатай, зарим заалттай гэрээнүүдээс бусад нь бол бүгдийг нь ил тод болгож байгаа. Ингэж байж бид ил тод байдлыг хангаж байж, эдийн засгаа сэргээж чадна. Ийм учраас энэ баялгийн хараал, хулгайтай тэмцэх ажлыг бол бид зогсоож болохгүй. Харин Их Хурал дэмжиж, хамтарч ажиллах ёстой гэж би бодож байгаа юм. Ингэж байж Монгол Улс сэргэнэ, хөгжинө. Өнөөдөр бүх шатад ямар хэмжээний хүнд суртал, чирэгдэл, авлига нуугдаад байгаа вэ гэдгийг ард түмэн шүүмжилж ярьж байна шүү дээ. Яаж бизнес эрхлэгчдэд хүндрэлтэй, чирэгдэлтэй болгоод байна. Энэ жишгээс хойш бүх түвшинд анхааруулга .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Ер нь тэгээд тийм болчимгүй яриа хэдэн хүн тойрч сууж байгаад шүүхийн шийдвэр ярьдаг, би лав амьдралдаа үзээгүй. Мэдээж Их Хурал дээр ч, энгийн түвшинд ч хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах, сэтгүүлчдийн эрх, эрх, эрх чөлөөг хамгаалах, иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх яриа бол болж байсан.

Түүнээс биш Монголд тийм юм хаана ч байхгүй гэдэгт итгэж байна. Тойрч сууж байгаад энэ бол бүхэл бүтэн засаглалын нэг салаа мөчир Үндсэн хуульт байгууллагад бас ингэж ор үндэсгүй, төрт ёс руугаа халдсан ийм үг, яриа гаргаж болохгүй байх гэж би бас хатуу, тийм яриа би л лав хэзээ ч сонсож байгаагүй, ярьж байгаагүй.

Б.Пүрэвдорж: Баттөмөрийн Энхбаяр гишүүн нэмж хариулъя.

Б.Энхбаяр: Би маш тодорхой асуултад маш тодорхой хариулъя. Өнөрцэцэг гэх сэтгүүлчийг 5 хүн Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Хэрэг эрхлэхийн сайд, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд гэсэн ийм хүмүүс нийлчихсэн хорьё, барья гээд, тэгсэн чинь Хэрэг эрхлэхийн сайд нь хорихгүй гээд, Ерөнхий сайддаа хорих юм бол би ажлаа өгнө гээд ярьсан гэж ярьсан шүү. Ийм утгагүй, би бол ерөөсөө ойлгохгүй байгаа. Энэ асуудлыг байна шүү дээ. Би илт худал мэдээлэл тараах гэдэг гомдол гаргах юм бол Амарбаясгалан ял авна. Эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн гэдгээр ял авна. Энэ тодорхой.

Ер нь нэг сэтгүүлчийг турхирч байсан хүмүүс нь тодорхой болчихсон шүү дээ. Амарбаясгалан .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Цогтбаатар гишүүн нэмж тодруулъя.

Да.Цогтбаатар: Хөрөнгө хураах хууль өргөн барьчихсан хэзээ батлагдах юм.

Б.Пүрэвдорж: Ерөнхий сайд нэмж хариулъя.

Г.Занданшатар: Оюунсайханы Алтангэрэл сайдын өргөн мэдүүлсэн хууль Улсын Их Хурал дээр өргөн баригдсан. Хэлэлцүүлэгдэж байгаа гэж ойлгож байгаа. Засгийн газар хууль баталдаггүй гэдгийг би сая тодруулж хэлсэн. Энэ бол Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал бөгөөд Улсын Их Хурал дээр энэ асуудал хэлэлцэгдэж байгаа гэж ойлгож байна.

Б.Пүрэвдорж: Цогтбаатар гишүүн нэмж тодруулъя.

Да.Цогтбаатар: Авлигатай тэмцэх нь Засгийн газрын ажил гээд сая Ерөнхий сайд өөрөө хэлчихлээ. Тэгээд манай Монгол Улс чинь 180 орноос 114-д авлигынхаа индексээр жагсаж байгаа. 100 хувь авах үнэлгээнээс 30 хувийг нь буюу “F” 50, 60-даа ч хүрэхгүй байна. Яг энэ дээр хэзээ, ямар үр дүнд хүрч, бодитой ажил хийгдэж, бодитой авлига буурах вэ. Энэ дээр таны байр суурь.

Б.Пүрэвдорж: Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Даваагийн Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Манай Засгийн газар байгуулагдаад хамгийн анхны гаргасан албан даалгавар бол 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдөр “Авлигатай тэмцэх тэмцлийг эрчимжүүлэх, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх” ийм албан даалгавар гаргасан. Уг албан даалгаварт бас авлигын индексийг урагшлуулах, үүний тулд Засгийн газрын ил тод байдлыг хангах. Ил тод байдал бол бүхий л түвшинд энэ авлигатай тэмцэх хамгийн сайн шийдэл. Ийм ч учраас энэ олон гэрээнүүдийг бүгдийг нь ил тод болгож байгаа. Ингээд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжилтийг эрчимжүүлж, авлига, албан тушаалын гэмт хэрэг гаргах шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээнд төлөвлөгөө боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг тухайн үеийн Хууль зүй, дотоод хэргийн сайд өгсөн. Бас авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж, үндэслэлгүй хөрөнгөжсөн, нийтийн өмчийг шамшигдуулсан нийтийн албан тушаалтнуудад хариуцлага тооцох, хууль бусаар олсон орлогыг нь хураах талаар шийдэл гаргаж, саналыг Засгийн газрын хуралдаанд 8 сард танилцуулахыг үүрэг болгосон байдаг. Мөн хууль бусаар олгосон..../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Сандагийн Бямбацогт гишүүн асуулт асууж,үг хэлнэ.

С.Бямбацогт: Худлаа үгийг мянга давтал үнэн болчихдог. Ямар нэг аргаар л ялж байх юм бол ялагчийг шүүдэггүй. Хуйвалдаад, хууль зөрчөөд ялж л байвал ялагчийг шүүдэггүй гэдэг үзэл, хандлага сүүлийн хэдэн жил бас их ноёрхлоо. Үнэнд бас гүйцэгдэх өдөр ирдэг юм байна. Сонгуульд худлаа хэлээд, хууль зөрчөөд, худлаа амлаад ялчихдаг. Засгийн газраа, намын бага хурлаа дүрмийн бус хийгээд дарга болчихдог. Засгийн газраа Үндсэн хууль зөрчөөд огцруулчихдаг энэ үйл явцуудыг та бүхэн бас анзаарч байгаа байх бүгдийг нь. Өнөөдөр тэмээг ямаатай харьцуулаад, тэмээ ямааг чинь уг нь шал өөр гэж Монголчууд ойлгодог шүү дээ. Гэтэл адилхан амьтан, адилхан амьтныг бид нар хулгайлсан, алсан, юу гэдэг юм. Тэгээд амьтны л асуудал шүү дээ энэ чинь гээд байдаг. Тэмээний асуудал, ямааны асуудал 2 чинь шал өөр шүү дээ.

Засгийн газрыг Үндсэн хууль зөрчиж огцруулчихаад Алтанхуягийн Засгийн газрыг ингэж огцруулсан. Эрдэнэбатын Засгийн газрыг ингэж огцруулсан. Хүрэлсүх өргөдлөө өгсөн байхад нь адилхан ингэж л огцруулсан шүү дээ. Тэр Үндсэн хуулийн заалтууд нь шал өөр л дөө. Гэтэл Үндсэн хуулиа зөрчиж, огцруулчихаад үнэнд гүйцэгдээд бас үнэн ялдаг, үнэн тогтдог, худлаа үгийг мянгад давтахад үнэн болдоггүй нь үнэн юм байна гэдэг үнэнд гүйцэгдэж байна. Үндсэн хуулийн цэц энэ шийдвэрийг гаргасан. Одоо Үндсэн хуулийн гаргасан шийдвэрийг бас хэлэлцэнэ, хэлэлцэхгүй. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг бид хэлэлцэнэ гээд ийм асуудал ярьж байгаа. Цэцийн шийдвэр бас албажаагүй, хүчин төгөлдөр болоогүй байхад яагаад Ерөнхий сайд Засгийн газрын сайд, гишүүнээр томилох гээд байгаа юм гэж ярьж байгаа юм. Цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно гээд Үндсэн хуульд заачихсан. Цэцийн шийдвэр Их суудлаараа хуралдсан бол эцсийнх гээд заачихсан. Одоо би Цэцийн дүгнэлт дээрээс уншаад өгье та бүхэндээ.

Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болсны хувьд түүний их суудлын хуралдаанаас Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлаар гарсан бүх шийдвэр эцсийнх байна. Иймээс Ерөнхий сайдыг огцруулсан үйл ажиллагаа Үндсэн хуульд нийцээгүй тухай энэхүү дүгнэлт Үндсэн хуулийн цэцийн эцсийн шийдвэр бөгөөд Улсын Их Хурал энэ талаар хүлээн зөвшөөрөх, эсэх шийдвэр гаргахгүй гээд заачихсан. Одоо ямар ч юу гэдэг юм хэлэлцэх хуулийн хугацаа, хэрэгжих хугацаа болсон, болоогүй гэх ярих шаардлага байхгүй. Ийм байдлаар л олуулаа яриад, ингээд л Үндсэн хууль руу дайраад, Үндсэн хуулиа буруу тайлбарлаад, ингээд бас ялагч болно гэж бодож байвал эндүүрэл.

Ерөнхий сайд Засгийн газрын гишүүнийг томилох Үндсэн хуулиа ... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минут.

С.Бямбацогт: Ерөнхий сайд Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газрын гишүүнээ Улсын Их Хуралд танилцуулаад, томилдог. Энэ эрхийг нь хэрэгжүүлэхгүй 24 хонолоо. Удаа дараа хойшлууллаа. Энэ чинь өөрөө Улсын Их Хурал эс үйлдлээрээ дахиад Үндсэн хууль зөрчиж байгаа. Тийм учраас өнөөдөр энэ танилцуулга хийгдэж байна. Улсын Их Хурлаар хэлэлцэх асуудлаас нам, эвслийн бүлгүүд завсарлага авдаг. Танилцуулах асуудлаар завсарлага авдаггүйб Улсын Их Хурлын тухай хуулийн 30.1.5-д заачихсан байгаа. Ингээд дахиад л мушгидаг Ерөөсөөб Өнөөдөр сая бас Пүрэвдорж дарга уншлааб Монгол Ардын намын бүлэг

10 сарын 14-нд олонх нь хуралдаад, 38 гишүүн хуралдаад, 36 гишүүн гарын үсгээ зураад, бүлгийн даргаа өөрчилсөн. Энэ асуудлыг Булгантуяа даргад, Пүрэвдорж даргад өгөөд уншигдахгүй, танилцагдахгүй удаж байна. Удаж байгаа. Бүтэн гурван 7 хоног бүлэг хуралдаагүй. Улсын төсвийн асуудал, өвөлжилтийн асуудал, шатахууны асуудал, багш, эмч нарын цалингийн асуудал гээд .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Цэндийн Баатархүү гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ц.Баатархүү: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Ер нь Улсын Их Хурал энэ гүйцэтгэх засаглал сүүлийн үед сүүлийн хэдэн жил хулгайтай тэмцэх тухай л яриад байгаа. Шийдэгддэггүй. Ямар нэг хулгайн асуудлыг нийгэмд дэлгэж тавиад, иргэдээ төөрөгдүүлээд ингээд 2 хуваадаг. 60 тэрбумын хэрэг шийдэгддэггүй, ЖДҮ-ийн асуудал шийдэгддэггүй, Нүүрсний асуудал шийдэгддэггүй. Энэ асуудлыг нэг тийш нь шийдээд, буруутай бол буруутай, буруугүй бол буруугүй гэдгийг нь гаргахгүй бол Улсын Их Хурлаараа нэг ийм хулгай шүүдэг. Хөгжлийн бодлого, дэвшлийн тухай хэлэлцүүлэг, бодлогын мэтгэлцээн өрнүүлж байх байтал ингээд ажил, албан тушаал, хулгайтай тэмцэх тухай парламент бол хамаг цагаа зарцуулж байна.

Монгол Улсад хийх ажил маш их байна. Ажлын байрыг бий болгох, түүнийг бий болгодог хувийн хэвшлийг дэмжих, экспортыг бий болгох энэ ажлуудаа ер нь хэзээ хийх юм бэ. Дарга ихтэй улс, үйлдвэр байдаггүй улс, хөгжил дэвшлийн тухай ярьж болдоггүй. Тэгээд энэ асуултад Ерөнхий сайд хариулж өгөөч ээ. Энэ яриад байгаа энэ хулгай зэлгийтэй асуудлаа хэзээ нэг тийш нь шийдэж дуусгах юм бэ. Нэг ийм улс төрийн хэллэг бий болчихлоо. Яг ингээд хуулийн хүрээнд үнэхээр ийм зүйл байгаа юм уу, байхгүй юм уу. Монголын ард түмэн ч гэсэн энийг харж байна.

Цаашдаа Монголын парламент чанартай хууль батлахад цагаа зарцуулмаар байна. Монгол Улсын гүйцэтгэх засаглал яг энэ хуулийг хэрэгжүүлэх, өвөлжилтийн бэлтгэл, Монгол Улсад 1 ч гэсэн үйлдвэр барих энэ асуудалд цагаа зарцуулмаар байна. Тэгээд энэ асуудалд нэг тодорхой хариулт өгөөч ээ. Эргээд жилийн дараа ийм юм яриад суудаг парламент, суудаг Засгийн газар байж болохгүй шүү гэдгийг хэлье. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар хариулна.

Г.Занданшатар: Баатархүү гишүүний асуултад хариулъя. Ер нь бол энэ нүүрсний хулгайтай тэмцэх ажлын хүрээнд энэ онд 58 гэмт хэрэгт холбогдох асуудлыг шийдвэрлэж, 106 хэрэг нээн шалгагдаж байгаа гэсэн мэдээллийг холбогдох хууль хяналтын байгууллагуудаас ирүүлсэн. Ер нь нүүрсний хэрэг гэгч бол улс төрийн өндөр эрсдэлтэй, олон нийтийн дунд шуугиан тарьсан, олон асуудлууд яригддаг. Нүүрсний гэрээ, үнэ цэнээс авхуулаад. Энийг л нэг тийш нь болгоё гэж манай Засгийн газар тэмцэж байгаа. Ийм учраас энэ талаар нүүрсний сонсгол явуулж бас тэр доторх гэдэс дотор асуудлуудыг нь уудалж үзээд, бодитой хэрэг асуудал байна гэж тогтоогоод Авлигатай тэмцэх газарт шилжүүлээд, эр зориг гаргаад, манлайлаад санаачлаад явж байсан Баттөмөрийн Энхбаяр гишүүнийг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар томилж байгаа юм.

Өнөөдөр Монголд хулгай байхгүй гэж яривал Баатархүү гишүүн ээ, энд та итгэх үү. Ард түмэн итгэж байна уу. Ийм учраас хулгайтай тэмцэх нь өөрийгөө нөгөө цацагт хяруул шиг элсэнд толгойгоо хийчхээд, тэрийг харахгүй байна гэж, байхгүй

байна гэж ярих бол үнэхээр Монголын эмгэнэл болно. Ийм учраас өнөөдөр энийг таслан зогсоох ёстой. Тэмцэх ёстой. 1 талд нь гаргах ёстой. Тэгэхдээ хүн хэлмэгдүүлж болохгүй. Бас ял завшуулж болохгүй. Энэ бол хууль сахиулах, хэрэгжүүлэх ажлын үндсэн зарчим. Өнөөдөр иргэдийн улс төр, төрд итгэх итгэл буурч, бухимдал өсөж байгаагийн гол шалтгаан бол ерөөсөө л энэ дарга нарын авлига, хулгай хэтэрлээ гэдэг л ийм шүүмжлэл байна шүү дээ. Энэ дээр бид бодитой арга хэмжээ авч тэмцэхгүй бол энэ ард түмнийхээ итгэлийг олохгүй бол энэ ардчиллын хамгийн том дайсан бол өнөөдөр авлига болчихоод байна. Авлигатай тэмцээд эхлэхээр дарангуйлал гэж ярьдаг болчихсон. Хүн биш хууль засагладаг нийгмийг бий болгоё гэхээр хууль засаглахаар тэрийг дарангуйлал гэдэг болчихсон. Ийм учраас энэ төрийн хууль сахиулах ажил гэдэг бол хэнбугай ч гэсэн хуулийн өмнө эрх тэгш байж, шалгуулж 1 бол нэр төрөө цэвэрлэж, 1 бол энэ асуудлыг мухарлаж байх ёстой. Энэ нэг баахан шуугиан 2022 оны нүүрсний гээд жагсаалыг та бүхэн санаж байгаа. Ард иргэд залуучууд яаж шаардаж, шахаж жагслаа. Энэ олон хэргүүд зарлаад л байдаг, зарлаад л байдаг. Цуутай хүүхэн хуримгүй гэдэг шиг шалгагддаггүй, мухарладаггүй учраас ард түмэн бухимдаад байна. Ийм учраас энийг хэргүүдийг мухарлаж, үнэн бол үнэн, худал гэдгийг худлыг нь тогтоож, ард иргэддээ мэдээлэх ийм үүрэгтэйгээр Хууль зүй, дотоод хэргийн сайд бас томилогдож байгаа.

Тэгэхдээ Хууль зүй, дотоод хэргийн сайд бол улс төрийн үйл буюу хүсэл зориг илэрхийлэгч болохоос биш хэрэг мөрддөг, шалгадаг, хэргийн мөрдөн байцаалтад оролцдог, нөлөөлдөг тийм субъект биш. Ерөнхий сайд ч тийм эрхгүй. Хэрэг уншаад хөөцөлдөөд явдаг хүн биш. Ийм учраас энэ 2022 онд иргэдийн шаардлага жагсаалын дагуу Улсын Их Хуралд нээлттэй сонсгол зохион байгуулж, нүүрсний салбарт байгаа хулгай зэлгийг илчлэх, ил тод байдлыг хангах, төрийн хяналтыг сайжруулах анхны том алхмаа хийсэн. Иргэдийн мэдэх эрхийг хангасан энэ иргэдийн мэдэх эрхийг хангасны хүрээнд хууль хяналтын байгууллагуудын ажил хэрэг хуучирдаггүй гэж шалгагдаад явж байсан. Сая Тавантолгой компани дээр онцгой дэглэм тогтоогоод, дотоод хяналт шалгалтад нь шалгаад эхэлсэн чинь тэр нүүрсний сонсголоор яригдаж байсан асуудлууд үнэн хэрэг дээрээ үнэн, бодитой юм байна гэдгийг нь холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлээд шалгах явцад олон асуудлууд гарч, илэрч эхэлсэн. Энэ бол ард түмний хүсэл зоригор хийгдсэн ажил.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Баатархүү гишүүн нэмж тодруулъя.

Ц.Баатархүү: Хулгай, гэмт хэрэгтэй тэмцэх зайлшгүй шаардлага байгаа гэдэгтэй бүгдээрээ санал нэг байгаа. Хамгийн гол нь энэ олон жил энийгээ мухарладаггүй, нэг тийш нь болгодоггүй, сонгуулийн хэрэгсэл болгоод байгаад л хүмүүс харамсаад байгаа юм. Занданшатарын Засгийн газар ямар ч байсан өөрийн итгэл хүлээлгэж байгаа хүнээрээ өнөөдөр Хууль зүйн сайдаар томилуулж байгаа юм байна. Энэ яриад байгаа зүйлтэйгээ ирэх жилүүдэд, ирэх саруудад бодитой тэмцэл гаргаж, амжилт гаргаасай гэж бодож байна. Эргээд жилийн дараа ийм зүйл яриад байдаг байж болохгүй шүү гэдгийг хэлж байгаа. 60 тэрбумын хэрэг ЖДҮ-ийн хэрэг аль нь ч мухарлагдаагүй байгаа учраас иргэд их бухимдалтай байна.

2 дугаарт энэ хулгай, зэлгийг үндсээр нь таслах, шилэн байлгах, цахимжуулах төрийн оролцоо.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Баатархүү гишүүнтэй санал 1 байна. Тэгээд яах вэ, энэ 2 бас огт яваагүй биш. Нүүрсний хулгайтай тодотголтой хэргүүд нь төмөр зам олборлолт, экспорт, борлуулалт, худалдан авалттай холбоотой системийн зөрчлүүдийг хамарч байгаа. Хэргүүдийн мөрдөн шалгах ажиллагаанаас 124 хэрэг үүсгэж, шалгаснаас 88 хэрэг шийдвэрлэгдсэн. 20 нь шүүхээр хэлэлцэгдээгүй байна. 40 хэрэг мөрдөн байцаалтын шатад байна. Ингэхээр нөгөө ард иргэд шаардаад байгаа юм нь нөгөө томчууд нь нуугдаж үлдчихээд, дунд, доод шатынх нь шалгагдаад байна. Дарга, гишүүд нь ард нь үлдчихээд байна гээд ингээд шүүмжлэгдээд байдаг. Энэ хулгайн олон хэлбэрийг илчилж байгаа хэрэг явдал бол үндсэндээ үүнтэй холбоотой. Хууль хяналтын байгууллагууд дээр анхан шатад шалгаж байсан хэргүүд үр хөврөлөөрөө ингээд шалгагдаад, цаашаа эцэслэгдээд явж байна. Ийм системийн шинж чанартай авлигын энэ том хэргүүд бол бас 1 өдөр илэрчихдэггүй. Энэ тэмцэл, хууль хяналтын байгууллагуудын ажил үргэлжлээд явж байгаа юм билээ..../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Чинбатын Номин гишүүн алга байна. Лутаагийн Энхнасан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Л.Энхнасан: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Би Ерөнхий сайдаас 1 асуулт асууя. Та Их хурлын гишүүн Энхбаярыг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар томилохдоо Монгол Улсын Засгийн газрын хууль, Ерөнхийлөгчийн тухай хуулийг заасан процессыг жоохон алгасаад, тэгээд хэвлэлийн хурлаар томилсныг зарласан. Миний ойлгосноор бол Мөнхбаатар сайдад бол чөлөөлөх шийдвэрийг нь урьдчилж ярилцаагүйгээр ингээд шийдвэр гаргасан байна. Энийг бол зарим судлаачид бол төрийн ёс зүйн харилцаа алдагдаж байна гээд бас шүүмжилсэн байсан. Тэгэхээр би танаас та ойрын хугацаанд танхимын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахаар төлөвлөж байгаа юу. Хэрвээ төлөвлөж байгаа бол цаашдаа энэ жишгээрээ ингээд сайд нарыг томилгоо хийнэ гэж ойлгож болох уу.

Б.Пүрэвдорж: Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар хариулна.

Г.Занданшатар: Энхнасан гишүүний асуултад хариулъя. Энхнасан гишүүн ээ, энэ процесс хэрвээ би одоо ингээд захирамж гаргачихсан бол би хууль зөрчсөн болно. Би улс төрийн шийдвэрээ олон нийтэд мэдээлсэн. Миний хэлсэн үгэнд ийм ийм шалтгааны улмаас Баттөмөрийн Энхбаярыг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар томилохоор шийдвэрлэснээ мэдэгдэж байна гэсэн. Мэдэгдэж байна гэсэн. Ингээд Ерөнхийлөгчтэй албан ёсоор зөвшилцсөн, албан ёсоор танилцуулсан. Албан бичиг хариу нь ирчихсэн. Хавсрагдсан та бүхэнд очсон байгаа. Мөн Улсын Их Хуралд өнөөдөр 24 хоногийн дараа танилцуулж байна. Энэ танилцуулсны дараа би зарлиг гаргана. Захирамж гаргана. Хэрвээ би захирамжаа урьдчилаад гаргачихсан бол энэ хуулийн зөрчил. Улс төрийн шийдвэрээ танилцуулах бол нээлттэй нийгэмд ард түмэндээ мэдэгдэх явдал бол хуулийн зөрчил биш. Гаргаж байгаа шийдвэрээ, гаргах гэж байгаа шийдвэрээ мэдээлж явдаг нь ардчилсан улс орнуудын нийтлэг зарчим. Хуулийн төслийг ч гэсэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээсээ өмнө 30 хоног ард иргэдээр хэлэлцүүлдэг биз дээ. Энэ хэлэлцүүлж байгаа, танилцуулж байгаа шат чинь хуулийн зөрчил биш биз дээ. Ийм учраас ард түмнээсээ нуух юм бидэнд байх ёсгүй гэж үзээд, би энэ гаргасан шийдвэрээ танилцуулсан, олон нийтэд мэдээлсэн. Энийг би Монгол Улсын Ерөнхий сайдад олгосон Үндсэн хуулийн бүрэн эрхийн хүрээндээ олон түмэндээ мэдэгдэж байна гэдгийгээ зарласан.

Цаашдаа ч гэсэн бид энэ зарчмаа баримталж, Улсын Их Хуралдаа хүндэтгэлтэйгээр бас ингэж өнөөдрийнх шиг танилцуулж, Ерөнхийлөгчтэй

танилцуулаад, Улсын Их Хуралдаа танилцуулдаг энэ албан ёсны зарчмаараа явна. Тэгэхдээ бидний, манай Засгийн газрын зарчим бол үнэн байна гэж хэлсэн учраас ил тод байдлыг харин хэзээ ч нуухгүй. Яагаад асуудлыг нууж байгаад л би Их Хуралд оруулж ирэх ёстой гэж та бүхэн үзээд байгаа юм бэ гэдэгт харин би гайхаж байгаа юм.

Б.Пүрэвдорж: Лутаагийн Энхсайхан гишүүн нэмж тодруулъя.

Л.Энхнасан: Тэгэхээр Энхбаяр нэр дэвшигч бол нүүрсний хулгайтай тэмцэх гэж сайд болж байна гэж ойлгож байгаа. Тэгэхээр нүүрсний хулгайч нарыг бүгдийг нь л илрүүлнэ гэж би ойлгож байгаа. Энхбаяр сайд аа тэгж ойлгож болох уу. Та заавал 1 хүнээр туг тахиулахгүйгээр зөвхөн нүүрсний хулгайч гэхгүйгээр Ногоон автобусны хулгайч нар, ЖДҮ-ийн хулгайч нартай бүгдтэй нь тэмцэнэ гэж ойлгож болох уу.

Б.Пүрэвдорж: Баттөмөрийн Энхбаяр гишүүн хариулъя.

Б.Энхбаяр: Мэдээж Хууль зүй, дотоод хэргийн сайдын гол ажил бол гэмт хэрэгтэй тэмцэх, эвлэрэхгүй байх, үнэн байх асуудал. Өөрөө мөрдөн шалгадаг этгээд биш. Хүмүүс болохоор ингэж ойлгоод байх шиг байгаа юм. Ингээд өмнө нь Хууль зүйн сайд байхдаа энэ асуудлаа ярьж байхгүй яасан юм гэж яриад байх юм. Би Монгол Улсын Их Хурлаас байгуулагдсан Хянан шалгах түр хорооныхоо хүрээнд зохион байгуулсан нотлох баримтыг шинжлэн судлах сонсгол дээр нэгэнт ил болсон нотлох баримтууд яриад байгаа шүү дээ. Энэ асуудлууд Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хувьд ярьж байсан асуудал биш байхгүй юу. Би Монгол Улсын Их Хурал дээр яригдаад, Их Хурлын тогтоол гарчихсан. Хууль бус байсан гэдгийг нотлоод тогтоол гарчихсан тэр баримтуудыг л яриад байгаа байхгүй юу. Тийм учраас би дахин дахин хэлээд байгаа. Бид ялагдахгүй гэдэг.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ц.Сандаг-Очир: Би хуралдаан даргалагчид хандаад 1 зүйл хэлэх гэж байгаа юм. Цэцийн дүгнэлт гарсантай холбогдуулж эцсийнх нь ойлгомжтой. Үүний зөв, бурууг хэн ч хэлэлцэхгүй. Гэхдээ Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээж аваад, Цэцийн дүгнэлтийн агуулга, Улсын Их Хурлын 95 дугаар тогтоол Үндсэн хууль зөрчсөн гэж гарсан учраас Их Хурал алдаагаа засах ёстой. Заавал процесс явах ёстой. Байнгын хороогоороо оруулаад, 95 дугаар тогтоолыг хүчингүй болгох асуудлыг яриад, ингээд чуулгандаа оруулж ирээд, энэ тогтоолыг хүчингүй болгосноор Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгчийн жинхэнэ үүрэг, эрх нь хэрэгжинэ гэж би хувьдаа ойлгож байгаа юм.

Тэгэхээр би юу гэж хэлж байна вэ гэхээр энэ хурал чинь бас хууль зөрчсөн асуудал руу явчих вий. Энийгээ сайн үзэж харсан юм байгаа биз дээ гэж нэгд хэлэх гэсэн юм.

2-т би сүүлийн 2, 3 сайд нар Засгийн газрыг хараад л байгаа. Жил ирэх тусам манай энэ Засгийн газрын нэр хүнд улам уруудаж байгаа. Олон нийтийн дунд хүлээн зөвшөөрөгдөх байдал улам унаж байгаа. Би хурал болгон дээр үе үеийн Засгийн газар, сайд нарыг сайн хийж байгаа, болж байгаа бүтэж байгаа нь байгаа л байх. Тэрнээс илүү болохгүй, бүтэхгүй, алдаатай зөрүүтэй зүйлийг нь олон хэлж байсан.

Шүүмжлэлтэй хандаж ирсэн. Тэгээд манай үе үеийн Ерөнхий сайд нар бас хүн танихдаа их муу юм шиг байгаа юм. Дандаа болохгүй, бүтэхгүй гэдэг юм уу, дандаа олон нийтийн дунд нэр хүнд муутай, дандаа ашиг сонирхлын зөрчилтэй ийм хүмүүсийг энэ дотроос олж ирж, тавьдаг. Энэ нь эргээд салбартаа хүлээн зөвшөөрөгддөггүй, олон нийтэд хүлээн зөвшөөрөгддөггүй, ингээд нийгмийн хүндлэл, итгэлийг алддаг. Төр засгийн итгэл энэ дээр унаж байгаа. Тийм учраас ажлаа сайн хийж байгаа сайд нар байгааг би үгүйсгэхгүй. Шинэ тутам сонгогдсон, томилогдсон хүмүүсийг. Энэ үе улиран ажиллаж байгаа, үе үеийн Засгийн газарт орж ажиллаж байгаа энэ сайд нар байгаа. Ах нар байгаа. Энийг ард түмэн мэдэж байгаа. Зарим нэг нь бараг зарим яамдыг хувьчлаад авчихсан, өмчлөөд авчихсан юм шиг аашилж байгаа хүмүүс бий.

Тэгээд өнөөдөр хар. Төсвийн гүйцэтгэл, хүрээ, төсвөө ярихгүй байна гээд гонгиноод, уйлан дуугараад байсан хүмүүс өнөөдөр хэлэлцээд эхлэхээр хаа байна. Сангийн сайд чинь хаа байна. Өчигдөр байсан уу. Байгаагүй. Бямбацогт сайд танилцуулгыг нь уншиж байх жишээтэй. Өнөөдөр чуулгандаа байна уу. Байхгүй. Энийг чинь л бид нар яриад байгаа шүү дээ. Ийм хариуцлагагүй сайд нар олон байгаа учраас энэ Засгийн газрыг огцруулах гэж яриад байгаа чинь .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минут тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Ийм хариуцлагагүй сайд нар энэ Засгийн газарт байгаад байгаа учраас бид бүхэн энэ хариуцлагагүй сайд нарт хариуцлага тооцох гэж яриад байгаа юм. Тийм учраас Ерөнхий сайд та бүрэн эрхээ ахиад шинээр хэрэгжээд эхэлбэл энэ хариуцлагагүй сайд нартаа арга хэмжээ аваач. Хариуцлага тооцооч. Толгойг нь илж явсаар байгаад эд нар чинь сүүлдээ таны толгой дээр, сүүлдээ Улсын Их Хурал дээр сандайлаад суудаг ийм Засгийн газар болж хувирч байна. Өнөөдөр Монголын улс төрд, нийгэм, эдийн засагт хариуцлагын асуудал ус, агаар мэт хэрэгтэй байна. Хэн хаана, хэзээ хариуцлага хүлээсэн юм. Том том хулгай, луйвар яриад байдаг хэр нь хэн өнөөдөр хариуцлага хүлээсэн юм. Энийг чинь ард түмэн уурлаж, бухимдаад байна шүү дээ. Тэр жинхэнэ эзэд нь, тэр нүүрсчид нь хаана байгаа юм. Жинхэнэ хулгайчид нь хаана байгаа юм. Хэн хариуцлага хүлээсэн юм. Тийм учраас өнөөдөр энэ сайд нар дээрээ хариуцлагын арга хэмжээгээ авч, огцруулаач ээ. Арга хэмжээг нь авч .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар хариулна.

Г.Занданшатар: Манай Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Сандаг-Очир гишүүн бас зарчмын асуудал хөндөж байна гэж ойлголоо. Ер нь бол холбогдох Байнгын хороод ажил нь муу хийж байгаа, хариуцлагагүй байгаа сайд нарыг огцруулах саналаа Ерөнхий сайдад санал хураалт хийгээд, танилцуулах Улсын Их Хурлын тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаа. Ер нь манай Засгийн газар бол бас улс төрийн хайчинд, цаг хугацааны хайчинд, төсвийн хайчинд эдийн засгийн уналт, гадаад, дотоод нөхцөл байдалд бүрдэхдээ харьцангуй тухайн үеийн намын удирдлагууд, Улсын Их Хурлын удирдлагууд бас төсөв мөнгө, энэ эрс шинэчлэлүүдийг дэмжинэ гэж итгэж, харьцангуй тэдний саналыг бас сонсож, зөвшилцлийн журмаар байгуулсан нь үнэн. Гэхдээ бид бол тавьдаг шаардлага бүх Засгийн газрын гишүүдтэй авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нэгт, хэрвээ ийм зөрчил гаргах юм бол шууд халж, солино шүү гэдгийг анхааруулсан. Улсын Их Хуралдаа хүндэтгэлтэй хандаж бай гэж анхааруулдаг. Хамгийн анхны

хуралдаанаараа бид хариуцлагын гэрээ байгуулж, хариуцлагын гэрээ байгуулж, энэ хариуцлагыг зөрчих юм бол хариуцлага тооцно гээд заасан. Энэ дагуу хариуцлага тооцож явах болно. Зөрчөөд, хариуцлагын гэрээгээ зөрчөөд байгаа сайд нарт бид хариуцлага тооцно.

Б.Пүрэвдорж: Сандаг-Очир гишүүн нэмж тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Та сая албан ёсоор тавивал гэж байна. Өнгөрсөн 6, 7 сард бид нар тавьсан шүү дээ. Энэ Боловсролын сайдыг чинь өчнөөн олон гишүүд гар, хөлийн үсэг зураад явж байгааг бүгд мэдэж байгаа шүү дээ. Та өнөөдөр хаацайлаад л үлдсэн шүү дээ. Тэр бичиг хаачсан юм. Өнөөдөр салбарынхан нь хүлээн зөвшөөрөхгүй, өнөөдөр ажлаа хийж чадахгүй байна гээд гадаа гудамжинд 10, 20 хоног жагсаж байна шүү дээ. Ажлаа хаячхаад байж байна шүү дээ. Тэгээд яагаад ийм сайдыг өмгөөлөөд байдаг юм. Өөрсдийнхөө Засгийн газар нь тарчих гэж байна гээд ингээд хамгаалаад байгаа юм уу. Албан ёсоор танд тавьсан шүү дээ. Тэгээд л усанд хаясан чулуу шиг өнгөрсөн шүү дээ. Ийм байдлаар ингэж худлаа асуудалд хандаж, худлаа микрофон ашиглаж худлаа ярьдгаа боль. Энэ чинь албан ёсоор гишүүд гарын үсгээ зураад, өргөн барьсан. Би ч гарын үсэг зурсан. Гэтэл өнөөдөр тэгээд ямар арга хэмжээ авч байгаа юм. Тэгээд боловсролын салбар чинь үнэхээр сайн байгаа юм уу. Энэ багш нар чинь, өнөөдөр энэ хүүхдүүд яаж байна.

Б.Пүрэвдорж: Ерөнхий сайд нэмж хариулъя.

Г.Занданшатар: Манай Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга хууль, эрх зүйн хувьд ийм дутуу ойлголттой байгаад харамсаж байна. Сайд нарыг Улсын Их Хурлын гишүүдийн саналаар огцруулдаг асуудал Үндсэн хуулийн зөрчилтэй болоод хуульчлагдчихсан. Дахин хэлж байна шүү дээ. Гишүүд явуулдаг чинь өөрөө зөрчилтэй болчихож байгаа юм. Байнгын хороогоороо хэлэлцээд, олонхын саналаар санал дэмжигдээд, тэрийг Ерөнхий сайдад тавина гэсэн Улсын Их Хурлыг хуультай 1-д.

2-т дөнгөж томилогдоод 3 өдөр болж байгаа сайдыг огцруулах гэж асуудал тавьсан. Тэгээд өмнөх Засгийн газрын үед тэгвэл тавьж байхгүй яасан юм. Өмнөх Засгийн газрын үед ажиллаж байсан сайд шүү дээ. Ийм нэг дабл стандарттай, давхар үгтэй, өнөөдөр хэлснээ маргааш өөрчилж байдаг ийм үйл ажиллагаанууд бол зарчимд нийцэхгүй. Энэ бол ХҮН намтай Монгол Ардын нам гэрээ байгуулаад, хамтарч ажиллаад, бага хурал дээрээ .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Сандаг-Очир гишүүн бас надад хандаж асуудал ярьж байна. Тэгэхээр Үндсэн хуулийн цэцийн шийдвэр бол эцсийн шийдвэр байгаа. Тэгээд энэ асуудлаар Улсын Их Хурал аливаа нэгэн шийдвэр, хүлээн зөвшөөрөх, эсэх талаар шийдвэр гаргахгүй. Үүний дараа бас 1 асуудал байгаа. Өөрөөр хэлбэл Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэх ёстой. Хэрвээ Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах юм бол автоматаар Засгийн газрыг, Ерөнхий сайдыг огцруулсан нь тэр Их Хурлын тогтоол бол автоматаар хүчингүй болно. Хэрвээ Их Хурал Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авахгүй бол бас тодорхой зөрүүтэй асуудлууд гарна. Тэгэхээр эцсийн шийдвэр Цэцийнх учраас Ерөнхий сайдыг огцруулах тухай асуудал бол шийдэгдсэн гэж ойлгож болно. 1 дүгээрт.

2 дугаарт би нэг зүйлийг хэлэхэд Үндсэн хуулийн цэц Ерөнхий сайдыг огцруулах тухай асуудлаар Үндсэн хууль зөрчсөн байна гэдэг ийм дүгнэлт гаргасан

болохоос биш 16, 17-ны өдрийн ирцийн асуудлаар аливаа нэгэн иргэн хүсэлт өгөөгүй учраас энэ асуудлаар ерөөсөө шийдвэр гараагүй. Тийм учраас энэ өнөөдрийн хурал, түүгээр хэлэлцэж байгаа асуудал бол албан ёсны байна гэдгийг бас хэлье. Дараагийнх нь Бадарчийн Хэрлэн гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Хэрлэн: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр Монгол Улсын Ерөнхий сайд Улсын Их Хурлын тухай хуулийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдаар томилж байгаа Баттөмөрийн Энхбаярыг өнөөдөр Улсын Их Хуралд танилцуулж байна. Тэгэхээр олон нийтэд мэдэгдсэнээсээ хойш гурван 7 хоногийн дараагаар өнөөдөр энэ танилцуулгыг хийж байгаа.

Баттөмөрийн Энхбаяр таныг Хууль зүй, дотоод хэргийн сайд болоод шударга ёсыг бодитой тогтооход томоохон өөрчлөлт хийнэ гэж ард түмэн найдаж харж байгаа. Өнөөдөр Монголын нийгэмд буруу, зөв, үнэн, худлаагаа ялгаж мэдэхээ байтлаа бие биеэ хардаж, сэрддэг болсон. Хамгийн гол нь төр засагтаа итгэх итгэл ерөнхийдөө алдрах талдаа байгаа. Монголын ард түмэн ер нь бол хуулийн дагуу байвал сая шударга болно гэж бодож итгэж ирсэн л дээ.

Гэхдээ сүүлийн үед бид нар олон нийтийн хэвлэл мэдээллээр би дарамтад өртөөд байна. Би айдаст автаад байна. Би заналхийлэлд өртөөд байна гэх жишээтэйгээр зарлаж, тэгээд ер нь надад туслаач ээ гээд үг хэлээрээ, үйлдлээрээ орон даяараа зарлаад байх ийм байдалтай болчихлоо. Тэгээд энэ илт худал мэдээллээр олон түмнийг төөрөгдүүлэх, олон түмнийг хямраах явдал бол ер нь хавтгайраад байна. Тэгээд худал хурдан ч үнэнд гүйцэгдэнэ гэж үг байдаг. Тэгэхээр би таныг Хууль зүй, дотоод хэргийн сайд болоод энэ шударга ёсыг бэхжүүлэхийн тулд хуулиа дээдэлж, хуулийн өмнө бүгдээрээ адил, тэгш эрхтэй байх энэ зарчмыг бодитой болгохын тулд бүрэн эрхийнхээ хүрээнд энэ салбарын бодлого, үйл ажиллагаанд ямар өөрчлөлт хийнэ гэж бодож, төлөвлөж байгаа вэ гэж би танаас асуумаар байна.

Шулуухандаа хэлэхэд хуучин жишгээр явах юм бол, хуучин жишгээр та ажил хэргээ явуулах юм бол үнэн худлыг гүйцэж чадахгүй л дээ. Тэгэхээр энэ хууль зүйн салбарын хүрээнд та шинэ жишгийг бий болгоорой. Худал, үнэнийг ялгаж өгдөг ийм шинэ жишгийг бий болгож өгөөрэй гэж би танд хэлмээр байна.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

С.Эрдэнэболд: Цаг бага учраас товчхон асуучихъя. Монгол Улсын Ерөнхий сайд аа, Монгол Улсын яг давхардаагүй тоогоор та 32 дахь Ерөнхий сайд. Өмнөх Ерөнхий сайд нар энэ улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, эрх чөлөөг бие даасан, хараат бус байлгах гэж эдийн засгийн оюун санааны хувьд энэ улсын тусгаар тогтнолыг бий болгох гэж зүтгэж ирсэн. Сайн нэртэй ч хүмүүс байгаа. Саар нэртэй ч хүмүүс байгаа. Амь насаа алдаж, бусдын нутагт цаазлуулсан ч хүн байгаа. Эх орондоо ч ирж чадахгүй хүмүүс байгаа. Тэгэхээр Монгол Улсын Ерөнхий сайд гэдэг бол дуртай аавын хүү, ээжийн охин санаан зоргоор суугаад хийдэг ажил биш. Энэ бол бас мянганаар өртөөлсөн Монголын алтан төрийн түүхийн жолоо, цулбуурыг атгаж яваа хүний хувьд хувийн ашиг сонирхлоо улдан хаяж, зөвхөн нийтийн эрх ашгийн төлөө нэгэн үзүүрт сэтгэлээр амь биеэ үл хайрлан тэмцэх ёстой ажил. Тэгэхээр сүүлийн үед таныг дарангуйлалтай холбогдож, хардаж сэрдэх болж

байна. Та энэ дээр яг цэгцтэй товч хариулт өгөхгүй юу. Та ер нь дарангуйллыг дэмжиж байгаа ямар нэгэн үг, үйлдэл гаргасан уу.

2 дугаарт Ерөнхий сайдын хувьд ер нь энэ огцрох асуудал бол Монголын Ерөнхий сайд нар огцорч болно. Гагцхүү энэ асуудал хууль зүйн хувьд явах ёстой гэсэн итгэл үнэмшил хийгээд, Үндсэн хуулийн зарчмаар өрнөх ёстой гэсэн хуульчийн бодол байдаг. Та Ерөнхий сайдын хувьд 1, 2, 3 гээд хэлэхэд хамгийн том ямар өвийг үлдээх гэж ажиллаж байгаа юм бэ. Энэ төрд зүтгэж байгаа юм бэ.

Энд бол дахин ачаалж байна. Цэцийн шийдвэр гарсан учраас та ажлаа үргэлжлүүлээд хийнэ. Багш, эмч нар, ахмадууд бухимдаад байгаа. Ер нь нийгэмд асар их бухимдалтай байгаа энэ асуудал бол зөвхөн цалингийн асуудал бас биш. Нийгэмд шударга бус байдал хавтгайрсан, далд эдийн засаг удирдсан, хулгай зэлгий өрнөсөн, зөв зүйл, хөгжилд зарцуулагдах ёстой мөнгөнд чадахгүй байгаа учраас хүмүүс бухимдаад байгаа. Тийм учраас та энэ микрофон дээр багш нарт, эмч нарт, ахмадуудад хандаж яг байр сууриа хэлээч ээ. Одоо олон мессеж ирж байгаа. Таныг үйл ажиллагааг чинь хүчтэй байлгах зүйл бол ил тод байдал. Та өөрөө зөвлөлдөх ардчилал гэж бас ярьдаг. Энэ ажил бас явах шаардлагатай байна. Өнөөдөр хэвлэл мэдээлэл дээр мөнгө төгрөгийн дайн, хэвлэл мэдээллийн энэ дайн бол эргээд энэ улс орны оюун санааны хувьд утгагүй болгож байна.

Дараа нь Энхбаяр сайдаас хүмүүс таныг нүүрсний хэрэгтэй тэмцэх гэж сайд болж байгаа гэж ярьж байгаа. Гэхдээ энэ авлигын асуудал гэж харж байгаа. Zandaa Goosh гээд энэ Од мөндрийн үүсгэн байгуулагч хүсэлт явуулжээ. Танаас асуугаад өгөөч ээ гэж.

Энхбаяр сайдын нүүрсний хулгайтай тэмцэнэ гээд зорьж байгаа энэ ажлын үр дүнг юугаар хэмжих юм бэ. 1 дүгээр асуулт.

2.Ямар хэмжүүрээр энэ тэмцлийг амжилттай болсон эсвэл амжилтгүй болсон гэж үзэх юм бэ.

3.Нүүрсний хулгай гээд байгаа энэ хэдэн төгрөг хулгайд алдагдсан ... хурал даргалагч аа, 1 минут нэмж авъя.

Б.Пүрэвдорж: Эрдэнэболд гишүүнд 1 минут нэмж тодруулъя.

С.Эрдэнэболд: 3 дугаарт нүүрсний хулгай гээд байгаад яг хэдэн төгрөг алдчихсан юм бэ. Хэвлэлээр яваад байгаа тоо хэр бодитой юм бэ. Хэдийг нь улсынхаа сан хөмрөгт буцаан авчрах зорилготой байгаа юм бэ. Ойролцоогоор хэдэн хүн энэ гэмт хэргийг үйлдсэн, тэндээс хэдэн зохих ял шийтгэлээ хүлээхгүй бол энэ тэмцлийг амжилттай буюу Энхбаяр сайд ажлаа сайн, эсвэл муу хийсэн гэдгийг дүгнэх юм бэ гэдэг асуултыг асуулгаж байна.

Ер нь та ингээд сайд болно. Би тэгж бодож байна. Би ингэж хардаж байна. Би ингэж таамаглаж байна гэдэг зүйлийг та энэ цагаас эхлээд ярьж болохгүй. Баримт нотолгоотой, зөвхөн хүйтэн логик, бодит факт, хуулийн хүрээнд та асуудлыг ярих ёстой. Цаашдаа хэвлэл мэдээллийн сенсац болдог сэдэв биш, хууль хэрэгжилтийн шударга ёсыг тогтоодог үг, өгүүлбэрийг та хэлэх ёстой шүү. Асуултад хариулт .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Гол асуултад Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Бярлалаа. Сүхбаатар Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Ер нь Монголын ард түмний хамгийн дээд хүслэн бол шударга ёсыг тогтоох явдал байна. Энийг хүн болгон мэдэж байгаа. Тэгэхээр намайг дарангуйлагч болох гээд байна уу гэж байгаа юм. Одоо ер нь энэ дээд хүслэн болсон ард түмний хүсэл зоригийг хэрэгжүүлэх энэ ардчилсан ёсны дээд шалгуур мөн. Хууль дээдлэх ёс Rule of law гээд байгаа энэ зарчим чинь өнөөдөр Монголд хэрэгжихээ больчихсон учраас, алагчилж үйлчлээд байгаа учраас ард түмэн энийг хүсэж, шаардаж байгаа. Үүний тулд бид уг нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийгээд, гэнэнээр мөрөөдөж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, хуулийн өөрчлөлтүүд хийсээр байгаад болчих юм байна гэж бодсон чинь яг гүйцэтгэх засаглал дээр ажиллаад, ирээд үзсэн чинь энэ хуулиасаа гадна хувь хүний системийн шинж чанартай авлигад Монголын төр, сонгуулийн систем бүх талаараа ялзрах ийм торгон ирмэг дээр хүрээд ирж. Ийм учраас энэ түүхэн эгзэгтэй цаг үед Монголын заяа их гэж бидэнд оногдсон хувь тавилан бол амь бие үл хайрлан тэмцэж, айдас байхгүй учраас авлига, ашиг сонирхлын зөрчил байхгүй явж ирсэн учраас, бид өнөөдөр энэ түүхэн үүргээ гүйцэтгэх ёстой гэж ухамсарлаж, хатуу тэмцэж, эвлэрэхгүй, шударга ёсны төлөө тэмцэнэ гэдгээ илэрхийлж, би энэ мэдэгдлийг хийж, өнөөдрийн сайдыг томилуулах асуудлыг ч гэсэн оруулж байгаа юм.

Ийм учраас энэ түүхэн эгзэгтэй үед би өөрийгөө 34 дэх Ерөнхий сайд гэж бодож байгаагийн хувьд биш, Монголын нийт ард түмний хүсэл эрмэлзэл болсон Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр энэ баялагтаа Эзэн Монгол, Үндэсний Баялгийн сан, энэ эрх мэдлийн хуваарилалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэхийг мөрөөдөж, тэмцсэний хувьд энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөө амь оруулах явдал, амьдралд хэрэгжүүлэх явдал бол миний үлдээх нэгт legacy өв байх ёстой.

Түүнээс илүү чухал нь манай Үндэсний аюулгүй байдлын, эдийн засгийн, тусгаар тогтнолын, ард түмний хүсэл эрмэлзлийн дээд шаардлага болоод байгаа энэ олон жил шуугьсан нүүрсний хулгай. Нүүрсний гээд нэрлэхихсэн боловч энэ цаанаа баялгийн хулгай. Баялгийн хулгай гэж байгаа боловч үүний цаана бий болчихсон шударга бус тогтолцоог өөрчлөхийг шаардаж байгаа юм. Үүний төлөө бид эцсээ хүртэл тэмцэж явах болно. Энийг харин Эрдэнэболд гишүүн та тууштай дэмжихийг Танаас хүсье. Энэ бол аль нэг намын асуудал биш, ард түмний хүсэл эрмэлзэл болсон ардчиллын шаардлага гэж ойлгох хэрэгтэй. Ардчиллын хамгийн том дайсан бол өнөөдөр дарангуйлал биш авлига болчихоод байна. Бид авлигыг дарангуйлах ёстой болохоос биш, ард түмнээ дарангуйлах ёстой биш. Ард түмнийг авлигаар дарангуйлаад байгаа энэ тогтолцоог өөрчлөхийг дарангуйлал гэж харин авлигачид энэ системдээ идэгдчихсэн хүмүүс өөр ийм тогтолцоо шинэчлэл гэдэг нэрийн дор бүхнийг хуурмаг ажиллагаа явуулж байгааг та бүхэн сайн мэдэж байгаа.

Ийм учраас бидний үлдээх өв бол ядаж энэ нийгэмдээ шударга ёсыг дээдэлсэн Rule of law хууль засагладаг нийгмийг үлдээгээсэй. Эрх зүйт төр байхгүй боллоо гэж.

Би намын дарга болох гэж зүтгээд байгаа юм биш. Намын даргын сонгуульд шударга бусаар, Үндсэн хуулийн үзэл санааг үгүйсгээд тооллогын комиссын журмаар Үндсэн хуульд халдаж байгааг би хүлээн зөвшөөрөхгүй байгаа юм. Яагаад гэвэл тооллогын комиссын журмаар Үндсэн хуулиар баталгаажуулсан засгийн эрхийн тогтвортой байдлыг зүгээр л намын даргыг 50 +1-ээр сонгоод, 50 дээр +1-

ээр огцруулаад байдаг жишиг тогтох юм бол хууль дээдлэх ёс чинь алдагдаад, засаг төр чинь тогтворгүй болоод, шинэ намын дарга нь сонгоод өөрчлөөд, Үндсэн хуульд оруулсан бидний бүх үзэл санаа, үнэт зүйл байхгүй болчхож байгаа байхгүй юу.

Би энэ хууль дээдлэх эрх зүйт төрийн төлөө тэмцэж байгаа учраас Үндсэн хуулиа хамгаалахын төлөө тэмцэж байгаа учраас үүнийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа байхгүй юу. Өнөөдөр энэ явж байгаа Үндсэн хуулийн цэцийн шийдвэр ч Улсын Их Хурал дээр явуулж байгаа үйл ажиллагаа ч гэсэн энэ хүмүүсийн зорилго нь ч буруу, арга нь ч буруу гэдгийг нотолж харуулж байгаа. Ийм учраас бид улам бүр итгэл үнэмшилтэйгээр энэ буруу зөрүү, гажуудлыг засахын төлөө тэмцэх болно. Биднийг Улсын Их Хурлын гишүүд маань энэ зөв үйлсийг.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуултад хариулъя.

Б.Энхбаяр: Яг хэдэн хүнийг шоронд хийснээр нүүрсний хулгайтай хийх тэмцлийн чинь үр дүнг хэмжих вэ гэж. Ер нь гэмт хэргийн асуудлыг санал хураалтаар, тоогоор хэмждэггүй. Үр дүнгээр хэмждэг. Миний хувьд Хөгжлийн банк болон Нүүрсний сонсгол гэсэн энэ 2 удаагийн том хэмжээний сонсголыг зохион байгуулснаар Монголын ард түмэн ялсан. Монгол Улс ялсан. Яагаад гэхээр ямар хэмжээний цар хүрээтэй схемээр, ямар хүмүүс энэ улс орныг тонон дээрэмдсэн бэ гэдгийг илчилсэн. Би мөрдөн шалгагч биш байхгүй юу. Прокурор биш. Ард түмний төлөөлөгчийн гол үүрэг бол би ард түмэндээ үнэнч байсан. Тэгэхээр эцсийн ялагч нь бол та бид хамтдаа..../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж тодруулъя. Эрдэнэболд гишүүний микрофон.

С.Эрдэнэболд: Ерөнхий сайдаас нэмж тодруулъя. Түрүүн 1 дүгээр, 2 дугаар асуултад хариулчихлаа гэж харж байна. Зүгээр яах вэ, одоо бол бид нар энд ингээд бодлогын асуудал ярьж байгаа яг энэ мөчид бид нарын гар утсанд тасралтгүй л багш нараас маань мессеж ирсээр байгаа юм. Тэгээд яах вэ, түрүүн хэлж байгаа санаа болохоор ер нь энэ боловсролын салбараа олон жил хөсөр хаясны л асуудал. 1 удаагийн 1 сайдаас асуухаас илүүтэйгээр ер нь энэ Монгол төрийн бодлого чинь ямар замаар яаж яваад ирчихсэн юм бэ гэдэг л асуудал. Боловсролд 1 доллар зарцуулж байж, нийгмийн өгөөж нь 12 нугарч, үр өгөөжөө өгдөг гээд олон улсын жишгээр батлагдчихсан зүйл. НҮБ-ын Form of small states" байгууллагын гаргасан судалгаагаар 10 саяас доош хүн амтай улсад хөгжихийн тулд хамгийн түрүүнд боловсролдоо хөрөнгө оруулалт хийх ёстой гэдэг зарчим байж байгаа. Тэгэхээр энэ индрийг, энэ микрофоныг ашиглаад Ерөнхий сайд аа, яг энэ эмч нар, багш нар, ахмадууддаа та маш тодорхой байр сууриа илэрхийлээч ээ.

Б.Пүрэвдорж: Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Эрдэнэболд гишүүний тодруулгын дагуу эрхэм хүндэт эмч, багш нар, ахмадууддаа бид байгаа бүх нөөц бололцоогоо дайчлаад, хулгайтай тэмцэж Бортээгийн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулснаар та бүхнийхээ шаардаж байгаа түвшинд цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэхийн төлөө ажиллаж байна. Үүний тулд Улсын Их Хурлаас Бортээгийн ордыг буюу Тавантолгойн ордод ашиглагдаагүй үлдсэн энэ ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг дэмжиж өгөхийг Улсын Их Хурлын эрхэм гишүүдээс хүсэж байна.

Ингэснээрээ бид олон улсын аудитыг оруулж, олон улсын стандарт нэвтрүүлж, Тавантолгой орд газруудад үр ашгийг эрс дээшлүүлэх замаар ирээдүйд олох орлогоор багш, эмч нарынхаа цалинг нэмэгдүүлж, ахмадуудынхаа тэтгэврийг нэмэгдүүлэх болно. Нүүрсний хулгайтай тууштай тэмцэж байж энэ алдагдаад байгаа олон тэрбумын боломжийг .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Гончигдоржийн Уянгахишиг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Г.Уянгахишиг: Ер нь бол өчнөөн олон жил хулгай, авлигатай тэмцье, хулгайчид байна, авлигачид байна гээд өчнөөн олон хүний нэр дурдагдаж, сошиалаар болон мэдээллийн хэрэгслээр, мөн улс төрийн тавцанд маш олон жил яригдлаа. Эндээс хэд нь хариуцлага хүлээсэн юм бэ. Хэд нь яг ял авсан юм бэ. Энэ өөрөө маш цөөхөн тоо гардаг. Тэгвэл бид нар энэ өвчлөлийн чинь эх үүсвэртэйгээ тэмцэж эхлэх ёстой юм биш үү гэдгийг асуумаар байна.

Тэгэхээр юу вэ гэхээр мэдээж Хууль зүйн сайдын хувьд гэмт хэрэгтэй тэмцэх, манлайллаар манлайлах энэ салбартаа гэдэг бол мэдээж 1 гол чиг үүрэг байгаа. Үүнээс гадна хамгийн гол чиг үүрэг бол эрх зүйн шинэтгэлийн бодлогыг хэрэгжүүлэх ийм чиг үүрэг байгаа. Энэ хүрээндээ Энхбаяр гишүүнээс маш тодорхой асуултыг асуумаар байна.

Өнөөдөр Эрдэнэс Тавантолгой, өнөөдөр энэ нүүрсний хулгай гээд байгаа асуудал маань ерөөсөө ганцхан компанийг л тойрч явж байгаа. Эрдэнэс Тавантолгой. Эрдэнэс Тавантолгой компанийн нүүрсээр хэрхэн оффтейк гэрээнүүд хийгдсэн бэ. Тэр нүүрсийг ямар үнээр явсан бэ. Тэр улсын төсөвт төвлөрөх ёстой байсан хөрөнгийг төсвийн гадуур хэрхэн зарцуулсан бэ гэдэг энэ асуудлаас бүх энэ нүүрсний хулгайн асуудал чинь уг улбаатай. Тэгвэл 15 жилийн өмнө Эрдэнэс Тавантолгой нээлттэй компани болчихсон байсан бол өнөөдөр асуудал арай өөр байх байсан болов уу гэж хувь хүний хувьд боддог. Тэгэхээр Ашигт малтмалын тухай хуулийн 5.6-д байдаг “стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээдийн хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг Монголын Хөрөнгийн биржээр арилжина” гэсэн энэ заалт амь оролгүйгээр өчнөөн олон жил, 10 гаруй жил, 20-иод жил болж байна. Тэгэхээр энэ тал дээр Хууль зүйн сайдын хүрээнд ямар манлайлал үзүүлж ажиллах вэ. Нөгөө талдаа Улсын Их Хурал дээр байгаа хамгийн том ажлын хэсэг буюу Нийтийн өмчийн тухай хуулийн төсөл болон Төрийн өмчит компанийн ил тод байдлын тухай хуулийн төслийн хамтарсан ажлын хэсэг байгаа. Энэ ажлын хэсгийг Энхбаяр гишүүн ахалж байгаа. Тэгэхээр энэ ажлын хэсгийн хүрээнд энэ төрийн өмчит компаниудыг хэрхэн задлах ёстой юм. Хэрхэн хувьчлах ёстой юм. Нөгөө талаасаа энэ төрийн хяналтыг хэрэгжүүлэх гээд байгаа юм бол мөнгө, санхүү, удирдлагад нь биш харин алтан хувьцааны хэлбэрээр оролцох боломжийг нь гаргах энэ тал дээр ямар бодол, саналтай байна вэ. Энэ тал дээр бас тодорхой хариулт авмаар байна.

Б.Пүрэвдорж: Нэр дэвшигч Баттөмөрийн Энхбаяр гишүүн хариулъя.

Б.Энхбаяр: Баярлалаа Уянгахишиг гишүүнд. Олон гишүүд бол намайг цагдаагийн сайд гэдэг нүдээр хараад, ганцхан хулгай асуугаад байсан. Уянгахишиг гишүүн маш зарчмын, хууль зүйн сайд гэдэг хувиар нь эрх зүйн шинэтгэлийн бодлогын асуудлаар асуулт асуусанд талархан хүлээж авч байна. 50/50 гэж ярьж болохгүй. Ер нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын гол үндсэн чиг үүрэг бол хууль зүйн бодлогын асуудал байгаа. Би өмнө нь 7 сарын хугацаанд ажиллахдаа энэ ажил

дээрээ ер нь бараг 90 хувьтай төвлөрч ажиллаж байсан. Хүмүүс Хууль зүйн сайдаар томилогдсоны маргааш Төрийн ордноос 1 хүнийг бариад аваад явчих байх гэж бодож байгаа байх. Намайг гавлаад. Энэ бол тодорхой гэмт хэрэг мөрдөн шалгах байгууллагын ажил байгаа. Би улс төрийн манлайллаа бол илэрхийлнэ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдаар томилогдсон тохиолдолд миний анхны Засгийн газраас санаачлах хууль бол Гэр бүлийн тухай хууль байх болно. Муу, муухай бүхэнтэй муу, муухай аргаар тэмцээд, үр дүнд хүрдэггүй. Чөтгөрийг дарах гэж байгаад бас чөтгөр болж болохгүй гэдэг би зарчим барьдаг. Өнгөрсөн парламентын үед мөн би Гэр бүлийн тухай хуулийг өргөн барьж байсан. Улсын Их Хурлын танхимд би хайрыг түгээх тухай ярьж байсан. Бид нар зөвхөн хуулийн нударгаар, хүчээр жанчуулж байж, шоронд хийлгэж байж энэ нийгэм сайн сайхан болно гэж би боддоггүй. Энийг үзэж байгаа ард иргэд, хэвлэл мэдээллийн байгууллагуудад ч гэсэн би уриалдаг. Муу муухай хэргүүдийг битгий сурталчилж түгээгээч ээ. Энд чинь нийгэм, хүмүүс тэр чигээрээ хохирогч болж байна.

Миний сонгогч 60 настай эмээ сонгуулийн үеэр надад хэлж байсан үгийг санаж байна. Бага насны хүүхдийн хэрэгтэй холбоотой уншаад, тэр эмээ 7 хоног унтаж чадаагүй. Бие нь муудсан байсан. Тэр чигээр нь нийгмийг, хүмүүсийг хохироож байна. Нийгэмд сайн сайхныг түгээх ёстой. Гэр бүлийн сайн сайхан орчноос сайн хүн гарч ирдэг. Миний аав, ээж 2 хэзээ ч бие биедээ хатуу хөтүү, муу үг хэлж үзээгүй. Би тийм гэр бүлд өссөн хүн. Би сайн сайхан зүйл үргэлж түгээгдээсэй гэж бодож явдаг.

Тийм учраас хамгийн түрүүнд би Гэр бүлийн тухай хуулийг санаачилна гэсэн бодолтой байгаа. Ирээдүй үедээ бид нар сайн сайхан жим татуулах ёстой. Бид сайн сайхан зүйлийг бас ярьдаг байх ёстой. Нүд нь улаанаараа эргэлдчихээд галзуу солиотой нь мэдэгдэхгүй төрийн танхимдаа эрүүл, эрүүл биш нь мэдэгдэхгүй төрийн түшээд орж ирсэнд би харамсаж байгаа. Би бушуухан эрүүл болоосой гэж хүсэж байгаа, ухаараасай гэж хүсэж байгаа. Тэгэхдээ өөрсдөө биш, цаг хугацаагаар энэ эмчлэгдэх байх гэдэгт би найдаж байгаа. Яагаад гэхээр удахгүй үнэн тодорно. Үүний цаана юу байсан юм, ямар хор байсан юм гэдэг юмнууд бүгд ил болно шүү дээ энэ чинь.

Б.Пүрэвдорж: Уянгахишиг гишүүн нэмж тодруулъя.

Г.Уянгахишиг: Би яг асуултдаа хариулт авч чадсангүй. Нүүрсний хулгайн уг угшил болоод байгаа төрийн өмчийн оролцоотой “Эрдэнэс Тавантолгой” хаалттай ХК-ийг нээлттэй ХК болгох, мөн энэ стратегийн ордуудын 10 хувь буюу компанийн 10 хувийг биржээр арилжаалах бүх энэ ил тод байлгах гэдэг энэ засаглалыг сайжруулах энэ тал дээр ямар бодлого авч хэрэгжүүлэх юм бэ гэдэг тал дээр тодруулга авмаар байгаа юм.

Бас Ерөнхий сайдаас бас саяын Хууль зүйн сайдын ярьсантай холбогдуулаад бас тодруулга асуулт байгаа нь өнөөдөр бид нар Хууль зүй, дотоод хэргийн яам гэж явж байгаа. Тэгвэл энийг бодлогын хувьд хууль зүйн бодлого талаасаа яг Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын анхаарч ажиллах ажил нь арай бага байгаад байх шиг санагдаад байгаа юм. Өөрөөр хэлбэл дотоод хэрэг рүүгээ илүү анхаараад байгаа учраас ялгах тийм бодлого байна уу.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар хариулна.

Г.Занданшатар: Ер нь өнөөдөр явуулж байгаа бүх тэмцлийн, үйл ажлын эцсийн гол зорилго бол Тавантолгой ХХК-г жинхэнэ утгаар нь нээлттэй компани болгож, ирэх оны цагаан сараас өмнө ард түмний нээлттэй эзэмшлийн компани болгохыг би зорьж байна. Өнөөдөр тэнд бугшсан авлига, хулгайг цэгцэлж байж олон улсын аудит оруулна гээд би биччихсэн байгаа биз дээ тэр тогтоол дээр. Яагаад би тэрийг хүсээд байгаа юм бэ гэхээр олон улсын аудит оруулж байж энэ нээлттэй IPO гаргах тийм боломж нь бүрдэнэ. Олон улсын аудит оруулж олон улсын стандартын дагуу ард түмэндээ би эзэмшүүлэхийг зорьж байгаа юм. Ингэж ард түмний хяналтад оруулах юм бол ард түмэн үр өгөөжийг нь шууд хүртдэг. Зүгээр E-Mongolia-гийн данс дээр хоосон үнийн дүн байж байдаг биш бодитой үр шимийг нь ард түмэн хүртдэг, баялагтаа эзэн Монгол болох энэ Үндэсний баялгийн сангийн хуулийг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх хамгийн том алхам бол Тавантолгойн орд газрыг.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж тодруулъя.

Г.Занданшатар: Тийм ард иргэдээ эзэмшүүлэх асуудал бол энэ Тавантолгой дээр тогтоож байгаа онцгой дэглэм, үйл ажиллагааны үндсэн чиглэл, зорилго. Ийм ч учраас Засгийн газрын 7 дугаар сарын 3-ны 02 дугаар албан даалгавраар тухайн үеийн Хууль зүй, дотоод хэргийн сайдад хууль бусаар олгосон эзэмшсэн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордтой холбоотой асуудлыг судалж, хууль зөрчсөн үйлдлийг таслан зогсоож арга хэмжээг шуурхай зохион байгуулж санал, дүгнэлтээ 8 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулах, “Эрдэнэс Тавантолгой” компанийг нээлттэй ХК болгох ажлыг зохион байгуулах үүргүүдийг холбогдох сайд нарт албан даалгавар өгөөд ажиллаж байгаа.

Харамсалтай нь энэ явцад маш олон хулгай луйврын асуудлууд илэрч байгаа учраас энийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн. Энэ асуудал нь өнөөдөр хөвөрсөөр байгаад ийм үр дүнд хүрэхийг би харин тооцоолоогүй юм билээ. Утасны үзүүр ийм байсан. Засгийн газар огцрох дээрээ тулсан шалтгаан энэ. Ийм учраас энэ асуудлаас бид зогсохгүй урагшилна. Ер нь Дотоод хэргийн яам, Хууль зүйн яам хоёр бол тусдаа байдаг. .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

С.Одонтуяа: Ерөнхий сайд, Энхбаяр сайдаас асууя. Ер нь бараг намайг ярих гэж байгаа юмыг гадарлаж байгаа байх. Өмнөх парламентад бас Энхбаяр сайдыг нэлээн энэ асуудлаар бас зовоож байсан. Энэ бол хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ болон хууль бус эргэлттэй холбоотой асуудал байгаа. Өнөөдөр Монгол Улс дамжин өнгөрүүлэх жороос хэрэглэх жорын тоонд орсон. Гэмт хэргийн тоо 25-30 хувь жил бүр өсөж байна. Гэмт хэрэгт холбогдогчдын 66 хувь нь 18-30 насны залуучууд байгаа. Тэгэхээр Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам энэ асуудалтай хэрхэн тэмцэх вэ, хэрхэн урьдчилан сэргийлэх вэ, хуулиа хэзээ өргөн барих вэ гэдгийг асуумаар байна. Ялангуяа энд манайд дандаа гэмт хэрэг гарсан хойно ингээд л тэмцээд л мөнгө зараад л байгаа.

Тэгэхээр энэ урьдчилан сэргийлэх, олон нийтийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, сэргээн засах асуудал дээр хуулийн төсөлд чинь орж байгаа юм байгаа болов уу. Ялангуяа энэ асуудалд холбогдож байгаа албан тушаалтнууд, худалдан борлуулж байгаа албан тушаалтны ялын бодлогыг чангатгаж чадаж байгаа юу. Өмнө нь Алтангэрэл сайдтай байх бас богино хугацаанд энэ талаар бид бас нэлээн

сайн ажиллаж байсан. Ер нь Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар боломжоороо бас ажиллаад байгаа. Гэхдээ гэмт хэрэг гарсан хойно нь ажиллаад байгаа юм. Тэгэхээр бид энэ урьдчилан сэргийлэхгүй юм уу, энэ донтолтын донтсон хүмүүсээ сэргээн засах асуудалд нь анхаарахгүй юм уу. Ингээд дандаа шоронжуулсан бодлого яваад байж болохгүй байна. Мөнхбаатар сайд надад бол юу гэж амласан бэ гэхээр СЭМҮТ-ийн хашаанд сэргээн засах энэ донтсон хүмүүсээ Сэргээн засах төвийн барилгын зураг, төсвийн төсөв энэ төсөвт орсон байгаа гэж хэлсэн. Тэгэхээр энэ нөгөө нэрээрээ ордоггүй учраас та сайд болчихоод энэ төсвийг хасчихгүй биз дээ. Энийг сонсмоор байна.

Хоёрдугаарт энэ хөтөлбөрт ердөө 67-хон сая төгрөг туссан байгаа. Энэ бол ямар ч хангалтгүй мөнгө. Тийм учраас энийг нэмэгдүүлэх саналаа ажлын хэсэгт өгсөн байгаа. Одоо боловсон хүчин байхгүй байна. Сэтгэл зүйчид хангалтгүй байна. Санамсаргүй 1 удаа хэрэглэхсэн хүмүүс хэнд, хаана хандаж туслалцаа авахаа мэдэхгүй байна. Тэгэхээр бусад оронд бол цуглаад энэ асуудлаа яаж салах вэ, яаж гарах вэ гэдэг ярилцдаг ийм ийм төвүүд байдаг. Тэгэхээр ийм уулзах газрууд байхгүй байна гэж надад их олон удаа хандаж байсан. Би энэ БГД-ийн Засаг даргаар ажиллаж байхад энэ архинаас гарах гэсэн хүмүүсийн “АА” гээд нэг бүлгэм байгуулаад байр сууц гээд ярихад орон нутаг бол энийг нь хангаж өгөөд, дэмжээд их үр дүнтэй болж байсан. Тэгэхээр энэ орон нутагтаа хэрхэн ажиллах гэж байна. Засгийн газар энэ уян хатан хурдтай ажиллахгүй бол хилээр орж ирж байгаа бүтээгдэхүүнүүдийн нэрсийг өөрчлөх гэж үгүй ээ мөн хэдэн сар, жил болох юм. Энэ бүтээгдэхүүнүүд чинь маш хурдан өөрчлөгдөөд байдаг. Тэгээд энэ.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минут тодруулъя.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ жишээлэхэд Өмнөд Солонгос бол энэ хилээр хориглосон бүтээгдэхүүний жагсаалт нь маш хурдан өөрчлөгдөж байдаг. Тэгэхээр бид нар болохгүй бол энэ орнуудын жагсаалтыг ч гэсэн аваад энэ хурдтай байхгүй бол энэ хилээр янз бүрийн бүтээгдэхүүнүүд бол их орж ирж байна. Тэгээд энэ залуус ингээд хар тамхинд донтох юм бол ерөөсөө бүх хүсэл мөрөөдөл нь тэр дороо дуусаж байгаа, айл гэрүүд ядуурч байна, нийгэмд асар их хохиролтой байгаа. Тийм учраас та гишүүдтэйгээ маш сайн ажиллах хэрэгтэй, эцэг, эхчүүдтэй бид ажиллах хэрэгтэй, орон нутагтай хамтарч ажиллах хэрэгтэй байна. Тэгэхээр энэ асуултууддаа хариулт авъя.

Б.Пүрэвдорж: Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар хариулна.

Г.Занданшатар: Манай Салдангийн Одонтуяа гишүүн хамгийн тулгамдаж байгаа асуудлыг хөндлөө. Баярлалаа.

Монгол Улсын Засгийн газар энд онцгой анхаарал хандуулж, 2025 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар 26 дугаар тогтоол гаргаж хар тамхитай тэмцэх ялын бодлогыг нь чангатгах, урьдчилан сэргийлэх, мөн эрх зүйн орчныг боловсронгуй болгох ийм тодорхой үүрэг, даалгаврыг тухайн үеийн Хууль зүй, дотоод хэргийн сайдад өгсөн. Үүгээр Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж энэ 8 дугаар сард оруулж ирэх ёстой байсан. Тийм учраас бас энэ 9 сард өнгөрчхөөд хуулийн төслийн эхний хэлэлцүүлэг бол явж байгаа.

Яг таны хэлсэнчлэн урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээ хэрэгжүүлэхийг бас энэ хүрээнд өгөгдсөн байгаа юм. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд анзаарагдах арга хэмжээ зохион байгуулж 146 контент хийж, давхардсан тоогоор 10 сая хүнд хүргэж 145 мянган лайк дэмжигдэж ийм бодитой ажлууд явж байгаа. Үүн дотроо “Устгал 2025” гэсэн арга хэмжээ явж хар тамхины чиглэл төрлийн ургамал ургадаг талбайнуудыг устгах, шатаах ийм арга хэмжээ зохион байгуулсан. “Тархцын хяналт 2025” арга хэмжээг зохион байгуулж 36 холбогдогчтой 15 гэмт хэргийг илрүүлж шалгаж байна. Тагнуулын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газартай хамтран явуулж байгаа “Суваг-2” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажиллагааны тусгай арга хэмжээнүүдийг зохион байгуулж, 11 удаагийн хяналт шалгалтын ажлаар 15 холбогчтой нөгөө тээвэрлэлтийн саяын хэлж байгаа олон улсын нисэх онгоцны буудлаар оруулж байгаа 9 гэмт хэргийг илрүүлэн шалгаж байна. Ингэж илэрц гэдэг арга хэмжээ, ер нь энэ арга хэмжээний хүрээнд энэ далд худалдааны энэ бүлэглэлийг илрүүлж шалгаж байна.

Одоо улсын хэмжээнд энэ 9 дүгээр сарын 20-ны байдлаар энэ хар тамхитай холбоотой 185 гэмт хэргийг бүртгэж, 141 хүнийг яллагдагчаар татаж, шалгаж байна. Энэ бол өмнөх оныхоос нэлээн өссөн тоо. Одоо бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бол 160 буюу 86.5 хувь нь Улаанбаатар хотод, 25 буюу 13.5 хувь нь хөдөө орон нутагт бүртгэгдсэн байгаа. Ер нь гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн бараг 80 хувь нь эрэгтэй, 20 хувь нь эмэгтэйчүүд байгаа. Анхаарал татаж байгаа. Ер нь бол яг таны хэлсэнчлэн хар тамхинд донтогчдыг шийтгэхээсээ илүү нөгөө эмчилгээний төв, дэм төв байгуулах тийм шийдвэрийг Засгийн газрын хурлаас гаргасан эмчилдэг.

Харин ийм учраас ялын бодлогыг өөрчлөх, оновчтой болгох асуудал бол энэ хуульд явж байгаа. Харин жинхэнэ тэр худалдаачид, бүлэглэлийг илрүүлэх ажил дээр илүү ач холбогдол өгч байна. Ийм учраас Хар тамхитай тэмцэх албыг тусад нь бие даалгаж гаргасан. Ингэснээрээ харьцангуй бие даасан үйл ажиллагаа явуулж, хар тамхитай тэмцэх үйл ажиллагааг шинэ шатанд гаргах ажлууд хэрэгжиж байгаа. Ер нь энэ улсын хэмжээнд энэ хар тамхи бол аюулын харанга дэлдэх хэмжээнд хүрсэн байсанд онцгой ач холбогдол өгч, зохион байгуулалтын тусгай ажиллагаанууд бол тогтмол сааралтгүй явж нийтдээ 19 баар цэнгээний газруудад сэжигтэй, эгзэгтэй ийм 19 цэнгээний газарт байнгын тогтмол хяналт тавьж, үндсэндээ бараг 22 мянган хүнд үзлэг хийж, 2327 иргэнийг хамруулан шалгаж энэ төрлийн бодисыг худалдан борлуулдаг сэжигтэй этгээдүүд бүлэглэлд цохилт өгөх ажлыг үе шаттай зохион байгуулснаар 284 хүнд холбогдох 145 гэмт хэрэг, мансуурсан 71 зөрчлийг илрүүлж шалгалтын ажиллагаа явуулж байгаа юм. Тийм учраас нөгөө хар тамхитай зарласан дайн, тэмцэл эрчимтэй үргэлжилж байна.

Цаашдаа энэ намрын чуулганаар бид өргөн барих байсан боловч Хууль зүй, дотоод хэргийн сайд маань томилогдохгүй байгаагаас шалтгаалаад бас энэ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай хууль буюу хар тамхитай тэмцэх тухай хууль маань гагцхиаад байгаа учраас л бид бас яаруулаад хурдан танилцаад өгөөч ээ гэж гуйгаад байгаа маань бас энэтэй бас холбоотой. Тэгэхгүй бол энэ гэмт хэрэг маань өнөөдөр.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Баттөмөрийн Энхбаяр гишүүн хариулья.

Б.Энхбаяр: Хар тамхитай тэмцэх хөтөлбөрт 67 сая төгрөг энийг нэмэгдүүлэх санаачилга гаргасан. Ер нь Нямбаатар сайдын үеэс эхлээд Алтангэрэл сайд, Мөнхбаатар сайд нар дамнаад ер нь хар тамхи хэрэглэсэн хүмүүсийг гэмт хэрэгтэн

биш өвчтөн гэж үзэж, үүнийг эмчилдэг байя, энэ хүмүүс чинь өөрсдөө бас гэмшээд гарах гээд яваад байдаг хаана очихоо мэддэггүй. Тэгээд очихоор бариад хорьчих вий гэдэг ийм айдастай. Тэгээд энэ нуугдмал хэлбэр рүү оруулаад байгаа шалтгаан бол энэ байгаа. Тийм учраас хар тамхитай тэмцэх дээр хатуу, зөөлнийг хослон хэрэгжүүлнэ. Зохион байгуулж, худалдан борлуулж, ашиг олж байгаа бүлгүүдэд оногдуулах ялын бодлогыг чангатгана.

Харин анх удаа болон бусдын нөлөөнд орж хэрэглэсэн этгээдийг бол гэмт хэрэгтэн гэж үзэхээс татгалзана. Энийг өвчтөн гэж үзэж харин цааш нь гүнзгийрүүлэхгүй байх дээр нь анх.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Манай Одонтуяа дарга өнгөрсөн 4 жил Их Хурлын дэд дарга хийж хуралдаан удирдахдаа бол үнэхээр маш сайн байсан. Би танаас бас үлгэр дуурайлал авч байгаа шүү. Бас хэлж зөвлөөрэй гэж хүсмээр байна. Одоо Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Ганбат: Ямар ч байсан ингээд Хууль зүй, дотоод хэргийн сайдтай болох юм шиг байна. Өчигдөр Хууль зүйн байнгын хороо дээр би лавласан л даа. Шадар сайд Учрал үгүй ээ, бид нар 23 хоночхож байгаа шүү дээ гэж байна лээ. Тэгээд өнөөдөр 24 дэх хоног нь юм байна л даа. Би бүр гайхаад байгаа юм. Тэгээд 24 хоног Хууль зүй, дотоод хэргийн сайдын статус нь тодорхойгүй ийм явж ирлээ. Энэний цаана юу нуугдаж байв аа, ямар юм байв аа Ерөнхий сайдаас, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас нэгэнт танилцуулагдчихаж байгаа юм чинь ингээд сайд л даа. Ямар учир шалтгаан байна гэж та нар бодож байна. Тэрийг би нэг асууя.

Тэгээд үнэхээр мэргэжлийн байх ёстой Үндсэн хуулийн цэц маань Үндсэн хуулийнхаа дагуу ажиллалаа. Монгол Улсын Ерөнхийлөгч бас энэ хүнд хэцүү цагт ард түмнээс сонгогдсон ийм Ерөнхийлөгч дээд танхимынхаа үүргийг гүйцэтгэж чадлаа. Энэ улс орон бол ёстой маш хүнд байдлын ирмэг дээр байлаа шүү дээ. Тэгээд тэр Байнгын хороон дээр ганцхан би л нэхээд байгаа юм л даа Хууль зүй, дотоод хэргийн сайдыг. Үгүй ээ, танай намынхан яагаад нэхдэггүй юм бэ. Сайн сайн улсууд, залуучууд зөндөө байна. Би харж л байна. Сая энэ хүнд хэцүү үед Ардчилсан нам үнэхээр нам шиг байж байж, манай энэ Пүрэвдорж гишүүн, би, манай намын дарга Одонгийн Цогтгэрэл, Амгаланбаатар гишүүд гээд ийм гишүүдтэй байсны хүчинд энийг даван туулж гарч, гарлаа шүү бид нар. Одоо та нарын өмнө бас ийм байна аа харж байна. Нөгөө юу билээ намтайгаа тэмцвэл улсгүй болчих гээд байдаг. Авлигатай тэмцвэл намгүй болчих гээд байдаг. Тэмцэхгүй бол улс оронгүй болчих гээд байдаг ийм л байдалд та 2 оччихоод байна.

Тийм учраас танай тэр намын хурал чинь иймэрхүү болоод байх шиг байна. Би тэгж харж байгаа. Тэрийг бүгдээрээ ч мэдэж байна л даа. Тэгээд энэ хоёр нам хоёулаа л аятайхан явчхаасай гэж бодоод байгаа юм би. Тэгж байж энэ улс орон өнгөтэй өөдтэй байна л даа. Энэ дээр та бүхэн ямар бодолтой байгаа вэ. Цаашдаа яах вэ.

Засгийн газрыг байгуулахад би хэлж байсан дэмжиж байна аа. 68-тай олонх засгаа байгуулаад ажиллах ёстой дангаараа. Та бүхэн тэгээд Ерөнхий сайдын эрх мэдэл дотор 2, 3 нам оруулаад л ингээд л хийсэн байна лээ. Тэгээд энэ чинь танхимынхаа зарчмаар нөгөө гэрээ хэлэлцээ байдаг юм бол тэрнийхээ дагуу ажиллаж чадаж байгаа юу, ямар байгаа вэ. Тэгээд жоохон хэврэг болоод.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Баттөмөрийн Энхбаяр гишүүн хариулъя.

Б.Энхбаяр: Ганбат гишүүнд баярлалаа. Ганбат гишүүн бол авлигачидтай, нүүрстэй хийх дайнд мөр зэрэгцэн хамт явах ийм нөхөр юм байна аа гэж. Би зүгээр хараад биш 2 сонсгол дээр бас хамтарч ажилласан хүний хувьд ийм итгэл үнэмшилтэй болсон. Энэ асуудлууд бол ер нь зүгээр нэг авлигын хэрэг ч биш. Ер нь сая болж өнгөрсөн асуудлууд бол эрх барьж байгаа намын даргаар дамжуулж гүйцэтгэх засаглалын оройд сууж, улмаар хууль хяналтын байгууллагуудын удирдлагыг томилох, чөлөөлөх эрхийн төлөөх тулаан болсон шүү.

Яагаад гэхээр энэ бол зүгээр нэг кнопын асуудлууд байгаагүй. Энд оролцож байгаа олон хүмүүс энэ өдрүүдэд нүүрсний жинхэнэ хулгайчтай бизнесийн ч, өөр олон талаараа ашиг сонирхол, зөрчил юутай нэгтэй гэдэг зүйл нь улам тодроод байгаа. Тэгэхээр энэ танхимаас бид нар нам үл харгалзаж энэ манлайллыг үзүүлж байх шаардлагатай. Тухайлбал энэ асуудлын дараа бид нар Сайнхүүгийн Ганбаатар гишүүний санал болгосон Улсын Их Хурлын гишүүнийг 4 жилийн хугацаанд хуулийн байгууллага шалгаж болохгүй гэдэг асуудлыг хэлэлцэх гэж байна. Энийг хэн зохион байгуулаад яваад байгаа юм. Ганбаатар гишүүн та ер нь дандаа хүний өмнүүр, урдуур гарч ирдгээ боливол яасан юм бэ. Админералтай Амарбаясгалан холбоогүй гэж итгэл төгс хэлсэн хүн чинь та шүү дээ. Одоо ямар учраас өнөөдөр Улсын Их Хурлын чуулган дээр амжиж Улсын Их Хурлын гишүүнийг шалгаж болохгүй гэдэг ийм асуудал барьж орж ирээд байгаа юм, юунаас айгаад байгаа юм, хэний захиалгаар яваад байгаа юм. Тийм учраас хууль шүүхийн өмнө эрх тэгш шүү. Улсын Их Хурал бол хулгайч нарын орогнодог газар биш. Ялангуяа энэ нүүрсний хулгайтай холбоотой асуудлууд хууль хяналтын байгууллага дээр үнэн мөн нь тогтоогдож, бүрэн эрхийн асуудал хөндөгдөхийн өмнө амжих гэсэн юм шиг ийм захиалгын арга хэмжээгээ нэн даруй таслан зогсоохыг би танаас шаардаж байна. Дараагийн асуудал дээр энэ асуудлыг хэлэлцэхэд би энэ Ганбаатар гишүүний саналыг би дэмжихгүй байхыг Их Хурлын гишүүдэд нам үл харгалзан бас уриалж байна.

Б.Пүрэвдорж: Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Хууль зүйн сайдын хэлж байгаа, ярьж байгааг сонслоо. Ямар ч байсан гэмт хэрэгтэй тэмцэх нөхцөл байдал арай өндөр түвшинд очих нь ээ гэж ойлголоо. Их Хурлын гишүүд бид ч гэсэн ер нь бол юун төлөө 126 гишүүнтэй болсон билээ. Тэгээд тойрог болгоноос 7, 8 гишүүд байгаа. Бид нар бас ёс суртахуунтай баймаар байгаа юм. Заавал тэр прокуророос тэр бичиг нь ирж байж бид нар яадаг биш. Тэгэхгүй бол 20, 30 хүн яллагдагчаар татагдчихдаг. Тэгсэн мөртөө өөрсдөө очоод шалгуулдаггүй тэгээд барьцаанд байгаа нь Улсын Их Хурал тэр чигтээ барьцаанд байгаа.

Нөгөө талаар тэр нүүрсний өшөө бас бус юманд холбогдсон хүмүүс бол ганцхан бид нар л эндээ мэдэхгүй байгаагаас биш манай 2 хөрш бол бүгдийг нь л мэдэж байна шүү дээ. Энэ бид нар энэ Их Хурлыг.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Энхбатын Болормаа гишүүн алга байна. Амгаланбаатарын Ганбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

А.Ганбаатар: Тэгээд хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоотой санал хэлье гээд. Өнөөдөр Хууль зүй, дотоод хэргийн сайдаар томилогдохоор нэр

дэвшээд орж ирж байгаа Баттөмөрийн Энхбаяр гишүүнийг бол ерөнхийд нь энэ хууль зүйн салбар, нийт ард түмэн бол бас шударга хүн юм байна гэж ерөнхийд нь төсөөлөөд байгаа юм. Би хувьдаа сонгуульд нэр дэвшиж байх үеийнх нь урианаас танина. Хүнээр нь биш би уриатай нь анх танил болж байсан. Өөрөөр хэлбэл хуулийн хулгайтай тэмцэнэ гэж та сонгуульд уриа авч, барьж орж ирж байсан. Тэгэхээр маш товч, тодорхой оновчтой уриа гэж олон нийтийн чиглэлээр ажилладаг хүний хувьд бол ойшоож харж байсан. Гэхдээ энэ уриагаа хэрэгжүүлэх нь хэр бодитой юм бол доо гэж бодож байсан юм.

Ялангуяа Ардын нам засаглаж байх энэ үе цаг үед. Харин танд энэ уриагаа хэрэгжүүлэх түүхэн боломж гарч ирж байна. Түүхэн боломж шүү. Өөрөөр хэлбэл та бол энэ томилгоо таныг эсвэл ардын баатар болгоно, эсвэл ардын мянгуужин болгоно. Яагаад гэвэл та хэлсэндээ хүрээд, шударга ёсыг тогтоодоггүй юм аа гэхэд тодорхой асуудлыг шийдээд, энэ хүмүүс танаас зарим тодорхой асуудлыг шийд гээд байгаа нь таны дор Засгийн газрын мэдэлд Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн газар, тодорхой эрх мэдлийн хүчний байгууллагууд байгаа учраас ингэж итгэж хараад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ асуудлаа эцэслэх юм бол таны нэр ард түмний дунд бол баатар болж үлдэнэ ээ. Хууль зүйн сайдын энэ томилгоо бол энэ Засгийн газрын амин сүнс шүү. Энэ Засгийн газар тогтох уу, үгүй юү гэдэг бараг таны энэ томилгооноос хамаарна. Үнэхээр Ерөнхий сайд хэлээд байгаа тэр Бортээгийн уул уурхай эдийн засгийн бөглөө болоод байгаа бол эргэлтэд оруулъя гээд байна шүү дээ. Тэгэхээр өнөөдрийн манай эдийн засаг чинь 30 их наядад эргээд байгаа юм бол шинэ гарц, орлогын гарц нээх гээд байгаа юм биш үү. Тэгэхээр энэ бол таны томилгоотой шууд хамааралтай юм шиг харагдаад байгаа юм.

Түрүүн та бол нэлээн ноцтой юмнууд хэлсэн. Үндэсний аюулгүй байдлын 3 гишүүний 1 нь гадаадын байгууллагын гадаад улсын хараанд байна аа, ийм хүмүүс Монгол Улсыг толгойлох эрхгүй ээ гээд. Энэ бол маш ноцтой асуудал шүү дээ. Түрүүн бид нар Үндсэн хуулийн хямралд оронгоо алдлаа, Үндсэн хуулийн эмтлэнгээ алдлаа. Одоо үндэсний аюулгүй байдлаа алдах хэмжээнд ийм сонор сэрэмжтэй байхгүй бол болохгүй ийм мэдэгдлийг та хийлээ. Тэгэхээр энэнийхээ хэлсэн үгэндээ эзэн байх энэ асуудал үлдэж байна. Мэдээж Засгийн газар таныг хамгаална. Энэ дотор байж байгаа гишүүд, үнэнийг олъё гэсэн гишүүд бол таны талд бас дэмжиж ажиллах байх.

Б.Пүрэвдорж: Нэгмөсөн 1 минут нэмж тодруулъя.

А.Ганбаатар: Зоригтой ажиллахыг хүсэж байна. Үүний төлөө нам харгалзахгүй гишүүд таныг дэмжих байх гэж бодож байна. Хууль зүйн сайдын хувьд бол нэн яаралтай горимоор Их Хуралд оруулж ирж батлуулах хууль байна уу. Тухайлбал та Хууль зүйн сайд хийж байхдаа Хүний эрхийн тухай багц хуулийг санал болгоод батлуулж чадаагүй гэж ойлгосон. Тэгэхээр ер нь цагдаагийн байгууллагатай холбоотой, энэ хүчний байгууллагатай холбоотой хүний эрхийн асуудал их зөрчигддөг. Тэгэхээр Их Хурлаар нэн даруй оруулж ирж энэ хүний эрхийг хамгаалсан энэ хуулиудыг батлуулах, Хүний эрхийн тухай багц хуулиас өөр ямар хууль байна вэ. Баярлалаа. Амжилт хүсье.

Б.Пүрэвдорж: Нэр дэвшигч Баттөмөрийн Энхбаяр асуултад хариулна.

Б.Энхбаяр: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Нэн яаралтай горимоор оруулж ирэхээр шаардлагатай 1 хууль байгаа. Тэр нь 2023 оны 11 сард миний бие

Хууль зүй, дотоод хэргийн сайд байхдаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлж Шүүх байгуулах тухай хуулийг өргөн барьж батлуулсан байдаг. Энэ дотор Монгол улсад анх удаа Гэр бүлийн шүүх гэдгийг байгуулсан.

Ингээд Гэр бүлийн шүүхийг 2026 оны 1 дүгээр сарын 1-ээс үйлчлүүлэхээр дагаж мөрдөх журмын хуульд нь бичсэн байгаа. Одоо Монгол Улсад Гэр бүлийн шүүх байгуулагдахад ердөө 2 сарын л хугацаа байна. Шүүгчид нь томилогдоогүй байгаа, байр савны асуудал байгаа. Мөн Гэр бүлийн шүүхийн хэрэг, маргаан хянан шийдвэрлэхтэй холбоотой процессыг журамласан хуулийн төсөл Улсын Их Хуралд өргөн баригдаагүй байгаа. 2 сарын дараа ажиллах тэр шүүхийн хэрэглэх хуулийг нь Улсын Их Хурал бариагүй байж байна.

Тэгэхээр хамгийн хоолойн дээр тулчихсан асуудал бол би энэ асуудал байгаа гэж үзэж байгаа. Тийм учраас нэн яаралтай горимоор энэ асуудлыг Улсын Их Хуралд бас шийдэж, Монгол Улсад гэр бүлийн, хүүхдийн асуудлыг шийддэг дагнасан шүүхтэй болохоор, болохын төлөө ингэж байгаа. Яагаад гэхээр хүүхэдтэй харьцана гэдэг бол хүүхдийг мэдэрдэг, ойлгодог, гэр бүлийн харилцаа гэдгийг ойлгодог, үүгээр мэргэшсэн ийм хүмүүс байх шаардлагатай. Өөрөө нүд нь улаанаараа эргэлдчихсэн галзуу солиотой хүн гэр бүлийн хэрэг, маргаан шийдэж болохгүй ээ. Тодорхой зөвхөн эрүүгийн хэрэг, хүнд хэргүүдийг шийддэг байсан хүн тэр хүүхдийн сэтгэл зүйг ойлгож шийдэхэд төвөгтэй. Тэр байтугай хүүхдийн сэтгэл зүй гэдэг бол нас наснаасаа хамаараад өөр өөр байдаг. Бага насны хүүхэд, дунд насны хүүхэд, шилжилтийн насны хүүхдүүд, бүр 2 насны зөрүүтэй хүүхдүүдийн сэтгэл зүй өөр байгаа.

Тийм учраас энэ гэр бүлийн шүүгчдийг сургах, бүр байр савнаасаа эхлээд хүнд бүр таатай хүүхэд, тэр чинь хүүхдүүд орох байхгүй юу. Тэр хүүхдүүд ороход тийм халуун дулаан ийм байр савтай ийм сайхан шүүхтэй болох мөрөөдлөө би биелүүлнэ ээ гэж үзэж байгаа.

Б.Пүрэвдорж: Равжихын Эрдэнэбүрэн гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Р.Эрдэнэбүрэн: Нэр дэвшигчээс, танилцуулагдаж байгаа нэр дэвшигчээс ганцхан асуулт асуух гэсэн юм. Эхний ээлжид. Хэд хоног энэ Үндсэн хуулиа ер нь мартсан байж байгаад дандаа нүүрс ярьсаар байж байгаад Цэц гэдэг байгууллага ер нь байдаг ч юм уу, үгүй ч юм уу шахуу болж байгаад эргээд Үндсэн хуулиа харцгааж байна. Цэц ер нь ямар байгууллага юм гэж харцгааж байх шиг байна. Тэгээд энэ үеэр нэг л зүйлийг ажиглалаа. Ялангуяа Хууль зүйн сайд энэ хууль зүйн салбарын бодлого, тэр дотроо энэ хууль зүйн салбарын боловсон хүчний асуудлыг хариуцаж явах ёстой. Энэ манай энэ хуульчдын энэ мэргэжлийн чадвар энэ тэр чинь ер нь ямар байдалд орчихсон юм бэ. Энэ Үндсэн хуулийн цэцийн Их суудлаар хэлэлцсэн асуудал эцсийнх байдаг гэдэг чинь шинэ зүйл биш шүү дээ. Дахиад хэлэлцсэнээ, яринаа л гэгцгээх юм. Харахаар л нэг хуульч. Нөгөө хэдэн овоо хууль бичдэг, ярьдаг хүмүүсээ үе нь өнгөрсөн гээд хөөгөөд явуулчихсан. Тэгээд хаана байдаг нь мэдэгдэхгүй, ямар хичээл ордог нь мэдэгдэхгүй нэг ийм сургууль, хуулийн сургууль төгссөн нөхөд ингээд орж ирээд бүр самарч байна шүү дээ. Хууль зүйн сайдад нэр дэвшигч ээ тэгээд та энийг цэгцлэх үү, энэ шалгуурыг нь өөрчлөх үү. Энэ дээр үед хуулийн сургуульд Үндсэн хуулийн эрх зүй гэдэг хичээл ордог байсан. Одоо больчихсон юм уу. Аливаа маргаантай асуудал гарахлаар ялангуяа Үндсэн хууль, тэр хуульд өөрчлөлт оруулсан тэр хуулийг хэлж байх үед хууль баталсан хүмүүс ямар сэтгэл, юу бодож энэ өөрчлөлтийг хийсэн бэ, тэр хуулийг баталсан бэ гэдгийг

нь тухайн үед хэлж байх үеийн тэмдэглэлүүдийг харж үздэг. Хэд хоног энэ 2019 оны Үндсэн хуульд өөрчлөлт оруулах үеийн хуралдааны тэмдэглэлийг уншиж үзлээ. Ямар ч асуудалгүй энэ өнөөдрийн энэ болох энэ хуулийн залилан яваад байгаа учраас энийг хаасан ийм л өөрчлөлт хийсэн байна лээ шүү дээ.

Тэгээд би энэ нэр дэвшигчээс асуух гэсэн юм. Ялангуяа энэ хуулийн сургуулиудыг аттестатчилах, энэ боловсон хүчнийхээ мэдлэг чадварыг сайжруулах чиглэлээр шалгах шаардлагыг нь өндөрсгөх ийм ямар зүйл бодож байна. Одоо энэ гүйцэтгэх байгууллагууд дээр ч гэсэн энэ хувийн хуулийн сургууль төгссөн хүмүүс ангиараа .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минут өгье.

Р.Эрдэнэбүрэн: Хонгил үүсгээд байдаг, нийлээд хоорондоо хэрэг янз бүрийн юм яриад байдаг ийм юу их сонсогдоод байгаа. Тэгээд энэ чиглэлээр арга хэмжээ авах хэрэгтэй байна. Энэ талаар ямар бодолтой байна гэж асуумаар байна, нэгдүгээрт.

Хоёрт нь Ерөнхий сайдаас асууя даа. Энэ болж өнгөрч байгаа юм бол нэг намын даргын асуудал биш, нэг намын асуудал биш ээ гэж гэдэгтэй бол санал нэгдэж байх шиг байна. Энэ бол цэвэр ялангуяа уул уурхайн бизнест төр оролцож байгаагаас болж байна. Тэгээд энэ төр давж хулгай хийхийн тулд стратегийн орд гэдэг нэр өгчөөд ингээд авдаг болсон. Ерөнхий сайд сая хэлж байна. Нээлттэй болгоёоо гээд. Эхний алхмууд хийх гэж байгаа Цагаан сарын наана Тавантолгойг нээлттэй болгоноо гэж байна. Цааш.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Эхлээд Баттөмөрийн Энхбаяр гишүүн хариулъя.

Б.Энхбаяр: Эрдэнэбүрэн гишүүн их чухал асуудал хөндөж байгаа юм. Хууль зүйн салбарын боловсон хүчин түүний сургалтын тогтолцоог боловсронгуй болгохгүйгээр бид мянга сайхан хууль гаргая гээд ч чадахгүй. Түүнийг хэрэгжүүлэх нь хүн л байгаад байгаа юм. Энэ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл Нямбаатар сайдын үед өргөн баригдаад миний бие Улсын Их Хурал дээр ажлын хэсгийг нь ахалж байсан юм. Энэ яагаад өнгөрсөн парламентын үед батлагдаагүй вэ гэхээр яг таны ярьсан энэ асуудал тэр хуульд ерөөсөө орхигдчихсон байгаад байсан.

Өөрөөр хэлбэл, тэр хуульч, эрх зүйчийг бэлтгэдэг тогтолцоо, сургалтын агуулга, хөтөлбөр тэр асуудлыг энэ хуулиар тодорхой болгохгүй зөвхөн нэг Хуульчдын холбооны хэн нь дарга цэрэг байх тухай хууль ороод ирсэн байхгүй юу. Тэгэхээр энэ Хуульчдын холбоо гээд байгууллагын асуудлыг бид ярих гээгүй. Бид ерөөсөө энэ эрх зүйчдээ яаж бэлдэх вэ гэдэг асуудлыг ярихгүй бол манай Баярбаатар шиг ийм нөхөд улс орныг хааш нь ч чиглүүлж магадгүй болчихоод байна шүү дээ. Одоо бол манай Баярбаатарын нүүрсчдийн хяналтын хороо л Үндсэн хуулийн цэцийг хяначих гээд байна шүү дээ. Тийм юм яриад байна шүү дээ.

Тэгэхээр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн эцсийн шийдвэрийг хэн гуай ч хянахгүй гээд Үндсэн хууль дээр хараар биччихсэн ийм асуудлыг яг ийм галзуу солиотой хүмүүст ийм гарт өгвөл юу болох вэ. Тийм учраас тантай бол би санал нэг байна. Бид нар Мөнхсайхан доктор шиг тэр үндэслэл, тэр шийдвэрийг бүр үгүйсгэе

гээд ч үгүйсгэж чадхааргүйгээр үндэслэл, тооцоо, логик судалгаанд суурилж гаргадаг ийм эрх зүйчтэй болмоор байна.

Монгол Улсын дээд шүүхийн шүүгч бичсэн байна лээ. Эрх зүйн шинжлэх ухаанд шүүхийнхээ шийдвэрийг гаргахад баримталдаг 7-н арга зүй байна гэж. Арга зүй, шинжлэх ухааны 7-н арга зүй байдаг. Саяын Үндсэн хуулийн цэцийн эцсийн шийдвэрт энэ 7-н арга зүйг долууланг нь ашигласан байна. Энэ 7-н арга зүйгээр үр дүн гарахад бүгдээрээ Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэдэг тэр үр дүн нэг хариулттай байна гэдэг ийм зүйлийг шинжлэх ухааны хүн бичсэн байна лээ. Тэгээд бид ийм эрдэмтэд, судлаачдаа ямар үндсэн дээр харин Цэцэд гишүүн болгосон байсан юм бэ гэж би бас бодож байсан. Үүний үр дүн юу байсан гэхээр Шүүхийн тухай хууль байсан юм.

Шүүхийн тухай хуулиар бид Улсын дээд шүүх Үндсэн хуулийн цэцэд гишүүнд нэр дэвшүүлэхдээ 25 гишүүн нь нууц санал хураалтаар шийднэ гээд хийчихсэн чинь Монгол Улсын 45 хуульч тэнд очиж бүдэрч унасан юм. 45 хуульч шүү. Босгыг даваагүй. Нууц санал хураалтын босгыг. Тэндээс ерөөсөө гарцаагүй хүлээн зөвшөөрөгдсөн онол, практикийн арга зүйтэй нэр цэвэр ийм эрдэмтэн хүмүүс л Дээд шүүхийн босгыг давсан байхгүй юу. Нууц санал хураалтынх нь босгыг. Тэгэхээр үнэхээр шалгагдсан ийм манай салбарын тэргүүлэх эрдэмтэд очсон юм байна гэдгийг, бас Монголын заяа их юм даа гэж бодож суулаа.

Б.Пүрэвдорж: Нэлээн чухал асуулт асуусан учраас Занданшатар даргад, Ерөнхий сайдад 2 минутаар хариулахыг хүсэж байна.

Г.Занданшатар: Равжихын Эрдэнэбүрэн гишүүний асуултад хариулъя. Маш чухал асуулт асуулаа.

Тэгэхдээ нүүрсний хулгайтай тэмцэхгүй бол улс орон сүйрчих гээд байна. Тийм учраас нүүрсний хулгайтай хийх тэмцэл бол нам хамааралгүй ийм хамтарсан тэмцэл, парламентад суудалтай намуудын, намын тийм хамтын ажиллагааны үр дүн байх ёстой гэж бодож байна. Ийм ч учраас би энэ талаар санаачилгатай хэлж байгаа түрүүний хэлсэн Ганбат гишүүндээ, Батсуурь гишүүндээ, Батчимэг гишүүндээ, Эрдэнэбүрэн гишүүн, манай Ганбаатар гишүүн байна, Түвшин гишүүн байна, Сэддорж гишүүн байна. Шижир гишүүн байна. Ингээд энэ нүүрсний хулгайтай хийх тэмцэлд бас санал бодлоороо нэгдэж дэмжиж байгаад чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Яагаад гэвэл энэ бол улс орныхоо төлөө хийж байгаа ийм тэмцэл. Энхийн цагт ч гэсэн энэ улс орныг сүйрүүлж байгаа энэ нүүрсний авлига хулгайтай, баялгийн хулгайтай тэмцэхгүйгээр бид яг энэ салаа замын уулзвар дээр олдсон эрх зүйт төрийг үгүйсгэж байна. Зүгээр тооллогын комиссын журмаар Үндсэн хуулийн үзэл санааг үгүйсгэдэг ийм бага хурлын үр дүнг бид хүлээн зөвшөөрч болохгүй. Тэр албан тушаалдаа биш эрх зүйт төрийг үгүйсгэж байгаа учраас энэ парламентын засаглалаа үгүйсгэж байна. Үндсэн хуулиа үгүйсгэж байгаа энэ зарчимгүй нь энэ нүүрсний хулгайг хамгаалахын төлөө тэмцээд байгаа юм шиг улайрсан тэмцлийн төлөө бол бид нам хамааралгүй нэгдэж тэмцэх ёстой. Энэ талаар бол санал нэг байна.

Үүний тулд бид жишээлбэл Эрдэнэс Тавантолгойг цагаан сараар бид ард түмэндээ нээлттэй компани болгож, энийг яагаад нээлттэй болгох вэ гэхээр тэнд

хулгайн систем, бүлэг систем зохиочихсон юм шиг ийм худалдан авах ажиллагаа, нүүрсний хулгай олон хэлбэрээр байгаа учраас Ерөнхий сайдаар томилогдсоныхоо дараа онцгой дэглэм тогтоож, хулгайн олон хэлбэрийг илчилж, компанийн үр ашиг, орлогыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн. Одоо сонгон шалгаруулалтаар удирдлагын багыг томилоод тавигдах шаардлага нь нэг.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Тэгээд энэ нүүрсний хулгайн асуудлыг энэ төр, хууль хяналтын байгууллагын хамтарсан шалгалтаар бүрэн илрүүлэх, хариуцлага тооцох, ил тод байдлыг хангах замаар энэ компани маань ард түмний компани болж ард түмэнд өгөөжөө өгдөг, авлигачид биш ард түмэнд өгөөжийг нь хүртээдэг энэ систем бүрдүүлэхийн төлөө хамтарч ажиллахыг уриалж байгаа. Манай дэд дарга, Пүрэвдорж гишүүн маань ч гэсэн энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр энэ санаачилгыг оруулахад Үндсэн хуулийн 6.2-т оруулахад энийг дэмжиж ажилласан хүний хүрээнд Үндэсний баялгийн сангийн жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх бодит суурь нь энэ Эрдэнэс Тавантолгой. Ийм учраас энэ чиглэлд та бүхнийг хамтран ажиллана гэж итгэж байна.

Тийм учраас төр биш энэ төрийн өмчит компаниудаа нээлттэй болгох, олон нийтийн хяналтад оруулах, албан тушаалтны хяналтаас илүү ард түмний хяналтад оруулсан нээлттэй ХК-ийн орчин үеийн хэлбэрт шилжүүлэх замаар, олон түмний хяналтыг бий болгох замаар .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Буланы Бейсен гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Бейсен: Үндсэн хуулийн Их суудлын дүгнэлт гарч Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар гуайд үргэлжлэн ажиллах дүгнэлт гарсанд бас баяр хүргэе. Танд ажлын амжилт хүсье.

Өнөө өглөө бид ирцэд орсон. Дараа нь энэ өрхийн эмч нарын 25 жилийн ойн доод талын баярын хуралд очсон. Тэгсэн чинь миний чинь нөгөө дахиад эсрэг юунд гарчихжээ. Түрүүн бас бид нар шөнө 12-оос хойш, өглөө дахиж шинээр ирц үүсгэнэ гэсэн таны юун дээр бас эсрэг гарсан. Одоо танай Засгийн газрын зарим гишүүд дарамтлах янзтай байна ерөөсөө. Би доор Ерөнхийлөгчийн ивээл дор явагдаж байгаа тэр өрхийн эмч нарын юунд орсон. Тэрийг бас зөвөөр ойлгоорой гэж хэлье.

Тэгээд хэд хэдэн асуулт асууя гэж бодож байна. Энэ нүүрсний хулгайн асуудал урьд нь бас яригдаж байсан. Урьд 4 жилд. Бас л олон хулгайч, бас олон юм илрэх юм байх гэсэн чинь манай ажнай Бат-Эрдэнээр туг тахиад дараа нь чимээгүй болчихсон. Одоо энэ хулгай чинь бас тэгчих вий. Энхбаяр сайд одоо энэ хулгайч нь аль нь мэдэгдэхгүй байгаа үед та би илрүүлнэ гээд гарч байна. Тэгэхээр танд хэлэх нэг юм байна. Үнэн, шударгаар ажиллах шаардлагатай гэж бодож байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ ЖДҮ түрүүн Батсуурь гишүүний ярьж байгаа ногоон автобусны хулгай, Хөгжлийн банк, энэ дотор Эрүүл мэндийн даатгалын хулгай гээд Чинбүрэн гишүүн яриад байгаа. Өчнөөн зуун тэрбумаар алга болгочоод 30, 40 саяар торгуулаад ингээд салчихдаг. Улсыг хохироочихдог. Энэ талыг Эрүүл мэндийн даатгалын сан дээр хулгай байна уу. Ер нь цаанаа хоцорчихсон шүү дээ. Та бас тэр үед Хууль зүйн сайд байсан.

Хоёр дахь асуудал энэ Тавантолгой биш нөгөө юун дээр бас байгаа Хөшөөтийн нүүрсний уурхай дээр. Бид нар тухайн үед 2, 300 мянган тонн нүүрсний хулгай 50, 60 сая доллар гээд илрүүлээд ирсэн. Бас чимээгүй. 4.6 тэрбумын нөөцтэй тийм стратегийн ордыг улсын юунд аваагүй. Тэгсэн мөртөө энэ дээр хулгай байгаа. Асуудлууд байж байгаа.

Занданшатар Ерөнхий сайдаас асууя. Энэ Оюу толгойн асуудал байж байгаа. Энэ хэвлэл мэдээллээр ярьж байх юм Засгийн газар өөрөө 16 тэрбум доллар, нийлээд 24 тэрбум долларын өртэй гээд яриад байна. Тэгэхээр энд бас хулгай байна уу, аль эсвэл гэрээг нь буруу хийсэн юм уу. Энийгээ Оюу толгойн гэрээг Монгол Улсад ашигтайгаар байлгах талаар та ямар бодолтой байна. Ер нь цаашдаа энэ дээр ямар бодлого барьж ажиллах вэ. Энэ ухаж ухаж дуусчих юм уу. 1 минутаа сунгаад аваадахъя.

Б.Пүрэвдорж: 1 минут сунгая.

Б.Бейсен: Дараа нь энэ ухаж ухаж байгаад бүх алт, зэсийг нь аваад явчхаад тэгээд юм ч үгүй үлдэх юм биш биз манай улс. Энэ тал дээр та ямар бодлого баримталж байна.

Энхбаяр сайдаас дахиад нэмээд асуулт асууя. Энэ сая та бас ярилаа. Энэ хулгайн асуудал дээр тодорхой та тэмцэнэ, бодит баримт нь байна гээд яриад байна. Тийм учраас энийг бид гишүүд ч эхэндээ гайхсан. Аль нь хулгайч юм мэдэхгүй. Тийм учраас та энэ дээр тодорхой байр суурьтай ажиллах байх гэж бодож байна. Ер нь цаашдаа ер нь ард түмэн ч итгээд байна. Энэ дээр ажиллах байх гэж бодож байна. Танд энийг бас дэмжиж байгаагаа хэлье. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Баттөмөрийн Энхбаяр гишүүн хариулъя.

Б.Энхбаяр: Хулгай ч олон янз л даа. Түрүүн Ганбаатар гишүүн бас асууж байсан. Хуулийн хулгайтай тэмцэнэ гэсэн ийм уриатай энэ уриаг дэмжиж байсан. Энэ их гишүүд энийг сайн анзаардаг болсон байх. Ер нь хуулиар үг, үсэг ямар их нарийн байдаг юм бэ гэдгийг. Би ганцхан жишээ хэлье. Энэтэй ганцхан Хууль зүйн сайд тэмцэж чадахгүй шүү. Хуулийн хулгайтай бол хууль тогтоогч хүн бүхэн тэмцэх ёстой. Намайг хуулийн сайдаар ажиллаж байх үед одоо энэ Шинэ хоршоотой холбоотой хуулийн төсөл Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдсэн юм. Би энэ хуулийн төслийг үзэл баримтлалыг Хууль зүйн сайд баталдаг. Би батлаагүй.

Яагаад гэвэл энэ маш их хэмжээний мөнгийг улс төрийн зорилготой гаргах гээд байна аа. Би 10 хуудас дүгнэлт өгч байсан. Хууль зүй, дотоод хэргийн сайдаас 10 хуудас энэ асуудлаар дэмжихгүй гэдэг санал өгч байсан. Улмаар Монгол Улсын Засгийн газарт Улсын Их Хурлын дарга байсан Амарбаясгалан Хэрэг эрхлэхийн сайд байх үед Хууль зүй, дотоод хэргийн энэ бичгээр өгсөн саналыг хүлээж авлаа, тусгалаа гэж хэлээд холбогдох заалтуудыг нь хасаад Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн.

Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Хууль зүйн сайдын санал тусгагдчихсан байсан. Өөрөөр хэлбэл энийг хасах, тэрийг хасах гэдэг заалтууд хасагдсан байсан. Тэгээд Улсын Их Хурал дээр ороод ирсэн чинь Хууль зүйн сайдын Засгийн газрын төслийг Улсын Их Хуралд өргөн барихдаа зөвшөөрөл өгч

хянасан хамгийн сүүлийн хувилбарынх нь төсөл нь өөрчлөгдчихсөн байсан. Өөрөөр хэлбэл, Хэрэг эрхлэхийн сайд Амарбаясгалан Хууль зүйн сайдыгаа залилаад, Хууль зүйн сайдын саналыг тусгалаа, авлаа гэж хэлж байгаад Улсын Их Хурал, Засгийн газраар хэлэлцэгдээгүй, Хууль зүйн сайдын хянагдаагүй ийм хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барьж баталсан байсан. Энэ бол би албан тушаалын гэмт хэрэг гэж үздэг. Албаны бүрэн эрхээ хэтрүүлэх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг гэж үздэг.

Улмаар би энэ асуудал Улсын Их Хуралд хэлэлцэгдэх үед Байгаль орчны Байнгын хороон дээр орж албан ёсоор протоколд хэлсэн. Та бүхний хэлэлцэж байгаа энэ төсөл бол Монгол Улсын Засгийн газраар хэлэлцэгдсэн тэр Хууль зүй, дотоод хэргийн сайдын эцэслэн хянасан энэ төсөл биш шүү гэж би албан ёсоор протоколд хэлсэн. Тэгэхээр ийм хулгай хийгээд сурчихсан. Засгийн газрыг нь, Хууль зүйн сайдыг нь, Улсын Их Хурлыг нь, хуулийг нь хулгай хийгээд сурчихсан явж байгаад Үндсэн хуулийг нь хулгайлах гэж байгаад сая баригдаад таслан зогсоогдчихож байгаа юм.

Үндсэн хууль бол Монгол Улс, Монголын ард түмэн. Монгол Улсын тусгаар тогтнолд халдсан хэн бэ гуайн ч толгойг нь авах ёстой, цээрлүүлэх ёстой. Хэн байх нь хамаагүй. Ард түмэнд үзүүлдэг байх ёстой. Энэ бол ард түмний эрх чөлөө, улс орны тусгаар тогтнол, төрийн бүрэн эрхт байдалд халдаж байгаа асуудал.

Б.Пүрэвдорж: Оюу толгойн асуудлаар Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар хариулна.

Г.Занданшатар: Оюу толгойн гэрээний асуудлаар бол анхнаас нь би дэмжиж байгаагүй. Тийм ч учраас Улсын Их Хурлын даргаар томилогдоод миний анхны гаргасан Улсын Их Хурлын 103 дугаар тогтоол байгаа. 103 дугаар тогтоолоор Дубайн гэрээг хүчингүй болгох, Монгол улсад ч ашигтай болгох ийм тодорхой шаардлагатай Улсын Их Хурлын тогтоолыг баталж, тэрний дагуу яриа хэлэлцээ өрнүүлж явсан. Харамсалтай нь хамгийн гол асуудал болох зээлийн хүүг бууруулах асуудал хаягдсан юм байна лээ. Зээлийн хүү өндөр байгаа нь зардлыг өндөр болгож, манай 34 хувийг үр ашиггүй болгож, хүүгийн аргаар зардлыг өсгөж байгаа ийм нөхцөл гэж үзэж бид нар бол яриа хэлэлцээрийг эхлүүлсэн.

Ер нь Оюу толгойтой бүх талын яриа хэлэлцээр явуулж арбитрын шүүхээр ч гэсэн маргаж байгаа. Ингээд тодорхой амжилтад хүрч байсан боловч энэ санаатай, санамсаргүй боловч өнөөдрийн энэ огцруулах үйл ажиллагаанууд Засгийн газрын легитим чанарыг тодорхой хэмжээгээр сулруулж сая хэлэлцэгч талуудын хувьд ч гэсэн бас итгэл үнэмшил сулрах, дараагийн Засгийн газартай нь ярилцъя ч гэдэг юм уу энэ тогтворгүй байдал чинь бүх бидний үйл ажиллагаанд сөрөг.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Эрүүл мэндийн даатгал болон Хөшөөтийн уурхайн асуудлаар нэмж хариулъя. Занданшатар Ерөнхий сайд аа.

Г.Занданшатар: Ингээд Оюу толгойн асуудлыг дуусгахад бол бидний Монгол Улсад ашигтай болгох зорилгоор бүх талын үйл ажиллагаа явуулж байгаа, зардлыг өсгөж байгаа сая тэр авлигал, хээл хахуультай асуудлыг ч гэсэн өнөөдөр бид нар манай тусгай албад илрүүлэн шалгаж, 10 гаруй тэрбум төгрөгтэй холбоотой асуудал энэ тэрийг илрүүлэн шалгаж байна. Энэ бол Монгол улсдаа ашигтай болгохын төлөө, тэгэхдээ гадаадын хөрөнгө оруулалтыг тогтвортой байдлыг хангах нь зүй

ёсны хэрэг боловч Монгол улсдаа ашигтай болох бүх талын үйл ажиллагааг хэрэгжүүлж байна гэдгийг хэлчихье.

Эрүүл мэндийн даатгалын сан дээр бол бас хулгай нүүрлэхихсэн. Энэ гүйцэтгэлийн санхүүжилтийн асуудал өнөөдөр бүх эмнэлгүүд дээр асуудал болоод байна. Ийм учраас энэ Эрүүл мэндийн даатгалын сангийн захирлыг сольж, тодорхой шинэчлэлийн бодлогыг манай Чинбүрэн сайд хэрэгжүүлж байгаа. Та эмч хүний хувьд хамтарч ажиллаж байгаа энэ чиглэлээр анхаарна биз. Танд бас дахин талархал илэрхийлэхэд энэ эс үйлдэхүйгээр Засгийн газрыг огцруулж болохгүй л гэж Үндсэн хуульчилсан юм бид нар. Ямар нэг шалтгаанаар танд чинь ингээд гарчихсан хүмүүсийг эс үйлдэхүйгээр Засгийн газар холдуулж болохгүй. Огцруулъя гэсэн чин итгэл үнэмшлээр хүн кноп дарж байж огцруулах ёстой гэсэн агуулгаар.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Одоо Дамбын Батлут гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Батлут: Оройн мэнд хүргэе. Зарим нэг гишүүдийнхээ өмнөөс санаа зовниж явна гэдэг ч бас лүд юм даа нээрээ. Та бүхэн танхимаа хар даа. 10 сарын 16-ны өдрийн Үндсэн хууль зөрчихийг сануулаад байсан гишүүд нь орж ирэхгүй байсан, Үндсэн хууль зөрчих гээд байгааг сануулсан гишүүд нь орж ирэхгүй байсан хуралдааны эсрэг байрлалчихсан. Сануулаад орж ирэхгүй байсан хүмүүс нь орж ирээд суучихсан. Нөгөө Үндсэн хууль зөрчих гээд байсан хүмүүс нь гараад суучихсан. Тэгээд хүчиндээд хурлаа хийгээд Үндсэн хуулиа зөрчсөн. Тэгээд Ерөнхийлөгч хориг тавьсан. Үндсэн хуулийн цэц Үндсэн хууль зөрчсөнийг тогтоочихсон. Ингээд шийдвэр гарсан.

Ингээд шийдвэр гарсны дараа манайхан, нөгөө нөхөд маань тайлбарлаад л яваад байгаа юм янз янзаар. Мэдээд ч тайлбарлаад байгаа юм уу хуулиа мэдэхгүй ч тайлбарлаад байгаа юм уу, эсвэл нийгэм мэдэхгүй учраас мэддэг юм шиг жүжиглээд байгаа юм уу бүү мэд. Одоо зарим нэг гишүүд нь Засгийн газрын гишүүд амь насанд халдахаар заналхийллээ л гэнэ, намайг дагаж гүйцэтгэх ажиллагаа зохион байгуулж байна гээд баахан машины дугаар барьчихсан зогсоод байх юм. Үгүй ээ Монгол төрийн тусгай албаны энэ гүйцэтгэх ажиллагаа чинь тэгээд тийм ил цагаан явдаг болчихсон юм уу. Амныхаа зоргоор ярьдаг болчихлоо шүү. Ингэж яриад байгаа яриаг чинь ард иргэд юу гэж сонсож байгаа гээч. Нүдээ аниад чихээ бөглөөд сонсож байгаа шүү. Төрийн ажлыг гацаах гээд, тэр дундаа Хууль зүйн сайдаар Энхбаярыг ингээд томилох гээд ирэнгүүт ингээд арга ядаж байгаа байдлууд чинь нүүрсний хулгай гэдэг чинь байгаа юм байна, үнэн юм байна гэдэг зүйлийг баталгаажуулж байгаа юм.

Өнөөдөр бид нар, багш нар, эмч нарыгаа цалинг нэмэх, ахмадуудынхаа тэтгэврийг нэмэхэд 1 их наяд төгрөгийг хаанаас гаргах вэ гээд хуруугаа, хумсаа хуйхлах гээд сууж байгаа шүү дээ ойролцоогоор. Тэгэхэд энэ нүүрсний хулгай ард хэдэн зуу, их наядын асуудал яригдаж байгаа юм. Тэгээд үүнийгээ цэгцлэхгүй юм уу. Цэгцэлье гээд хуулиа, хурлаа хийгээд цаашаа явах гэхлээр нөгөө нөхөд гараад явчхаж байгаа юм байна л даа. Үгүй ээ ингээд Бортээгийн уурхайг ярьж байгаа юм. Тэндээс нэг хүрз нүүрс олборлоогүй ээ гээд. Бортээгийн уурхай байгаа газарт чинь 35 га газрыг нь аваад нүүрс угаах үйлдвэрээ барьчхаад барьцаалаад байна. Тэгээд тэр нүүрсийг буюу 404 их наядаар үнэлэгдэх нүүрсийг монопол эрхтэйгээр тэр “Админерал” гэж компани нь зарж борлуулах эрх авчхаад гэрээ байгуулчхаад байгаа асуудал шүү дээ. Би тэгж ойлгоод байгаа. Би Энхбаяр нэр дэвшигчээс,

Ерөнхий сайдаас асууя гэж бодож байна. Энэ үнэн юм уу. Би бол ингэж ойлгож байгаа. Энэ хулгайн асуудал энэ тэрийг цэгцлэх хэрэгтэй шүү дээ. Тэгэх юм бол энэ багш нар, эмч нарын цалин гээд бид цалинг бид нар 1000 долларт хүрэх асуудал алга байна.

Б.Пүрэвдорж: 1 минут нэмж тодруулъя.

Д.Батлут: Ахмадынхаа тэтгэврийг нэмэгдүүлэх ч гэсэн асуудал алга байна шүү дээ. Үнэндээ байгаа төсөв маань хүрэхгүй учраас хумсаа хугалчих гээд сууж байгаа хүмүүс шүү дээ бүгдээрээ. Тэгээд бүгдээрээ жоохон үнэн ярьж, энэ хуралдааны танхимд иргэдэд үнэн мэдээлэл хүргэмээр байна. Тэгэхгүй зүгээр амныхаа зоргоор ярьж, хуулийг өөр өөрсдийнхөөрөө тайлбарлаж, хүний тархи толгой угаахаа больцгоомоор байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуултад хариулъя.

Б.Энхбаяр: Үгүй ээ, энэ үнэн үү, худлаа юу. Энэ чинь бүр их тийм сонин юм болоод байгаа шүү дээ. Энэ Амарбаясгалан дарга энэ Админерал-тай холбоотой асуудлаа цэгцэл гэж манай Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд 2023 оны 11 сард нүүрсний сонсгол зохион байгуулагдахаас 45 хоногийн өмнө Монгол Улсын Засгийн газрын хуралдаан дээр хэлж байсан. Өөрөө хэлж байсан шүү дээ. Тэгээд энэ сонсгол тэр хэвлэл мэдээллээр гарсан гэж байгаа. Тэр асуудлуудыг хянан шалгагч шинжээч нар судлаад бүхэлдээ хууль тогтоомж зөрчиж Бортээгийн орд дээр нүүрс баяжуулах үйлдвэр барина гэдэг тендер зарлах халхавчаар, би халхавчаар гэж хэлээд байна шүү дээ. Тендер нь тийм нэртэй. Тендерийнх нь бичиг баримтыг нь юу гэж өөрчилсөн гэхээр Бортээгийн нүүрсийг зах зээлийн үнээр худалдан борлуулах эрх өгчхөж байгаа байхгүй юу даа тэр компанид. Хамгийн гол асуудал энд байгаад байгаа юм. Шанага нүүрс ашиг ухаагүй шүү дээ Бортээгээс. Одоо байж байгаа шүү дээ гэж хэлээд байгаа юм.

Тэр нүүрсийг чинь энэ сонсгол хийгээд өмнөх Улсын Их Хурал 24 оны 1 сард хууль бус ийм үйл ажиллагаа болсон байна гэж тогтоод цуцалсан учраас хулгай үргэлжлэх боломжийг хааж зогсоогдсон байхгүй юу. Зогсоогдсон. Манай Амарбаясгалан дарга чинь бүр ингэсэн шүү дээ. Би энэ тэр нүүрсний хулгайны Админерал-ын эрхийг цуцлах Улсын Их Хурлын тогтоол гарахаас 1 өдрийн өмнө, 1 өдрийн өмнө, өмнөх өдөр нь гэсэн үг. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын сайдынхаа хувьд энэ Админерал-ын эрхийг цуцал аа гэдэг бичгийг Эрдэнэс Монголын ТУЗ-ийн дарга руу явуулчихсан байсан. Хүн харахад яаж байна вэ. Би өөрөө цуцал гэдэг бичгийг өгсөн биз дээ гэж хэлж байгаа биз. Гэхдээ энэ заль байсан. Залилан байсан. Яах гэж байсан гэхээр хууль бусаар цуцлуулаад Захиргааны хэргийн шүүх дээр унагаад хууль бус шийдвэр гаргуулж байгаад шүүхийн шийдвэрээр буцаад зөвшөөрлийг нь олгох гэж байх залилан явсан энд. Хэрвээ Улсын Их Хурал хууль бус гэдгийг нь тогтоогоод хүчингүй болго гэдэг тогтоол гаргаад тэр тогтоолыг үндэслээд Засгийн газар шийдвэрээ гаргах юм бол энэ нь шүүхэд хандах боломжгүй нөхцөл байдлыг эрх зүйн хувьд үүсгэх гээд байсан байхгүй юу. Тэгэнгүүт Улсын Их Хурал шийдвэр хууль бус гэдэг шийдвэрийг нь гаргахаас 1 хоногийн өмнө өрсөж зориуд хууль бусаар цуцлуулах, тэгээд шүүхээр энийгээ сэргээлгэх хүртэл арга хэмжээ авч байсан.

Би тэр 2024 оны 1 сард Улсын Их Хурлын чуулганы танхимд хэрвээ Улсын Их Хурал энэ тогтоол гаргахаас өмнө та бүхэн цуцлах юм бол энэ бол үгсэн хуйвалдсан

ажил боллоо шүү. Үүнийгээ болиорой гэж хэлээд тэгээд тухайн үед Эрдэнэс Монгол, Эрдэнэс Тавантолгойн удирдлагууд энийг цуцлаагүй юм. Сайндаа цуцлаагүй шүү бас. Тэгээд энийгээ цуцлахгүй хэдэн сар, жил явсан бэ. Их Хурлын тогтоол 2024 оны 1 сард гарсан. 2025 оны 5 сар цуцалсан шүү дээ Оюун-Эрдэнийн Засгийн газар. Жил 5 сарын дараа. Тэгэхдээ хэзээ гээч. Би намын бүлгийнхээ хурал дээр намын дарга, Ерөнхий сайдыгаа аятайхан байгаарай ах, дүү хоёр минь гэж хэлж байж нэг юм цуцалсан тэр долоо хоногт. Нөгөөдөр нь цуцал.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг огцруулах, томилох тухай асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайд Улсын Их Хуралд танилцууллаа.

Одоо Ерөнхий сайд захирамж гаргаж, дээрээс нь томилох асуудлыг шийдвэрлэнэ. Энэ хугацаанд 10-15 минут чуулган түр завсарлана. Энэ хооронд, үүний дараагаар тангараг өргөсний дараагаар төсвийн асуудалтай холбоотой 2 асуудал дээр санал хураалт явуулна.

Ирцээ бүрдүүлэхийг хүсэж байна. Яагаад гэвэл энэ төсөв 11 сарын 15-ны дотор батлах үүрэгтэй. Тийм учраас энэ үүргээ хэрэгжүүлж, ирэх жилийн төсөв батлагдахгүй байх юм бол маш том эрсдэлд орно. Тийм учраас энэ эрсдэлээс сэргийлж 11 сарын 15-ны дотор төсөв батлахын тулд өнөөдөр 2 асуудлыг, санал хураалтыг явуулж цэгцлэх ёстой.

Чуулганыг 16 цаг 20 минут хүртэл завсарлууллаа. Уучлаарай. 17:20 хүртэл шүү.

16.59 цаг.

Б.Пүрэвдорж: Энэ миний дэлгэц дээр хэлэлцэх асуудал гээд бичээд байгаа. Танилцуулах асуудал 5.

Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө.

Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар Засгийн газрын гишүүнээр томилсон тухай захирамжийг уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд онцгой бүрэн эрхийнхээ дагуу Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаярыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хуралд танилцуулсны үндсэн дээр Хууль зүй, дотоод хэргийн сайдаар томилж батламжиллаа.

Төрийн шударга байдал, иргэдийн итгэл хоёр салшгүй холбоотой. Хууль шударгаар үйлчилж, хуулийн өмнө хүн бүр тэгш эрх байж, төр хариуцлагатай ажиллах ёстойг ард иргэд шаардаж байна. Монгол Улсын сайд гэдэг бол ард иргэдийнхээ итгэлийг даах, хэлсэн үг, хийсэн ажилдаа эзэн байх хамгийн дээд

хариуцлага юм. Сайд хүн бол албан тушаалын биш ард түмний итгэлийн эзэн байх учиртай.

Ерөнхий сайд шинээр томилогдож байгаа Засгийн газрын гишүүндээ болон нийт Засгийн газрын гишүүддээ хандан төрийн үйл хэрэгт хоёргүй сэтгэлээр зүтгэж, Үндсэн хуульт, эрх зүйт төрийг батлах үүргээ бүрэн ухамсарлан танхимын зарчмаар хамтран ажиллаж, улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, хамгийн гол нь Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, улс эх орныхоо эрх ашгийг дээдлэн ажиллах явдал юм гэж шаардаж, шахаж ажиллах болно.

Монгол Улсад худал, хулгай биш үнэн, Үндсэн хууль, хууль дээдлэх ёс ялах учиртай. Хууль дээдэлсэн төр, шударга ёсонд итгэсэн иргэн, хариуцлагатай төрийн алба энэ гурвын нэгдэл дээр Монгол Улс хөгжин дэвжих учиртай. Баялагтаа эзэн, шударга төртэй Монголынхоо төлөө хамтран зүтгэе. Мөнх хөх тэнгэрийн хүчин дор Монгол Улс мандан бадрах болтугай.

Б.Пүрэвдорж: Одоо Засгийн газрын гишүүн тангараг өргөх ёслолын ажиллагааг эхлүүлье.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр таныг тангараг өргөхийг урьж байна.

Б.Энхбаяр: Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, Засгийн газрын гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.

Б.Пүрэвдорж: Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөлөө. Танд баяр хүргэж, ажлын амжилт хүсье.

Тангараг өргөх ёслолын ажиллагаа өндөрлөснийг мэдэгдье.

17.28 цаг.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалтдаа бэлтгээрэй. Хурууны хээгээ өгөөрэй. Ирцийн санал хураалтыг явуулъя.

Өглөө хэд хэдэн асуудлыг хэлэлцэх санал хураалтыг хойшлуулсан байгаа.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд. Санал хураалт явуулъя.

Томьёоллоо уншина. Сая би та нарыг шалгасан юм.

Нэгдүгээрт нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт. 99 гишүүнээс 54 гишүүн дэмжиж, 54.5 хувиар дэмжигдлээ. Замира гишүүн дэмжсэнээр, Хэрлэн гишүүн дэмжсэнээр орлоо.

2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хурааа. 99 гишүүн оролцож, 59 гишүүн дэмжиж, 59.6 хувиар дэмжигдлээ.

3.“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хурааа. 56 гишүүн дэмжиж, 56,6 хувиар дэмжигдлээ.

4.“Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хурааа. 99 гишүүнээс 58 гишүүн дэмжиж, 58.6 хувиар дэмжигдлээ.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

17.37 цаг.

Дараагийн асуудал буюу “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалтыг явуулна.

Санал хураалт. Санал хураалтад эхлээд бэлдэх ёстой юм байна. “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хурааа. Тогтоолын төслийг баталлаа. Улсын Их Хурлын гишүүддээ баярлалаа.

Өө энэ чинь нээрээ юугаа уншаагүй байна шүү дээ. Би тийм айхтар бас туршлагатай хүн биш шүү. Сая энэ санал хураалт уначихлаа. Сая бэлтгэл, ирцийн бэлтгэлдээ ороогүй хүмүүс “эсрэг” санал өгчих шиг боллоо л доо. Лүндэг гишүүн санал гаргая гэж байна.

С.Лүндэг: Би сая энэ төхөөрөмж ажиллахгүй байж байгаад санал хураалтад орж чадсангүй. Дахиж энэ санал хураалтыг, саяын саналыг хүчингүй болгож өгөөч гэдэг горимын санал гаргаж байна.

Б.Пүрэвдорж: Лүндэг гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулъя. Горимын санал. 99 гишүүнээс 55 гишүүн дэмжиж, 55.6 хувиар дэмжигдлээ.

Дахин томьёоллыг уншъя. “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 99 гишүүнээс 59 гишүүн дэмжиж, 59.6 хувиар дэмжигдлээ.

Тогтоолын төслийг баталлаа. Улсын Их Хурлын гишүүддээ талархлаа. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

17.41 цаг.

Дараагийн асуудалд оръё. Хэлэлцэх асуудал 6.

Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай саналыг хэлэлцэнэ.

Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Уянгахишиг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатараас Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай саналыг 2025 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороо 2025 оны 10 дугаар сарын 15, 16-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 88 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд гаргах саналын талаар танилцуулсан бөгөөд уг асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Х.Баасанжаргал нар асуулт асууж, хариулт авч, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Б.Энхбаяр нар үг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэгт заасны дагуу саналд дурдсан асуудал нэг бүрээр хэлэлцэж, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 45.2.3 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална гэж заасныг, мөн зүйлийн 3 дахь хэсгийн Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж, Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна гэж заасныг тус тус зөрчсөн эсэх талаарх Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай Улсын Их Хурлын гишүүний саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 53.8 хувь нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай Улсын Их Хурлын гишүүний саналыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Б.Пүрэвдорж: Уянгахишиг гишүүнд баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

С.Эрдэнэболд: Сайн байцгаана уу. Ажлын хэсгээс асуулт асууя. Энэ яг энэ халдашгүй байдалтай холбоотой асуудал ер нь бол бид нар зарчмын хувьд олон улсын жишгээрээ парламентат ёсны дархлаа парламентын гишүүний бүрэн эрхийн асуудал байдаг. Парламентын гишүүний бүрэн эрхийн асуудалтай холбоотой Английн парламентын нэг сонгодог жишээ байдаг л даа. Хаан төсвийг хэтрүүлж хэрэглээд байна, өөртөө хэт тансаглаад байна гээд тодорхой парламентын гишүүд санал гаргасан. Миний эрх хэмжээг хязгаарладаг хэн бэ гээд хаан тэдгээр парламентын гишүүдийг хариуцлага тооцохоор ордонд ирэхэд парламент нь тэр парламентын гишүүдээ хамгаалаад зугтаалгаад үлдэж байсан гээд 4, 500 жилийн өмнөх кэйс. Энэ үеэс эхлээд энэ парламентын гишүүний халдашгүй байдал, дархлааны асуудал орж ирсэн байдаг. Тэгээд энэ жирийн иргэд яаж байна гэхлээрээ хуучин 76 гишүүн байхад байж болох хамгийн хэцүү үгнүүдээр 76 гишүүнийг шүүмжилдэг байсан. Одоо 126 гишүүн гэнгүүт мөн ялгаа байхгүй. Ер нь энэ 126 чинь бүтэхгүй юм байна гэсэн нэг талаас хэвлэл мэдээллийн Пи Ар, нөгөө талаас энэ байгаа төрийн арчаагүй байдал нь тийм шүүмжлэл рүү дагуулаад оччихдог.

Гэтэл яг энэ Их Хурлын гишүүний халдашгүй дархан байдал, ер нь төрийн өндөр алба хашиж байгаа хүмүүсийн энэ халдашгүй байдал гэдэг бол зөвхөн энэ тансаглах, илүү эрх дарх эдлэхтэй холбоотой зүйл биш. Харин өөрөө энэ парламентат ёсны төлөвшил, парламентын аюулгүй байдал, дээрээс нь хууль засаглах, цаашлаад Үндсэн хуульт ёсны төрийн байгуулалтай шууд утгаараа холбоотой байдаг.

Тэгэхээр яг энэ асуудлыг ярихаар иргэдийн дунд асар их шүүмжлэл байгаа. Тэгэхээр би санаачлагчдаас асуух гэж байгаа нь асар их шүүмжлэл байдаг. Ерөөсөө л өөрсдийнхөө эрх дархыг хадгалах гээд байгаа юм байна, хамгаалах гээд байгаа юм байна. Өөрсдийгөө л эрх мэдлээр хуяглах гээд байгаа юм байна. Эцсийн эцэст энэ бол ач холбогдол багатай зүйл юм аа гэсэн ийм үндэслэлүүдийг хэлдэг.

Нэг талдаа үнэн боловч нөгөө талдаа энэ парламентын гишүүд маань тодорхой явцуу ашиг сонирхолд хөтлөгдөх, олон нийтийн сэтгэл зүйд тохирох популизм хийх Пи Ар-ын суурьтай улс төрийн нүүдэл хийх, судалгаа, бодлогод захирагдахгүй байх, судалгаа бодлогыг үндэслэхгүй байх гэсэн ийм хам шинж, өвчин шиг юмнууд гарчхаад байгаа юм.

Тэгэхээр ер нь Орос, БНХАУ гэсэн хоёр улсын дунд цөөн хүн амтай, эдийн засгийн хувьд бас сорилт бэрхшээлтэй, гадаад эдийн засгийн хараат байдалтай ийм орны хувьд бол энэ парламентын засаглалаа бэхжүүлэхэд энэ хуулийн үзэл санаа ямар ач холбогдолтой гэдэг талаас нь хууль санаачлагч тодруулна уу гэж хүсэж байна.

Б.Пүрэвдорж: Цогтбаатар дарга аа ер нь дэгээрээ 2 хүн хариулах ёстой. Хэн хариулах юм. Цогтбаатар дарга хариулъя.

Д.Цогтбаатар: Энэ иргэдээс шүүмжлэл дагуулах нь аргагүй. Яагаад гэвэл одоо энэ асуудлыг яригдаж байхад би Байнгын хороо дээрээ ч хэлж байсан. Нэг л Их Хурлын гишүүд гэмт хэрэг үйлчлэхэд энэ Их Хуралд орж ирээд нуугдаад байдаг, дархан эрхийн ард нуугдаад байгаа юм шиг ийм сэтгэгдэл төрөх тийм нөхцөл байдал үнэхээр үүсээд байгаа нь үнэн. Энэ дээр дархан эрхийн асуудлыг би бол жишээлбэл ойлгохдоо үг хэлэх эрх чөлөөг нь хамгаалах гэж олгосон байгаа. Түүнээс аливаа нэг гэмт хэргээс, прокурорын газар шалгахаас нь хамгаалсан ч юм уу гэмт хэрэгтнийг хэзээ ч, хаана ч тэр нь ёстой ямар эрх тушаалтан, албан тушаалтан байна гэмт хэрэг үйлдсэн бол тэр шалгагдаж байх ёстой. Миний байр суурь бол ийм байгаа.

Энэ асуудал дээр Үндсэн хууль дээр томъёологдсон байгаа энэ томъёо эд нараасаа хараад үзэхэд яах аргагүй нэг талаас нэг байр суурь хэлэгдэнэ. Тэр техникийн яг цэвэр эрх зүйн бас тайлбарын асуудлаа Үндсэн хууль цэц нэг тал руугаа гаргаж өгөх нь зөв байх. Түүнээс энэ дээр бид нар сая л гэхэд Үндсэн хуулийн маргаан чинь тал талдаа бид нар өөр өөрөөр тайлбарлаж явж байж эцсийн дүндээ бид нарын хэн нь ч Үндсэн хуулийн цэцийн өмнөөс тэр тайлбарыг чинь гаргаж чадахгүй байгаад байна шүү дээ. Үндсэн хуулийн цэц энийг нэг талд нь гаргаж өгнө. Би нэг талдаа гаргаж өгөхдөө энэ дээр бол гэмт хэрэгтнүүдийг хамгаалах талдаа гаргах ямар ч боломжгүй гэж бодож байна.

Яагаад гэвэл Үндсэн хуулийн өөрийнх нь цаад санаа, агуулга тийм байхгүй юу. Их Хуралд дэвшихдээ бид нар бүгдээрээ цагдаагаас би ямар нэгэн гэмт хэрэгт холбогдоогүй гэсэн. Өөрөөр хэлбэл ёстой нөгөө презумпц ярих юм бол юу гэмгүйн зарчим энгийн иргэдэд үйлчилдэг бол Их Хурлын гишүүдийн хувьд бол ерөөсөө гэмт хэрэгт холбогдоогүй байх презумпц шууд үйлчилж байгаа байхгүй юу. Тийм учраас тэр шалгуурыг давж байж нэр дэвшиж орж ирж байгаа шүү дээ. Тэгээд ийм зүгээр маргаантай асуудал байгаа болохлоор нөгөө эрх бүхий Үндсэн хуулийн цэц дээрээ нэг тал руугаа гарахгүй бол энэ маргаан цаашаа яваад л байх юм байна лээ.

Б.Пүрэвдорж: Тогтоолыг санаачлагч Сайнхүүгийн Ганбаатар гишүүн хариулна.

С.Ганбаатар: Эрхэм гишүүд ээ,

Энэ дээр хов хонзонгоор төрийн ажлыг явуулж болохгүй ээ. Энэ бол яг л зарчмын зүйл ярьсан. Миний хувьд бол Хууль зүйн байнгын хороогоор анх удаа би бас асуудал оруулж байгаа. Хуульч гишүүд бол асуудлыг субьектив биш объектив хандах ёстой гэж би итгэдэг. Тэгээд энэ дээр гол хэлэх гэж байгаа санаа гэвэл 4 жил энэ Улсын Их Хурлын гишүүний дархан эрхийн ард нуугдах тухай яриагүй. Гэмт хэрэгт холбогдонгуут л шууд бүрэн эрхээс нь түдгэлзүүлдэг, Улсын Их Хурлаар орж ирдэг энэ асуудлыгаа би хамгаалж явсан. Одоо яаж байна Улсын Их Хурлын гишүүнийг зүгээр л гүтгээд л алуурчин, хулгайч гээд л. Тэгээд л АТГ дээр байцаагаад л яваад байдаг. Тэгэнгүүт л энэ нөгөө дархан эрхэд нөлөөлдөг. Нөгөө сонгогчдын эрхэнд нөлөөлөөд байдаг. Өнөөдөр энэ хувь хүний асуудал яриагүй. Улсын Их Хурлын гишүүн ураны асуудлаар, Оюу толгойн асуудлаар маш том байр суурь, шийдвэр гаргадаг. Энэ дээр.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: 1 минут нэмж өгье.

С.Ганбаатар: Энэ дээр Авлигатай тэмцэх газар дээр, прокурор дээр гогодуулчихсан яваа бол тэр хүний шийдвэр гаргах тэр дархан эрхэд, сонгогчдын эрхэд халдаж байна гэсэн үг. Энийг нь үндсэндээ Үндсэн хууль зөрчсөн бол, 29.3 дээр Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг эргүүлэн татна. Хамгийн гол нь Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг гэж байгаа юм шүү дээ. Холбогдонгуут л тат гэж байгаа юм. Тэрнээс биш ингээд зовоогоод ингээд АТГ дээр дэгээтэй байгаа тохиолдолд Улсын Их Хурлын гишүүд хараат бус байдлаар асуудалд орох гээд байна аа олон гишүүд. Би нэрийг нь яриад яах вэ. 4 жил өнөөдөр шүүх дээр гогодуулж байгаа хүн яаж өнөөдөр яг ингэж хараат бусаар асуудлыг шийдэх вэ. Би өнөөдөр өөрөө бол гүтгүүлээд, доромжлуулаад, сошиалаар яллуулчихсан хүн. Надад хамаагүй. Дараа дараагийн парламентын гишүүд, залуучуудад, дараа дараагийн парламентад энэ чухал учраас энэ асуудлыг ярьж, дараа дараагийн улсууд хэнээс ч айхгүйгээр хараат бус байдлаар үгээ хэлдэг байх боломжийн төлөө л өнөөдөр энийг ярьж байгаа.

Б.Пүрэвдорж: Эрдэнэболд гишүүн тодруулъя.

С.Эрдэнэболд: Олон улсын жишгээр төрийн тэргүүнүүд буюу Ерөнхийлөгч нарын хувьд бол ийм кэйсүүд байдаг. Жишээлбэл Францын Ерөнхийлөгч Саркози яг албан тушаалаасаа буугаад шалгуулж байсан ч гэдэг юм уу, энэ Израилын Ерөнхий сайдын асуудал ч гэдэг юм уу олон улсад энэ кэйс бол Ерөнхийлөгчийн түвшинд, Ерөнхий сайдын түвшинд түгээмэл байдаг.

Харин парламентын гишүүний түвшинд энэ хууль санаачлагчдаас тодруулж асуух гээд байгаа нь зөвхөн Монголын кэйсээс илүүтэйгээр олон улсын яг энэ эрх зүйт нийгэм төлөвшсөн, парламентын засаглал төлөвшсөн орнуудын кэйс, судалгаан дээр та бүхэн ямар дүн шинжилгээ хийсэн юм бэ. Энэ талаар дэлгэрүүлж, тодруулж тайлбарлахгүй юу. Ер нь миний харж байгаагаар маш олон орны парламентад яг л Монголын одоо явж байгаа парламентын жишгийн дагуу байдаг. Тэр би асуултыг чинь үгүйсгэж, асуудлыг чинь хуулийн төслийг үгүйсгээд байгаа биш нэгэнтээ энэ эмзэг асуудал учраас иргэд, олон нийтэд бас их ойлголт өгөх ёстой л гэж харж, лавлаж асуугаад байгаа юм шүү.

Б.Пүрэвдорж: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн хариулъя.

С.Ганбаатар: Эрдэнэболд гишүүн маш чухал асуудлыг гаргаж ирж байна. Өнөөдөр энийг судалгаа хийсэн. Олон улсын практикт энэ байдаг зүйл. Улсын Их Хурлын гишүүн нийт сонгогчдоо төлөөлж хэнээс ч эмээхгүйгээр, айхгүйгээр, дарамтлуулахгүйгээр шийдвэр, шийдлээ, үг хэлэх ёстой, эрхтэй байх ёстой. Өнөөдөр энэ зүгээр ганцхан энэ Үндсэн хуулийн цэц дээр энэ очоод бас Үндсэн хуулийн цэц энийг хүлээж авсан юм байна лээ шүү. Энийг авч байсан юм байна лээ.

Тэгэхлээр тэр үед бол Гончигдорж гуай бас Улсын Их Хурлын энэ дархан эрхийг хамгаалж ярьж байсан байна. Энэ дээр бол ингэж үгэнд нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 16 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 25 дугаар зүйл, Шүүхийн тухай хуулийн 78 дугаар зүйл болон бусад энэ албан тушаалтнууд ч гэсэн хувь хүнийг нь биш албан тушаалынхаа тэр үг, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг нь хамгаалж энэ хуульд бас шингэсэн байгаа.

Тэгэхлээр өнөөдөр миний хэлэх гээд байгаа зүйл гэвэл та нар нэг юм хар даа Үндсэн хуулийн 29.3-д гишүүн тан.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: 1 минут нэмж тодруулъя.

С.Ганбаатар: Хурал даргалагчид баярлалаа. Үндсэн хуулийн 29.3-д гишүүн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол эгүүлэн татагдах үндэстэй гэж заасан. Гэтэл өнөөдөр өөрийнхөө жишээг яривал эвгүй юм 15 жилийн өмнө удирдаж байсан төрийн байгууллагын тухай асуудлыг ярина гэдэг бол бүх гишүүд өнөөдөр нийнтэгт орох магадлалтай. Өнөөдөр тангаргаасаа няц гэж тангаргаа өргөөгүй байхдаа хийсэн хэрэгт өнөөдөр орж байгаа. Өнөөдөр гишүүн болох гээд бид нар чинь хууль, шүүх, цагдаа, прокуророос баахан тодорхойлолт авдаг. Гишүүн боллоо энэ хүний шийдвэрт нөлөөлөхийн тулд хэрэг үүсгэж дарамталж байгаа явдал бол надаар дуусаасай. Өөр дараагийн энэ залуу хүүхдүүдэд ингэж дарамт битгий очоосой.

Тэгээд энэ дээр хамгийн гол хэлэх гээд байгаа үндэслэл гэвэл Үндсэн хуулийн 29.3 нь Улсын Их Хурлын тухай хуулийн 45.2.2, 45.2.3 дээр хэрэг үүсгээд л дарамтлаад яваад байх боломжийг нь үүсгэчихсэн. Тэрийгээ.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Ганбат: Ер нь энэ парламентын нэр хүнд их сайнгүй байна л даа. Тэгээд үүний цаад талд бол ардчилал бид нарын 35 жилийн өмнө сонгосон энэ сонголт, ард түмэн өнөөдөр 30 хувь нь ядуу байна. Хэдийгээр бид 35 жилийн өмнө энэ парламентын тогтолцоо, энэ ардчилал энэ бүх юмыг сонгосон боловч яагаад вэ гэхээр хулгай, авлига энэ бүх юм бол хэтэрхий их ийм байна. Тэгэхээр дархлагдсан хулгайч гэж ойлголт байдаг бас. Энэ парламентад дархлагдсан хулгайч нар орж ирээд суучихвал энэ парламентын нэр хүнд улам унана. Энэ ардчилалд итгэх итгэл бүр байхгүй болно.

Ийм учраас хамгийн шилдэг, хамгийн хүндтэй, хамгийн нэр сэв цэвэр ийм юмс нь одоо энэ парламентад сууж байх ёстой юм. Ард түмний төлөөлөл болж. Ард түмэн чинь сонгож байгаа шүү дээ. Тийм учраас бас жагсаалтаар ч гишүүд орж ирж байна одоо. Намууд ч цэвэр байх ёстой. Ийм 126 хүн бол өнөөдөр тойргийг төлөөлөөд, намаа төлөөлөөд сууж байна. Бид нар бол шалгуулах ёстой. Яг ард түмэнтэйгээ адилхан. Бид нарын дархан эрх бол иргэдийнхээ төлөө зүтгэх, үг хэлэх, энэ бүх юман дээр л хадгалагдах ёстой шүү дээ. Тэрнээс биш гэмт хэргээ нуун далдлах ийм юмтай байж болохгүй.

Тэгэхээр Ганбаатар гишүүн та өөрөө сая өөрөө хэлчихлээ л дээ намайг шалгаж байгаа гээд. Ингээд та өөрөө ашиг сонирхлын зөрчилтэй болчхож байна. Тийм учраас бас энэ асуудлыг ингэж яриад энийгээ босгоод явалгүй энэ асуудлаа та татаад авчих аа. Энэ парламентыг улам муухай харагдуулаад байна гэж хэлмээр байна. Удахгүй бас ер нь 20 гишүүнийг шалгаад, чөлөөлөөд ингэхэд бол хэрэв намайг шалгая гэвэл би хамгийн түрүүнд очиж шалгуулна. Энэ бүрэн эрхээсээ татгалзаад ёс суртахуунтайгаа харуулна. Гишүүд ч гэсэн ийм байгаасай гэж хүсэж байна. Ийм ч байх ёстой. Ийм соёлыг энэ 126 гишүүнтэй энэ парламент үзүүлээсэй, бий болгоосой, энэний эхлэлийг гишүүд хийгээсэй гэж хүсэж байна. Үнэхээр залуу сайхан гишүүд орж ирсэн гэдэг, өндөр боловсролтой гэж өөрсдийгөө ярьдаг. Ингээд харъя л даа, ард түмэндээ харуулаасай. Би л лав харуулна гэж бодож байгаа. Үлгэр

жишээ үзүүлнэ хэрвээ надтай холбоотой ямар нэгэн асуудал. Тэр хүнтэй ямар нэгэн холбоотой асуудал гарна аа гэдэг чинь тэр хүн өөрөө барьцаанд орж байгаа байхгүй юу. Давхар парламентыг барьцаанд оруулж байгаа, муухай харагдуулж байгаа. Зүгээр л очоод л тэр 3 шатын шүүх нь байна, хууль хяналтын байгууллага нь байна, хууль нь байна, тэр бүх шүүлтүүрээр ороод гараад ирэхэд улам л аятайхан харагдана. Ард иргэд бүгд тэр замаар л явж байна. Тэндээ бид нар итгэдэг, тогтолцоондоо итгэдэг бол эндээ итгэх л хэрэгтэй.

Харин үг хэлэх, хууль боловсруулах энэ бүх юман дээр л бидний дархан эрх байх ёстойгоос энэ Улсын Их Хурал бол энэ маягаараа.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн хариулъя.

С.Ганбаатар: Ганбат гишүүний энэ асуудалд би бас хариулъя. Үндсэндээ эрүүгийн хэрэг үүсгээд амьдралын аль ч үеийн үйлдэлтэй нь холбоод л шалгаад байх энэ тэнэглэлийг зогсооё оо л гэж байгаа юм. Намайг шалгаад үндсэндээ дуусчихсан. Дараа дараагийн тэгээд хэлэх гэж байгаа зүйл гэвэл энэ Үндсэн хуулийн заалт дээр би та нарт уншаад өгье дөө. Үндсэн хуулийн 29.3-д Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцсан бол тэгэхлээр тэр тангараг өргөөгүй байх үеийн асуудлуудаас бултаж зугтах тухай яриагүй шүү дээ. Дараад нь Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг гэж байгаа шүү дээ. Холбогдуулаад, тамлаад, мөрдөөд тэр гаргасан шийдвэрт нь нөлөөлөөд байж болохгүй ээ л гээд байгаа. Мань мэт бол тэртээ тэргүй холбогдуулаад, шалгуулаад, дүгнэлтээ гаргаад ингээд зовоож байгаа. Энэ хамаагүй. Дараа дараагийн залуучуудад холбогдонгуут л Улсын Их Хурлаар хэлэлцүүлдэг байгаач гэж байгаа юм.

Тэгэхгүй өнөөдөр Улсын Их Хурал хов хонзонгийн талбар боллоо. Зүгээр л баахан хов ярьдаг, доромжлол ярьдаг. Ямар ч үндэслэл байхгүй. Энийгээ болиод, Улсын Их Хурал чинь ард түмний итгэл дээр зогсдог. Улсын Их Хурлын гишүүн хулгайч байхыг хамгаалаагүй. Харин бараг би хамгийн зоригтойгоор энэ асуудлыг оруулж ирж байгаа. Энийг оруулж ирэхээр л дархан эрхийн ард хулгайч нуугдах гэж байгаа. Үгүй ээ, дархлагдсан хулгайч нарын эсрэг үг хэлж байгаа дараа дараагийн залуу гишүүдийг яаж хамгаалах вэ тухай ярьж байгаа. Тэртээ тэргүй дархлагдсан хулгайч нар чинь тэр АТГ, прокурор дээрээ зүгээр хангалттай хүмүүсээ тавьчихсан. Тэр хүмүүсийн тухай ярихгүй. Тэр том дээрэмчдийн чинь талаар шинэ залуу гишүүд орж ирээд, үгээ чөлөөтэй хэлэх боломжийг өнөөдөр Үндсэн хуульд заачихсан. 29.3-д.

Харин энийг нь Улсын Их Хурлын тухай хуулийн 45.2.2, 45.2.3-аар мөрдөөд, шалгаад, янаглаад, шийдвэр нь нөлөөлөөд явж болно гэдэг гажуудал үүсчихсэн байна. Энийгээ засаад өгөөч. 4 жилийн ард, энэ суудлын ард нуугд гэж хэлээгүй шүү дээ. Гэмт хэрэгт холбогдонгуут л шууд түдгэлзүүлдэг байя. Түдгэлзсэний дараа, тэр ард түмний сонгосон эрхийг аваад хаячихсаны дараа, тэр хонгилдоно уу, мөрдөнө үү тэр хамаагүй. Тэрийгээ хамгийн түрүүнд хэлчихсэн. Тэгэхгүй ард түмнийг төлөөлөх эрхтэй байхад нь хонгилдоод байна гэдэг бол Улсын Их Хурал одоо миний мэдэхийн надад бичиг өгөхгүй байгаа. 17 гишүүн хууль хяналтын байгууллагаар дарамтлуулж байгаа. Тэдний гаргаж байгаа шийдвэр бол аюултай. Энэ 17-оо 20 болбол, 30 болбол, 50 болбол Улсын Их Хурлын дархан эрхэд халдана. Нөгөө сонгосон ард иргэдийн төлөөллийн эрх алдагдана. Улсын Их Хурал ямар ч утгаа алдана. Энэ эрх мэдэл хуваарилалтын зарчим алдагдана. Ганбат гишүүн дээр

ирээгүй байж болно ийм зовлон. Очоод шарвалзаад байвал яах ч үгүй л дээ. Нохой засуулсан хүндээ янаг гэж үг байдаг юм. Яах ч үгүй таныг.

Тэгэхдээ шударгаар үг хэлээд, шударгаар үнэний төлөө өөрийгөө золиосолж байгаа хүмүүст үг хэлсний төлөө өнөөдөр хэрэг үүсгэж байгаа шүү дээ. Шударга үг хэлсний төлөө өнөөдөр АТГ дээр, прокурор дээр дамжилж байгаа. Энэ улсуудыг хамгаалах гэж парламентын анх энэ үг хэлсний төлөө бурууддаггүй гэдэг энэ зарчим олон улсад байдаг.

Тэгэхээр миний ахан дүүс ээ, надад бол хувь хүнд хамаагүй. Дараа дараагийн парламентад энэ дархлагдсан, парламент өөрөө дархлагдсан хулгайч нарыг нам дарахын тулд шударгаар тэмцэж байгаа жирийн гишүүдийн ард түмнийхээ төлөө төлөөлөх эрхийг нь хангах ёстой гэдэг л ганцхан байр сууриа би илэрхийлж байгаа юм шүү.

Б.Пүрэвдорж: Чуулганы хуралдаан 18 цагт хаах ёстой. Чуулганы хуралдааныг энэ хэлэлцэх асуудал дуусах учраас үргэлжлүүлэн явуулъя.

Санал хураая. Гишүүд дэмжиж байна уу. Дэмжиж байна. Дашдондогийн Ганбат гишүүн нэмж тодруулъя.

Д.Ганбат: Бид нар чинь юу байхгүй юу даа ардчилсан улс орон. Гүйцэтгэх засаглал, хууль тогтоох засаглал, шүүх засаглал гэж байгаа. Тэр шүүх засаглал гэм бурууг тогтооно шүү дээ. Бид нар энэ ойлголт жоохон тааруу байх шиг байна. Зарим нэг гишүүд. Тэр чинь 3 шатын шүүх явж байгаа шүү дээ. Гэм бурууг нь тэнд л тогтооно шүү дээ. Тэнд бол ямар ч хонгил байх ёсгүй. Хонгил байвал бид нар тэрийг байхгүй болгох үүрэгтэй. Иргэдийг ч тэрүүгээр явуулаад байж таарахгүй. Тэгэхээр ийм тогтолцоондоо итгэхгүй байгаа хүмүүс яаж энэ Их Хуралд суух юм бэ, яаж хууль тогтоогоод байж байгаа юм бэ. Ийм ойлголттой байж болохгүй ээ. Бид нар тэрнээс өөр эрх дархтай ингэж байна гэсэн ойлголт байвал та бид хоёрын ойлголт өөр юм байна шүү. Ингэж.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Манай Дашдондогийн Ганбат гишүүн бол бас тодорхой үг хэллээ. Өөрөөр хэлбэл хэрвээ шалгагдах юм бол ажлаа өгч байгаад шалгуулаад явчихна, ард түмнийхээ өмнө хэлж шударга байна, та бол энэ парламентын эр зориг шүү. Ер нь ардчилал, шударга ёс, хувь хүний эрх, эрх чөлөө, чөлөөт зах зээлийн төлөө таны гаргадаг илэрхийлэл бол хамгийн сайн байдаг шүү гэдгийг бас хэлмээр байна.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн өөрөө асуудал оруулсан учраас асуулт асуухгүй. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

О.Цогтгэрэл: Энэ тогтоолын агуулга нь Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байхдаа аливаа гэмт хэрэгт холбогдвол шалгаж болохгүй л гэсэн утга үүний цаана л харагдаад байна л даа. Энийг бас аль ч талаас нь тайлбарлаж болно. Мэдээж парламентын дархлаа гэдэг асуудал яригдах зүй ёсны асуудал. Тэгэхдээ хууль өөрөө тэгш, хууль өөрөө хэлбэрэлтгүй хэрэгжиж байх ёстой гэдэг бас тэр Үндсэн хуулийн үзэл санаа маань хаачих юм бэ. Парламентын гишүүн хүн ерөөсөө ямар ч асуудлаар шалгагдаж болохгүй л гэж л үүний цаана уншигдаад байна. Тэгэхлээр энэ асуудлыг би бас сая анх удаагаа л сонсож байна.

Тэгэхээр Ардчилсан намын бүлэг ирэх Даваа гаргийн хурлаар энэ бүлэг дээр энэ танилцуулга хийлгэж энэ асуудлыг бас сонсож нэлээн нухацтай ярих ёстой. Энэ эрх зүйт ёс, хуульт ёс эрхэмлэдэг Үндсэн хуулийн үзэл санаа бүхий орны хувьд энэ нэлээн нухацтай ярих ёстой асуудал юм байна гэж ойлгож байна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүнийг та бас материал бэлдээд Ардчилсан намын бүлэг дээр 1 дэх өдөр танилцуулга хийгээч гэж бас танаас хүсэж байна. Хурал даргалагчаас Ардчилсан намын бүлгээс энэ асуудлаар 3 хоногийн завсарлага өгөөч гэж байна. Ардчилсан намын бүлэг 3 хоногийн завсарлага авъя.

Б.Пүрэвдорж: Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл завсарлага хүссэн. Ажлын 3 өдрийн завсарлага өглөө.

18.07 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Баталсан тогтоолын эцсийн найруулга сонсох.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль тогтоолын төслийн эцсийн найруулгатай танилцаж, ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу Улсын Их Хурлын тогтоолуудын эцсийн найруулгыг Байнгын хороод бэлтгэж, Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна.

1.“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо./18:08/

2.“Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо./18:09/

Саяын Ганбаатар гишүүний Цэцэд гаргах хүсэлтийг бас тодорхой хугацаатай Дэгийн тухай хуулиар бас хугацаа заасан байна. Яг энэ асуудлыг тодорхой тодруулаадахъя. Наранцогт дарга аа.

Ер нь бол 7 хоногийн дотор хэлэлцээд эхэлчихсэн учраас энэ асуудал бол хэлэлцэгдээд явагдах юм байна. Тийм учраас хууль зөрчихгүй юм байна. Хугацаа шахахгүй юм байна. Тийм учраас 3 өдрийн завсарлага гэдэг чинь ирэх долоо хоногийн 4 дэх өдөр энэ асуудал ороод, хэлэлцэгдээд явах боломжтой. Тэгээд энэ хугацаанд бас та бүлэг дээрээ энэ асуудлыг бас тодорхой хэлэлцэхийг хүсэж байна.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

18.10 цаг.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Э.СУВД-ЭРДЭНЭ